



Үндэсний аудитын газар


ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛЖ, ТАВАНТОЛГОЙН
ОРДЫН ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН 2018-2022 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА БОЛОН ТАВАНТОЛГОЙН ОРД АШИГЛАЛТАД ТӨРӨӨС ЭРДЭС
БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО, АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ
ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

АУДИТЫН КОД: АГГ-2020/12-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.



2023 он

Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын
захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд
Утас: 263755 Цахим хаяг: enkhbold@audit.gov.mn
Аудитын менежер Б.Сапуул
Утас: 261805 Цахим хаяг: saruulb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батдэлгэр
Утас: 261675 Цахим хаяг: batdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор И.Туяадарь
Утас: 261675 Цахим хаяг: tuyadarii@audit.gov.mn
Ахлах аудитор С.Одонцэцэг
Утас: 262451 Цахим хаяг: odontsetsegs@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батчимэг
Утас: 261745 Цахим хаяг: batchimegb@audit.gov.mn
Аудитор М.Доржмаа
Утас: 261456 Цахим хаяг: dorjmaam@audit.gov.mn
Аудитор М.Сангижанцан
Утас: 261745 Цахим хаяг: sangijantsanm@audit.gov.mn
Аудитор И.Дөлгөөнтуул
Утас: 261675 Цахим хаяг: dulguuntuuli@audit.gov.mn
Аудитор Ж.Чинбат
Утас: 261675 Цахим хаяг: chinbatj@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралт ёсоор баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Эдийн засгийн Байнгын хороо, Үйлдвэржилтийн байнгын хороо, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эрдэнэс-Тавантолгой ХК-д тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга /Д.Амарбаясгалан/, Эдийн засаг, хөгжлийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Б.Ганбат/, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Бүрэн эрхт төлөөлөгч /Ж.Ганбат/ нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар /Д.Энхболд/-т даалгасугай.

5. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар /Д.Энхболд/-т даалгасугай.

6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын багт үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

Z:\Tushaal\2023\Tuшаан\EA-Ын А Тушаан\0419 GNAG-1.Docx

0001010326

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	5
Хүснэгтийн товъёг	6
Графикийн товъёг	7
Зургийн товъёг	7
Дүрслэлийн товъёг	7
Хавсралтын товъёг	8
Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа	9
Ерөнхий мэдээлэл	12

БҮЛЭГ 1. ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД АХИЦ ДЭВШИЛ ГАРААГҮЙ НЬ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ, БҮХ ТҮВШИНД ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО СУЛ БАЙГААГААС ШАЛТГААЛЖ БАЙНА

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх суурь болох дэд бүтэц, усны асуудлыг бүрэн шийдвэрлээгүй, хэрэгжилтэд оролцогч талуудын ажлын уялдаа холбоогүй байдлаас шалтгаалж нүүрсний салбарт ахиц дэвшил гараагүй байна

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил нүүрсний салбараас шууд хамааралтай байгаа нь олон тулгуурт эдийн засгийн тогтолцоог бий болгох шаардлагатайг харуулж байна ...

БҮЛЭГ 2.ТАВАНТОЛГОЙН ОРДЫГ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТӨД ҮНДЭСЛЭН ҮР АШИГТАЙ, ЦОГЦ БАЙДЛААР АШИГЛАХГҮЙ БАЙГАА НЬ ОРДЫН ҮНЭ ЦЭНИЙГ БУУРУУЛЖ БАЙНА

Хайгуулын ажлын хоцрогдол Тавантолгойн ордын баттай, бодитой нөөцийг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.....

Техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу хөрсний овоолгыг үүсгээгүйгээс их хэмжээний үргүй зардал гаргах эрсдэлтэй байна

Уурхайд ашиглах усны эх үүсвэрийг шийдвэрлээгүйгээс нүүрсийг сорчлон олборлож байгаа нь ордын үнэ цэнийг бууруулж, насжилтыг богиносгож байна

Уурхайг цогц байдлаар ашиглахад секундэд 328.4 литрийн ундаргатай усны нөөц шаардлагатай байгаагаас 63.5 литр секундийн эх үүсвэрт техник, эдийн засгийн үндэслэл хийсэн нь ордыг сорчилж олборлосон хэвээр байхад хүргэж байна

Ордыг олон тусгай зөвшөөрөлд хувааж ашиглалт явуулж байгаа нь нэг уурхайн хөрсний овоолго нөгөө уурхайн хүрээг дарах, нэг компанийн лицензтэй талбайгаас өөр компани олборлолт явуулах нөхцөлийг үүсгэсэн байна

Цанхийн баруун хэсгийн уулын цулыг хөдөлгөх ажлыг олборлолт, борлуулалтын төлөвлөгөөтэй уялдуулаагүй байна

Цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлээгээс ТЭЗҮ-д тусгасан ашиглалтын системийн дагуу Цанхийн зүүн болон баруун уурхайд олборлолтыг зохих хүчин чадлаар явуулж чадахгүй байна

Эрдэнэс-Тавантолгой ХК ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн талбайн газар эзэмших эрхийг бүрэн аваагүйгээс ашиглалтын лиценз бүхий талбайгаас иргэн, аж ахуй нэгжид эзэмших, ашиглах, өмчлөх хэлбэрээр 4,937.8 га газрыг олгожээ

Хэт олон автомашинаар нүүрсийг тээвэрлэж байгаагаас байгаль орчинд нөлөөлөх эрсдэл нэмэгдэж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна

Эрдэнэс-Тавантолгой ХК болон эрх бүхий байгууллагууд хяналтаа бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажлын үр дүн хангалтгүй байна	37
Хуулийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны хөрөнгийн төвлөрүүлэлт хангалтгүй, буцаан олголтын талаарх эрх зүйн орчин тодорхойгүй байна	40
Компани байгаль орчныг хамгаалах ажлыг төлөвлөсөн хэмжээнд гүйцэтгээгүй, тайлагнал бодитой бус, зарим хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй болжээ	40
Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль, журамд заасны дагуу уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулаагүй, хуримтлалын сангийн тооцооллыг бодитой хийгээгүй байна	42
“Сая тонн-Сая мод” хөтөлбөрийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө, ТЭЗҮ батлагдаагүй, ажлын гүйцэтгэл хангалтгүй, түүнд тавих хяналт сул байна	43
Тусгай зөвшөөрөл шилжүүлэх эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйгээс төлбөл зохих албан татварыг төлөөгүй байна	43
Засгийн газрын эрх мэдлээ хэтрүүлэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бууруулсан байна	44
Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналтын тогтолцоо үгүйлэгдэж байна	45

БҮЛЭГ 3. ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАРЧМААР БУС ТӨРӨӨС ХЭТ ХАМААРАЛТАЙ БАЙГАА НЬ ОРДЫГ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ, ЦОГЦ БАЙДЛААР ҮР АШИГТАЙ АШИГЛАХ БОЛОМЖИЙГ ХЯЗГААРЛАЖ БАЙНА..... 46

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн засаглалыг сайжруулж, үр нөлөөтэй хяналтын тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна	46
Төрийн эрх хэрэгжүүлэгч нь удирдамж өгөх хэлбэрээр компанийн засаглалд оролцож байгаа нь төрийн оролцоог нэмэгдүүлж, “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчмуудыг алдагдуулж байна	48
Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог үр ашигтай зохион байгуулаагүй байна	50
Компанийн дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаа жигдрээгүй, үр дүнд чиглэсэн үйл ажиллагаа явуулаагүй байна	52
Эрдэнэс-Тавантолгой ХК “ам” нөхцөлөөр борлуулалт хийхгүйгээр нүүрсийг баяжуулж, нэмүү өртөг шингээн эцсийн хэрэглэгчид борлуулах стратегийг баримтлах шаардлагатай байна	54
Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн коксжих нүүрсний үнэ зах зээлийн үнийг дагаж өсөж, буурах нөхцөл бүрдээгүй байна	56
Эрдэнэс-Тавантолгой ХК нүүрс борлуулах гэрээ байгуулахдаа урьдчилгаа төлбөрийн хэмжээнээс хамаарсан хөнгөлөлт үзүүлж байгаа нь Ашигт малтмалын тухай хуультай нийцэхгүй байна	57
Эрдэнэс-Тавантолгой ХК Чалко трейдинг хонконг ХХК-д борлуулалтын дундаж үнээс доогуур үнээр борлуулж 306.2 тэрбум төгрөгийн орлого олох боломжийг алдсан байна	59
Нүүрс олборлох нэгжийн өртгийг Цанхийн баруун болон зүүн хэсэгт олборлогч компанитай харилцан адилгүй нөхцөлөөр гэрээ байгуулж зардал хэмнэх боломжийг алдсан байна	60
Компанийн борлуулсан бүтээгдэхүүний нэгжийн үнэ өссөн байна	64
Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2019-2022 оны борлуулалтын 7.2-39.8 хувь нь төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг нүүрсээр барагдуулахад зарцуулагдаж байгаа нь тус компанийг мөнгөн хөрөнгийн дутагдалд оруулах эрсдэлтэй байна	64

Техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу хөрөнгийн болон үйл ажиллагааны урсгал зардлыг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна	66
Худалдан авах ажиллагааг тооцоо судалгаагүйгээр төлөвлөж, гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтын хэрэгжилт хангалтгүй байна	72
Засгийн газрын шийдвэрийн дагуу охин компанийг байгуулсан ч тодорхой үр дүнд хүрээгүй 48.1 тэрбум төгрөгийг үргүй зарцуулсан байна	76
Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 1072 ширхэг хувьцааны нэрлэсэн үнийн тооцооллыг хийгээгүй нь Тавантолгойн бүлэг ордын үнэ цэнийг бууруулж байна	77
Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төрийн мэдлийн ногдол ашиг болох 880.2 тэрбум төгрөг Ирээдүйн өв санд төвлөрөөгүй байна	78
Засгийн газрын тогтоолын дагуу үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлэх хөрөнгийг төлөвлөөгүй байна	80
Бонд гаргах зардалд нийт 8.0 тэрбум төгрөг зарцуулжээ	80
Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн 42.0 хувь нь гэрээт олборлогчдод гэрээгээр гүйцэтгэсэн ажлын төлбөр барагдуулсан байна.....	81
Дүгнэлт	83
Зөвлөмж.....	86
Холбогдох байгууллагын санал	89
ХАВСРАЛТУУД:	97

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны татвар
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБҮТХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
БОНЭЗНУ	Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үнэлгээ
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
БОХТХ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
БУА	Барилга угсралтын ажил
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
МУХБ	Монгол Улсын хөгжлийн банк
МХБ	Мэргэжлийн хяналтын байгууллага
НББОУС	Нягтлан бодох, бүртгэлийн Олон Улсын стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨМӨЗО	Өвөр Монголын өөртөө засах орон
СЯ	Сангийн яам
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
УЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

Хүснэгт 1	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны бүрэлдэхүүн, түүний өөрчлөлт	15
Хүснэгт 2	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт, тэрбум төгрөг	15
Хүснэгт 3	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, төлбөр, сая төгрөг	16
Хүснэгт 4	Монгол Улсын 2018-2022 оны нүүрсний экспорт, БНХАУ-ын импортын мэдээ, тонноор	20
Хүснэгт 5	Тавантолгойн орд газарт хайгуулдсан өрмийн торын нягтрал, метр	25
Хүснэгт 6	Геологи хайгуулын ажлын 2018-2022 оны хэмжээ болон зардлын мэдээлэл	26
Хүснэгт 7	ТЭЗҮ-д тусгасан нүүрс олборлох ажлын 2018-2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	28
Хүснэгт 8	Цанхийн баруун уурхайн ТЭЗҮ-д тусгасан уулын цул хөдөлгөх ажлын 2018-2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	33
Хүснэгт 9	Лабораторид шинжлүүлсэн шинжилгээний тоо, сая төгрөг	34
Хүснэгт 10	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээлэл	35
Хүснэгт 11	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан хэрэгжилт бүрэн хангагдаагүй ажил болон өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдал	38
Хүснэгт 12	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 2018-2022 онд байршуулсан барьцаа хөрөнгийн мэдээлэл, сая төгрөг	40
Хүснэгт 13	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны байгаль орчныг хамгаалах зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг, хувь	41
Хүснэгт 14	Ногдуулсан болон жишиг үнээр тооцсон АМНАТ-ын зөрүүгийн тооцоо	44
Хүснэгт 15	Эрдэнэс-Тавантолгой ХК-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь, тэрбум төгрөг	48
Хүснэгт 16	ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалин, сая төгрөг	49
Хүснэгт 17	Уурхайд ажиллаж буй нийт ажилтны тоо	51
Хүснэгт 18	Уурхайн ам нөхцөлөөр коксжих нүүрсний борлуулах үнэ болон борлуулсан үнийн зөрүү, ам.доллар	54
Хүснэгт 19	Төлбөрөө урьдчилж төлсөн борлуулалтын гэрээний өглөг, тэрбум төгрөг	57
Хүснэгт 20	Урт хугацааны гэрээтэй коксжих нүүрс худалдан авагчийн гэрээний үнийг индексжүүлсэн болон урьдчилгаа төлбөрийн хэмжээнээс хамаарч үзүүлсэн үнийн хөнгөлөлт	58
Хүснэгт 21	Гэрээт олборлогчдын уулын ажлыг гүйцэтгэлийн төлбөрийг барагдуулахад үзүүлсэн хөнгөлөлт	58
Хүснэгт 22	Чалко Трэйдинг Хонгконг компанийн борлуулалт, түүний тооцсон өгөөж, сая ам.доллар	60
Хүснэгт 23	Цанхийн зүүн болон уурхайн өртөг, төгрөг	60
Хүснэгт 24	Гэрээт олборлогчийн гэрээний үнээрх хөрс хуулалт, олборлолтын үнэ	62
Хүснэгт 25	Цанхийн зүүн уурхайн олборлолтыг Цанхийн баруун уурхайн үнээр тооцсон байдал	62
Хүснэгт 26	Цанхийн зүүн, баруун уурхайгаас ачсан нүүрсний нийт хэмжээ, ачилтын зардал	63
Хүснэгт 27	Эрчим хүчний нүүрсний өртгийн харьцуулалт	64
Хүснэгт 28	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн борлуулалтын мэдээ	64
Хүснэгт 29	Гэрээний төлбөрийг нүүрсээр барагдуулсан тоо хэмжээ, үнийн дүн	65
Хүснэгт 30	Төлбөрийг нүүрсээр барагдуулах гэрээний төлбөрийн үлдэгдэл	66
Хүснэгт 31	ТЭЗҮ-д заасан хөрөнгө оруулалт	68
Хүснэгт 32	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн зардлаар гадаад томилолтоор ажилласан байдал	71
Хүснэгт 33	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, тэрбум төгрөг, хувь	72
Хүснэгт 34	Авто ачигч худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байдал	73
Хүснэгт 35	Төрийн мэдлийн хувьцааны ногдол ашгийн зарцуулалт, тэрбум төгрөг	78
Хүснэгт 36	Ногдол ашиг хуваарилах тооцоо, төгрөг	79
Хүснэгт 37	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн бондоор татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг зарцуулах төлөвлөгөө, тэрбум төгрөг, хувь	80
Хүснэгт 39	Үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн	81

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хүснэгт 40	Үнэт цаасны арилжаанд төлсөн шимтгэл, зөвлөх үйлчилгээний төлбөр, сая төгрөг	81
Хүснэгт 41	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөг	81

ГРАФИКИЙН ТОВЬЁГ

График 1	Монгол Улсын 2015-2022 онд экспортолсон нийт нүүрсний хэмжээ, борлуулалтын дүн	14
График 2	БНХАУ-руу 2015-2022 онд экспортолсон коксжих нүүрсний хэмжээ, нийлүүлэгч орноор харьцуулсан байдал	14
График 3	ДНБ-д уул уурхайн олборлолтын салбарын эзлэх хувь	22
График 4	Монгол Улсын нүүрсний экспортод Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эзлэх хувь	22
График 5	Нүүрсний экспортын Олон улсын зах зээлийн үнэ	23
График 6	Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээнд уул уурхайн орлогын эзлэх хувь	23
График 7	Уул уурхай, олборлолтын салбарт ажил эрхлэлтийн байдал	23
График 8	Монгол улсын ядуурлын түвшин, хувь	23
График 9	ДНБ-ий өсөлт, оны үнээр	24
График 10	Цанхийн зүүн болон баруун уурхайгаас 2018-2022 онд олборлосон нийт нүүрсийг давхарга тус бүрээр харьцуулсан байдал, сая тонн, эзлэх хувь	29
График 11	Цанхийн баруун уурхайн ТЭЗҮ-ийн олборлолтын дундаж үзүүлэлт	31
График 12	Цанхийн зүүн уурхайн ТЭЗҮ-ийн олборлолтын дундаж үзүүлэлт	31
График 13	Нүүрс тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн тоо болон бүтээмж	36
График 14	Коксжих нүүрсний Ганцмод боомтын үнэ болон борлуулалтын гэрээний үнийн харьцуулалт	56
График 15	БНХАУ-ын импортолсон нүүрсний тоо хэмжээ, үнийн харьцуулсан мэдээлэл (2019 он)	57
График 16	Чалко трейдинг хонконг ХХК болон бусад компанид борлуулсан коксжих нүүрсний үнэ, ам.доллар	59
График 17	Цанхийн зүүн хэсгийн коксжих нүүрсний өртгийн бүтэц	61
График 18	Цанхийн баруун хэсгийн коксжих нүүрсний өртгийн бүтэц	61
График 19	Цанхийн зүүн хэсгийн исэлдсэн нүүрсний өртгийн бүтэц	61
График 20	Цанхийн баруун хэсгийн исэлдсэн нүүрсний өртгийн бүтэц	61
График 21	Эрчим хүчний нүүрсний үнэ өртгийн харьцуулалт, ам.доллар	64

ЗУРГИЙН ТОВЬЁГ

Зураг 1	Тавантолгойн орд газарт хайгуулдсан өрмийн цооногийн байршлын мэдээлэл	25
Зураг 2а	Цанхийн зүүн уурхайн анхны ТЭЗҮ-ээр төлөвлөлт-2011 он, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх уурхайн босоо зүсэлт	29
Зураг 2б	Цанхийн зүүн уурхайн ТЭЗҮ-ээр төлөвлөлт 2021 он, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх уурхайн босоо зүсэлт	30
Зураг 3а	Цанхийн баруун уурхайн ТЭЗҮ-ээрх төлөвлөлт-2012 он, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх уурхайн босоо зүсэлт	30
Зураг 3б	Цанхийн баруун уурхайн ТЭЗҮ-ээрх төлөвлөлт-2021 он, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх уурхайн босоо зүсэлт	30
Зураг 4	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд эзэмших, ашиглах, өмчлөх байдлаар олгосон газар олголтын байдал	36
Зураг 5	Компанийн дотоод хяналтын нэгжийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт	53
Зураг 6	1500 м.куб усан сангийн барилга угсралтын ажлын явц	75

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

Дүрслэл 1	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилтууд	17
Дүрслэл 2	Уул уурхайн салбарын бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцооны өнөөгийн процессын зураглал	19
Дүрслэл 3	Компанийн засаглалын загвар	46
Дүрслэл 4	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн засаглалын одоогийн загвар	47

ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ

Хавсралт 1	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайн байршлын тойм зураг	97
Хавсралт 2	Хөрс тээвэрлэх зайг харьцуулсан байдал	98
Хавсралт 3	Тавантолгойн бүлэг ордын ойролцоо орших усны ундаргын байршил	99
Хавсралт 4	ТЭЗҮ-ээр төлөвлөсөн уурхайн хүрээг одоо үүсээд байгаа уурхайн хүрээ болон овоолготой харьцуулсан зураг	100
Хавсралт 5	ТЭЗҮ-ээр төлөвлөсөн уурхайн хүрээ рүү 400-450 метрээр цөмөрч орон “0”, “III”-ын давхаргын нүүрсийг дарсан овоолгын зураг	101
Хавсралт 6	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ашиглалтын лицензтэй талбайд иргэн, хуулийн этгээдэд эзэмших, өмчлөх, ашиглах хэлбэрээр олгосон газрын мэдээлэл	102
Хавсралт 7	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүчин чадал, санхүүжилтийн судалгаа, тэрбум төгрөг	103
Хавсралт 8	Борлуулалтын гүйцэтгэлийн тайлангаарх борлуулсан нүүрсний тоо хэмжээг уулын ажлын тайлантай харьцуулсан байдал	105
Хавсралт 9	Гэрээт олборлогч компанийн төлбөрт 2021-2022 онд өгсөн нүүрсний тоо хэмжээ, үнийн дүн	106
Хавсралт 10	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Цанхийн зүүн уурхайн 2018-2022 оны уулын ажлын төлөвлөгөө, тайлан	105
Хавсралт 11	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Цанхийн баруун уурхайн 2018-2022 оны уулын ажлын төлөвлөгөө, тайлан	107

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХУГАЦАА

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэл, 2023 оны 09 дүгээр тогтоол, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 4/233 дугаар албан бичиг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/53, 2021 оны А/28, 2022 оны А/12, 2023 оны А/04 дүгээр тушаалуудаар баталсан Үндэсний аудитын газрын гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөг үндэслэн Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Энэхүү аудитыг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэх зорилтод тулгуурлан хийв. Үүнд:

- ✓ Тавантолгойн орд ашиглалтад Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого болон Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт үр нөлөөтэй байгаа эсэх;
- ✓ Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх.

Аудитад Тавантолгойн орд газрын ТЭЗҮ, хувьцаат болон охин компанийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, аудит хийсэн санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, борлуулалтын гэрээ, орлого, зарлагын мэдээлэл, төсөл, хөтөлбөрийн гэрээ, ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн баримт болон бусад холбогдох баримт материалд үндэслэн ЗГХЭГ, УУХҮЯ, Сангийн яам, БОАЖЯ, АМГТГ, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Орон нутгийн засаг, захиргааны нэгж болон бусад холбогдох байгууллагын 2018-2022 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн гаргасан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүй, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалд заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах зэргээр нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглан гүйцэтгэлийн аудитын шалгуур үзүүлэлт болох арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг баримтлалаа. Үүнд:

- НҮБ-аас 2015 онд баталсан “Тогтвортой хөгжил-2030” зорилтууд;
- Ашигт малтмалын тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Гаалийн тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Газрын хэвлийн тухай хууль;
- Хөрөнгө оруулалтын тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Усны тухай хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- УИХ-ын 2007 оны “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27 дугаар тогтоол;
- УИХ-ын 2008 оны “Стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн нүүрсний ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим батлах тухай” 40 дүгээр тогтоол;
- УИХ-ын 2010 оны “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” 39 дүгээр тогтоол;
- УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” (хүчингүй болсон);
- УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (хүчингүй болсон);
- УИХ-ын 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол;
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Засгийн газрын 2018 оны “Багануур, Шивээ-Овоо ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 132 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2018 оны “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай” 242 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2018 оны “Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 245 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2019 оны “Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 296 дугаар тогтоол (хүчингүй болсон);
- Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл шахмал түлшний үйлдвэрлэлийн талаар;
- Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн “Эрдэнэс Монгол ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 367 дугаар тогтоол;
- Бусад холбогдох журам, аргачлал, стандартууд.

Аудитын баг, бүрэлдэхүүн

Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Саруул хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батдэлгэр, И.Туяадарь, С.Одонцэцэг, Б.Батчимэг, аудитор И.Дөлгөөнтуул, М.Сангигжанцан, М.Доржмаа, Ж.Чинбат, шинжээч Д.Даваасамбуу, А.Алтангэрэл, Г.Буянбат нар гүйцэтгэв.

Аудитын эхний үе шатыг 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хэрэгжүүлж, тайлангийн төслийг МУЕА-т танилцуулж, Төсвийн байнгын хорооны 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэл, аудитын сэдвийн төлөвлөгөөг үндэслэн нэмэлт горим гүйцэтгэх аудитын нэмэлт төлөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр батлуулсан.

Аудитын нэмэлт горимыг хэрэгжүүлэх үе шатны ажлыг 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд гүйцэтгэсэн бөгөөд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Аудитын шалгалт хийлгүүлэх тухай” н/300 дугаар албан бичиг, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 09 дүгээр тогтоол болон Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01/2214 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн аудитад компанийн 2022 оны үйл ажиллагааг хамруулахаар аудитын нэмэлт төлөвлөгөөг 2023 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр батлуулж, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэн, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ, судалгааг МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журмын 3 дугаар хавсралт маягтын дагуу бэлтгэж, ажлын баримт материалд хавсаргав.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль, эрх зүй, Төрөөс баримталж буй бодлогын талаар:



Монгол Улсын урт хугацааны бодлого болох “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д (хүчингүй болсон) ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээр тусгаж, 2020 он гэхэд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулахаар тус тус заажээ.

Шинээр баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа-2050”-д 2021-2030 оныг эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе хэмээн нэрлэж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн салбарыг байгальд ээлтэй, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөх;
- Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байх зарчмаар хөгжүүлж, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжих;
- Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн нүүрс угаах үйлдвэр, нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн паркийг тус тус барьж байгуулахаар зааж, говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулахаар тусгасан байна.

Харин дунд хугацаанд АМТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1¹ дэх заалтыг үндэслэн УИХ-аас 2014 онд “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг (УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болсон²) баталж, хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангах зорилт тавьж хэрэгжүүлэхээр заасан байна.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогод 59 зорилт, арга хэмжээг тусгасан бөгөөд Нүүрсний салбарт хамааралтай 41 зорилтыг хэрэгжүүлэхээр заажээ. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилго нь хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацыг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг бусад салбарын бодлоготой харилцан уялдаатай хөгжүүлэхээр тодорхойлсон байна.

¹ Геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

² Аудитын хамрах хугацаанд уг бодлого хүчинтэй байсан тул тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг аудитад авч үзнэ.

Энэхүү бодлогын баримт бичиг нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим, хөгжлийн хандлагыг тодорхойлж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэх бөгөөд тэдгээр чиглэлийг эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дунд, урт хугацааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, төсөлд тусган хэрэгжүүлэхээр заажээ.

Тавантолгойн ордын талаар:



Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций суманд оршдог Цанхи, Бортээг, Оорцог, Ончхараат, Бортолгой, Ухаахудаг гэсэн 6 үндсэн хэсгээс бүрдэх 2-30 метр зузаан 16 давхраастай 71,708.6 га ашиглалтын талбайг эзэлсэн эрчим хүчний болон коксжих чулуун нүүрсний орд юм.

УИХ-ын 2007 оны “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27 дугаар тогтоолоор Тавантолгойн ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулжээ.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эзэмшлийн 8 тусгай зөвшөөрлийн ашиглалтын талбай нийт ордын талбайн 95.4 хувийг буюу 68,471.4 га талбайг эзэлж байна. (Зургийг хавсралт 1-ээс харна уу)

АМГТГ-ын даргын 2019 оны “Нөөцийг хүлээн авах, бүртгэх тухай” Н/26 дугаар тушаалаар тус ордын нөөцийн шинэчилсэн тооцооны нэгтгэлийг хүлээн авч ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд цэвэр нүүрсийг 2,614.9 сая тонн коксжих, 1,405.5 сая тонн эрчим хүчний, нийт 4,020.4 сая, чулууны үетэй нүүрсийг 2,988.9 сая тонн коксжих, 1,528.0 сая тонн эрчим хүчний, нийт 4,516.9 сая тонноор бүртгэсэн байна.

Гадаад зах зээлийн талаар:



Дэлхийн гангийн холбооны мэдээллээр 2019 онд БНХАУ-ын коксжих нүүрсний хэрэглээ 5.2 хувиар буюу 546.7 сая тонн, коксжих нүүрсний импорт 14.4 хувиар буюу 74.7 сая тонн болж тус тус нэмэгдсэн нь түүхий гангийн үйлдвэрлэл өмнөх оноос 8.3 хувиар өсөж, 996.3 сая тонн-д хүрсэнтэй холбоотой байна.

Харин 2021 онд БНХАУ-ын коксжих нүүрсний хэрэглээ 545.4 сая тонн болж, өмнөх оноос 2.2 хувиар буурсан нь түүхий гангийн үйлдвэрлэл тус онд 3.0 хувиар буурч, 1033.0 сая тонн болсонтой холбоотой байна. Гангийн үйлдвэрлэл 2022 оноос нэмэгдэж, БНХАУ-ын нүүрсний импорт өмнөх оноос 16.9 хувиар өссөн байна.

БНХАУ-д 2020 оныг хүртэл нүүрс экспортлогч орнуудаас Монгол Улс болон Австрали улсууд 60 орчим хувийг нийлүүлдэг байсан ч 2021 оноос эхлэн ОХУ, АНУ, Канад Улсууд нийлээд 33.3-55.0 хувийг нийлүүлсэн нь өрсөлдөөн нэмэгдэж байгааг харуулж байна.

Монгол Улс 2019 онд БНХАУ-д 33.8 сая тонн коксжих нүүрс экспортолж, нийт импортын 45.2 хувийг эзэлсэн хамгийн том нийлүүлэгч байсан бол 2022 онд 25.6 сая тонныг нийлүүлж, нийт импортын 40.1 хувийг эзэлж байна.

График 1. Монгол Улсын 2015-2022 онд экспортолсон нийт нүүрсний хэмжээ, борлуулалтын дүн





График 2. БНХАУ-руу 2015-2022 онд экспортолсон коксжих нүүрсний хэмжээ, нийлүүлэгч орноор харьцуулсан байдал



Эх сурвалж: YCG

Эх сурвалж: www.sxcoal.com

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн үйл ажиллагааны талаар:




УИХ-ын 2010 оны 39, Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийг Эрдэнэс МГЛ ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулж, Төрийн өмчийн хорооны (хуучин нэрээр) 2010 оны 425 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дүрмийг баталсан байна.

УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийг бие даасан компани болгож, Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Эрдэнэс Монгол ХХК-аас шилжүүлж, УУХҮЯ 70 хувь, ТӨБЗГ 30 хувь тус тус хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Эрдэнэс Монгол ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 367 дугаар тогтоолоор төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Эрдэнэс Монгол ХХК-д буцаан шилжүүлсэн байна.

Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах зорилгоор компанийн үндсэн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, төлбөр тооцоог сайжруулж, орлогыг нэмэгдүүлэх асуудлыг шууд хариуцан гүйцэтгэж, компанийг бүрэн төлөөлөх эрх бүхий Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчөөр Сангийн яамны ТНБД Ж.Ганбатыг 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс томилон ажиллуулж байна.



Тус компанийн ТУЗ 10 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас 7 нь төрийг төлөөлж, 3 нь хараат бус гишүүн байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хүснэгт 1. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны бүрэлдэхүүн, түүний өөрчлөлтийг харуулбал,

№	ТУЗ-д хамаарах албан тушаал	Овог нэр	Эрхэлж байсан албан тушаал	Томилсон		Чөлөөлсөн	
				ТУЗ-ийн тогтоолын дугаар	Огноо	ТУЗ-ийн тогтоолын дугаар	Огноо
1	Дарга	Дааданхүүгийн БАТБААТАР	ЗГХЭГ-ын дэд дарга	2	2022.01.31	40	2022.11.04
2	Дарга	Бямбажавын ГАНБАТ	ЗГХЭГ-ын дэд дарга	41	2022.11.04		
3	Гишүүн	Баттулгын ГАНХУЯГ	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Гүйцэтгэх захирал			40	2022.11.04
4	Гишүүн	Жигжидийн ГАНБАТ	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга				
5	Гишүүн	Болдын УЯНГА	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын дарга			40	2022.11.04
6	Гишүүн	Самданямын МӨНХЧУЛУУН	ШӨХТГ-ын дарга				
7	Гишүүн	Чулуунбаатарын ЭНХ-АМГАЛАН	Эрдэнэс Монгол ХХК-ийн Худалдан авалтын хэлтсийн дарга				
8	Гишүүн	Доржийн БАЯРБАТ	Эрдэнэс Монгол ХХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын захирал				
9	Гишүүн	Баяраагийн БЯМБАДАГВА		40	2022.11.04		
10	Гишүүн	Ханджавын БАТЖАРГАЛ		40	2022.11.04		
11	Хараат бус гишүүн	Жамъяндоржийн ЧИМЭДЦЭРЭН	Хувиараа				
12	Хараат бус гишүүн	Баярсайханы МӨНХЗАЯА	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн Захиргаа удирдлагын албаны дарга				
13	Хараат бус гишүүн	Энхтуяагийн ТЭМҮҮЛЭН	Wintech ХХК-ийн гүйцэтгэх захирал				
14	Хараат бус гишүүн	Хаянгаагийн БОЛОР-ЭРДЭНЭ	Дорнод газар ХХК-ийн гүйцэтгэх захирал				

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн тогтоол

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эзэмшлийн MV-011943, MV-016883, MV-0168818, MV-016882, MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956 дугаартай 8 тусгай зөвшөөрлөөс 2019 онд MV-011943 дугаар тусгай зөвшөөрлийг Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-д шилжүүлсэн бөгөөд уг компани 2020 онд татан буугдсанаар буцаасан байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК 2019 онд нийт 822 үндсэн ажилтан, мөн хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан 71 ажилтантай үйл ажиллагаа явуулж байсан бол 2022 онд нийт 1026 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Мөнгөн хөрөнгө	605.3	656.4	134.6	49.2	385.3
Авлага	50.1	250.3	34.2	22.4	35.2
Урьдчилгаа	8.7	12.4	898.6	1,613.4	1,711.2
Бараа материал	104.1	105.5	129.7	263.8	393.8
БЗЭБЭБХ (борлуулах бүлэг хөрөнгө)	0.4	0.4	0.4	-	-

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Бусад санхүүгийн хөрөнгө	15.3	15.3			-
Эргэлтийн хөрөнгийн дүн	783.9	1,040.3	1,197.5	1,948.8	2,525.6
Үндсэн хөрөнгө	31.6	37.4	46.9	111.0	232.7
Биет бус хөрөнгө	11,184.6	11,159.4	11,138.8	11,126.4	11,108.0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.5	312.2	309.3	308.6	1,346.8
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	10.7	13.8	15.9	16.4	18.5
Хойшлогдсон татварын хөрөнгө	0.1	23.3	41.8	116.3	117.6
Бусад эргэлтийн бус хөрөнгө	313.2	798.8	1,384.9	1,690.2	2,131.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,540.7	12,344.9	12,937.6	13,368.9	14,954.8
Нийт хөрөнгийн дүн	12,324.6	13,385.2	14,135.1	15,317.7	17,480.4
Богино хугацаат өглөг	285.2	311.9	1,115.1	523.0	1,077.7
Урьдчилж орсон орлого				892.9	1,445.6
Урт хугацаат өглөг	35.6	43.4	925.7	1,645.0	1,403.0
Эздийн өмч	12,003.8	13,029.9	12,094.3	12,256.8	13,554.1
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	12,324.6	13,385.2	14,135.1	15,317.7	17,480.4

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны санхүүгийн тайлан

Эрдэнэс-Тавантолгой ХК 2018 онд 13.1 сая тонн нүүрс борлуулж 1,990.0 тэрбум, 2019 онд 15.5 сая тонн нүүрс борлуулж 2,660.0 тэрбум, 2020 онд 11.9 сая тонн нүүрс борлуулж 1,547.7 тэрбум, 2021 онд 6.2 сая тонн нүүрс борлуулж 1,126.8 тэрбум, 2022 онд 11.5 сая тонн нүүрс борлуулж 3,494.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 2018-2022 онд нийт 6,930.7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллан улс, орон нутгийн төсөвт 2,749.8 тэрбум төгрөгийн татвар, хураамж, төлбөрийн орлого төвлөрүүлсэн байна.

Дэлхий нийтэд шинэ төрлийн коронавируст халдвар тархаж, Гашуунсухайт хилийн боомтын үйл ажиллагааг хязгаарласнаар 2020-2022 онд 701 өдөр нүүрсний экспорт саатсан байна. Энэ нь Монгол Улсад орох валютын урсгал, компанийн борлуулалтад сөрөг нөлөө үзүүлж мөнгөн хөрөнгийн дутагдалд оруулжээ.

Хүснэгт 3. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, төлбөр, сая төгрөг

Төсвийн ангилал		2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	Нийт
Улсын төсөв	Ногдуулсан	468,389.8	719,432.2	416,641.6	337,056.8	1,250,601.7	3,192,122.2
	Төлсөн	388,238.0	677,935.4	445,237.3	200,091.3	985,118.1	2,696,620.1
Орон нутгийн төсөв	Ногдуулсан	3,728.2	5,770.5	23,546.0	8,368.5	10,800.2	52,213.5
	Төлсөн	3,753.9	5,846.0	26,277.1	6,857.5	10,461.7	53,196.2
Нийт	Ногдуулсан	472,118.0	725,202.7	440,187.7	345,425.3	1,261,401.9	3,244,335.6
	Төлсөн	391,991.9	683,781.4	471,514.4	206,948.8	995,579.8	2,749,816.3

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, ТЕГ-ын Том татвар төлөгчийн газар

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нийт хувьцааны 85.19 хувийг төр, 0.06 хувийг аж ахуйн нэгж, 14.75 хувийг иргэд эзэмшиж байгаа бөгөөд иргэдийн хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор уулзалт, сургалт зохион байгуулан иргэдээс судалгаа авч, хувьцааны баримтыг цахимжуулж, 2019 оны ашгаас иргэдийн 1072 ширхэг хувьцаанд ногдол ашиг хуваарилахаар ТУЗ-өөс шийдвэрлэж, нэгж үнийг 90 төгрөгөөр тооцож ногдол ашиг тараасан байна. Харин 2020, 2021 онд ногдол ашиг олгоогүй байна.

БҮЛЭГ 1. ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД АХИЦ ДЭВШИЛ ГАРААГҮЙ НЬ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ, БҮХ ТҮВШИНД ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО СУЛ БАЙГААГААС ШАЛТГААЛЖ БАЙНА

1.1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (хуучин нэрээр)-ийн 6 дугаар зүйлд заасан урт хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг болох УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг болох УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”³-д эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Дүрслэл 1. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилтууд

3.1.Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд:

- 4.3.9.эрдэс баялгийн салбарын бүх шатны үйл ажиллагаа нь хууль, журмын дагуу явагдаж олон нийтэд нээлттэй, ил тод байж, шинээр хууль тогтоомж, журам боловсруулах, томоохон хэмжээний төсөл хэрэгжүүлэхэд олон нийтийн саналыг хүлээн авч, шийдвэр гаргахад тусгаж байх эрх зүйн орчин бүрдсэн байх;

3.2.Геологийн салбарын хүрээнд:

- 4.3.1.геологийн судалгаа, хайгуулын ажлыг төрийн бодлогын дагуу гүйцэтгэж, улсын эрдэс баялгийн нөөцийг өсгөж, уул уурхайн салбарын урт хугацааны тогтвортой хөгжлийн суурийг бүрдүүлэх;
- 4.3.2.эрдэс баялгийн нөөцийг иж бүрэн зохистой түвшинд олборлож, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай технологи ашиглаж, боловсруулалтын түвшинг ахиулснаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрөл нэмэгдэх;

3.3.Олборлох салбарын хүрээнд:

- 4.3.3.олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаанд нэгдсэн стандартыг мөрдүүлж, үйлдвэрлэлийн бүх дамжлага, шатанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлснээр үйлдвэрлэлийн осол буурах;
- 4.3.4.уул уурхайн төслийг дагаад дэд бүтцийн хөгжлийн (замын сүлжээ, цахилгаан станц, хот, суурин газар) төлөв тодорхой болж, урт хугацааны төлөвлөлт хийх боломжтой болох;

3.4.Боловсруулах салбарын хүрээнд:

- 4.3.5.томоохон хэмжээний үйлдвэрлэлийн төвүүд бий болсноор хүн амын хэт төвлөрөл саарах;
- 4.3.10.өнөөгийн эрдэс баялгийн салбарт бизнесийн таатай орчин бүрдэн, эрдэс баялгийн бирж дээр эрдсийн бүтээгдэхүүний арилжаа нээлттэй, олон улсын жишгийн дагуу явагдах орчин бүрдэх;

3.5.Орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд:

- Хүрэх үр дүнг тодорхойлоогүй.

3.6.Байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээнд:

- 4.3.7.байгаль орчныг хамгаалах, уурхайг хаах, нөхөн сэргээх, урт хугацааны мониторинг хийх үйл ажиллагаа нь хууль тогтоомж, олон улсын стандартын дагуу цэгцтэй, дэс дараалалтай, хариуцлагатай болох;
- 4.3.8.экологийн тэнцвэрт байдлыг хангах, эрүүл, эко-хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор гол, мөрний урсац бүрэлдэх эх, ай сав, ойн бүс, тариалангийн талбай, шимт бэлчээр, говийн баянбүрд, нуур, цөөрмийн орчимд олборлолт, боловсруулалтын үйл ажиллагааг хязгаарлаж, иргэдийн эрүүл хүнс хэрэглэж, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;

3.7.Эрдэс баялгийн салбарын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн хүрээнд:

- 4.3.6.эрдэс баялгийн болон дэд бүтцийн салбарын мэргэжлийн хүний нөөц бэлтгэгдэж, үндэсний мэргэжилтэй ажиллагсдын тоо, ажлын байр нэмэгдэж, ажилгүйдэл буурах;

Эх сурвалж: Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого

1.2. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэт ерөнхий агуулгаар баталж, ашигт малтмалын нэр төрөл тус бүрээр баримтлах бодлогыг нарийвчлан тодорхойлоогүй, бодлогын баримт бичгийг дагалдан гарах богино хугацааны бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх дарааллаар эрэмбэлээгүй, бодлогын шийдвэрийг хэрхэн гаргах талаар дэлгэрэнгүй тусгаагүй байна.

³ Энэхүү бодлого нь УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болсон. Аудитын шалгах хугацаанд уг бодлого хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан учир тус бодлогын хэрэгжилтийг авч үзсэн болно.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх суурь болох дэд бүтэц, усны асуудлыг бүрэн шийдвэрлээгүй, хэрэгжилтэд оролцогч талуудын ажлын уялдаа холбоогүй байдлаас шалтгаалж нүүрсний салбарт ахиц дэвшил гараагүй байна

1.3. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилтуудын хэрэгжилт нүүрсний салбарт, тэр дундаа Тавантолгойн бүлэг ордыг эзэмшиж буй Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой ХК (орон нутгийн)-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд хангалтгүй, үр дүн гараагүй байна. Тухайлбал,


- Ордыг нэгдмэл байдлаар ашиглах;
- Олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Боловсруулах салбарыг хөгжүүлэхдээ зах зээл дэх өрсөлдөх чадвар, үйлдвэрлэлд зарцуулах **усны хэрэглээ** болон үйлдвэрлэлээс гарах хорт хаягдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэрэг хүчин зүйлсийг **цогцоор** нь судалж, шийдвэр гаргах;
- Боловсруулах салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг бодлогоор дэмжих;
- Нүүрс баяжуулах, кокс, химийн үйлдвэр байгуулах нүүрсний ордод түшиглэсэн цахилгаан станц барих төслийг дэмжих;
- Олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэрт байдлыг хангасан байх;
- Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах боломжийг бүрдүүлэх, эрдэс баялгийн салбараас орох орлогыг нэмэгдүүлэх зэрэг зорилтын хэрэгжилт хангалтгүй байна.

1.4. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилтуудын хэрэгжилт хангалтгүй, олборлох, боловсруулах салбарын дэд бүтцийн суурь болсон усны эрэл хайгуул, ашиглалтын асуудал, цахилгааны эх үүсвэр, тээврийн дэд бүтцийг шийдвэрлээгүй хугацаа алдсан зэрэг нь энэхүү бодлогын хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан болжээ.

1.5. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ТЭЗҮ-д туссан төсөл, хөтөлбөрүүд (цахилгаан станц барих, техник, тоног төхөөрөмжтэй болох) төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, нэн тэргүүнд шаардлагатай усны эх үүсвэрийг бүрэн шийдвэрлээгүй, үр ашиггүй зардал гаргах эрсдэл нэмэгдсэн, ордыг нэгдмэл, цогц байдлаар ашиглаагүй нь засаглалын хувьд төрөөс хэт хамааралтай, компанийн орлого, ашгийг төлөвлөсөн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайжруулахад бус Төрийн шийдвэрээр нийгмийн асуудалд зарцуулсан нь компанийг нээлттэй хувьцаат компани болгож, үр нөлөөтэй хяналтын тогтолцоо бүрдүүлээгүй зэргээс шалтгаалсан байна.

1.6. АДБОУБ-ын дэргэдэх Олон Улсын Хөгжлийн агентлагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтэд аудит хийх удирдамжид заасан “Үндэсний зорилтуудын биелэлтийг хангахад чиглэсэн багц бодлогын хэрэгжилтийг үнэлэх загвар”-ын дагуу уул уурхайн салбарын бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцооны уялдаа холбооны зураглал хийж үзэхэд бодлогыг хэрэгжүүлэх тогтолцооны уялдаа холбоо алдагдсан, хоорондын хамаарал бүрэн хангагдаагүй байна.

Дүрслэл 2. Уул уурхайн салбарын бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцооны одоогийн процессын зураглал



Тайлбар:
■ - ханагдсан
■ - сайжруулах шаардлагатай
■ - хангагдаагүй

Эх сурвалж: Аудитын тооцоолол

1.7. Тухайлбал, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018, 2019 онд борлуулсан коксжих нүүрсний үнийг Тавантолгой ХК (орон нутгийн)-ийн борлуулсан коксжих нүүрсний үнэтэй харьцуулахад Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн борлуулалтын үнэ тонн тутамд 2.93-14.99 ам.доллаароор илүү байна.

1.8. Тавантолгойн бүлэг ордод үйл ажиллагаа явуулж буй хоёр компанийн бүтээгдэхүүн борлуулсан үнэ харилцан адилгүй байгаа нь БНХАУ-тай гадаад худалдааны нэгдсэн бодлого, зохицуулалтгүйгээс шалтгаалсан бөгөөд энэ нь бүтээгдэхүүнийг үнэгүйдүүлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашгийг бууруулах эрсдэлийг бий болгосон байна.

1.9. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын 3.7.5-д “Эрдэс баялгийн бүтээгдэхүүний гадаад, дотоодын зах зээл дээрх борлуулалтыг нээлттэй, оновчтой, өндөр үр ашигтай, зах зээлийн зарчимд нийцсэн аргаар хийх, шударгаар үнэ тогтоох, дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах зорилгоор эрдэс баялгийн бирж байгуулах”-аар заасан зорилтыг хэрэгжүүлж, олон улсын жишгийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг бүрдүүлэх нь тулгамдсан асуудал болж байв.

1.10. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ыг баталсан бөгөөд журам нь Эрдэнэс-Тавантолгой ХК болон хүсэлт гаргасан БНХАУ-ын хилийн боомтоор нүүрс экспортлогч аж ахуйн нэгжийн экспортод гаргах нүүрсийг цахимаар нээлттэй арилжих үйл ажиллагааг зохион байгуулах, түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулахад үйлчилж байна.

1.11. Дээрх журмын 1.2.5-д “...цахим системээр дамжуулан арилжаа зохион байгуулах хуулийн этгээд буюу Монголын хөрөнгийн бирж ТӨХК” байна гэж заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК хамтран нүүрсний цахим арилжааг зохион байгуулахтай холбоотой сургалтыг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 340 худалдан авагчид оролцож, биржид 88 компани бүртгүүлснээс 42 нь Монголын хөрөнгийн бирж ТӨХК -тай гэрээ байгуулан ажиллаж байна.

1.12. Биржийн анхны цахим арилжааг 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, 2023 оны 01 дүгээр улиралд нийт 10 удаагийн арилжаагаар Эрдэнэс-Тавантолгой ХК 640.0 мянган тонн (үүнээс 416.0 мянган тонн коксжих нүүрс, 192.0 мянган тонн эрчим хүчний нүүрс, 32.0 мянган тонн хагас коксжих нүүрс тус тус борлуулсан), Энержи ресурс ХХК 204.8 мянган тонн, Тавантолгой ХК 236.8 мянган тонн, нийт 1081.6 мянган тонн нүүрсийг биржээр дамжуулан худалдсан байна.

1.13. УИХ-аас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталж, “биржийн арилжаа”-г уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан худалдан борлуулах, түүнтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулах, үйл ажиллагааны цогц арга хэмжээ гэж тодорхойлсон байна.

1.14. Хуулийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд хууль мөрдөж эхлэх хүртэл хугацаанд уул уурхайн бүтээгдэхүүн, түүнд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэн арилжих, тээвэр, агуулах, лабораторийн итгэмжлэлийн тогтолцоог бий болгох, төлбөр тооцоог гүйцэтгэх зэрэг 12 төрлийн журам шинээр боловсруулах, арилжаа, клирингийн системийн бэлэн байдлыг хангах, чанарын хяналтын тогтолцоо, итгэмжлэлийн зохицуулалт бий болгохоор холбогдох байгууллагууд ажиллаж байна.

1.15. Энэ нь бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр арилжаалах боломжийг бүрдүүлсэн бөгөөд Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого хүчингүй болж, шинээр боловсруулж буй өнөөгийн нөхцөлд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг бодлогын уялдаа холбоо, хэрэгжүүлэх арга хэрэгсэл, олон талын оролцоог хангасан, өмнөх бодлогоор дэвшүүлсэн зорилт, хэрэгжилттэй уялдуулан боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

1.16. Мөн Монгол Улсын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хооронд 2010 оны 6 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан мэдээлэл солилцох протоколын⁴ 1.2-т “...талууд гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг цахим хэлбэрээр хагас, бүтэн жилээр харилцан солилцох”-оор заасан ч нүүрсний экспорт, импортын статистик мэдээг зөвхөн 2013, 2018 онуудад солилцсон байна. Харин 2019-2021 онд зэрэгцүүлэлт, харьцуулсан судалгаа хийгээгүй бөгөөд 2022 оны мэдээлэлд зэрэгцүүлэлт хийхээр БНХАУ-руу илгээсэн байна.

Хүснэгт 4. Монгол Улсын 2018-2022 оны нүүрсний экспорт, БНХАУ-ын импортын мэдээ, тонноор

Он	Монгол Улсын экспортолсон нүүрсний биет хэмжээ*	БНХАУ-ын импортолсон нүүрсний биет хэмжээ**	БНХАУ-ын импортолсон нүүрсний биет хэмжээ *** (цахим хуудаст мэдээлснээр)
2018 он	35,758,312.68	35,737,545.82	36,268,273.47
2019 он	36,465,256.43	36,057,773.80	36,348,978.57
2020 он	28,586,768.94	28,454,288.13	28,555,305.24
2021 он	15,683,174.31	16,025,422.82	16,479,926.76
2022 он	31,692,501.41	-	31,150,370.40

Эх сурвалж:

* Монгол Улсын ГЕГ-ын мэдээ

** БНХАУ-ын ГЕГ-аас Монгол Улсын ГЕГ-т ирүүлсэн мэдээ

*** БНХАУ-ын ГЕГ-ын Статистик мэдээллийн Онлайн Лавлагааны Платформ) <http://43.248.49.97/>, Ган төмрийн мэдээлэл солилцох мэргэжлийн платформ <https://www.mysteel.com/>

1.17. Аудитын хамарсан хугацаанд 2 улсын Гаалийн байгууллагуудын мэдээ болон хөндлөнгийн эх сурвалжийн мэдээлэл зөрүүтэй илэрхийлэгдсэн нь статистик мэдээлэлд 2019-2021 онд зэрэгцүүлэлт хийгдээгүй, түүнд тавих хөндлөнгийн хяналтын тогтолцоо

⁴ МУЗГ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1993 оны Хэлэлцээр, түүний хэрэгжилтийг хангах тухай 2010 онд байгуулсан Засгийн газар хоорондын Протоколын хүрээнд цаашид эрчимтэй хамтран ажиллахыг эрмэлзэж, Мэдээлэл солилцох нь гаалийн байгууллагын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой болохыг харилцан хүлээн зөвшөөрч энэхүү Протоколыг байгуулсан байна.

бүрдээгүй, статистик мэдээ, тайланг Засгийн газарт хүргүүлж хэлэлцдэггүйтэй холбоотой байна.

1.18. Уул уурхай дагнасан эдийн засагтай орнууд **Шигтгээ 1**-д дурдсан нүүрс олборлолт, үйлдвэрлэлээ тусгай хуулиар зохицуулж буй сайн жишээ олон байна. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа АМТХ-д тусгай зөвшөөрлийн харилцааг тусгайлан зохицуулснаас биш ашигт малтмалын төрөл тус бүрээр зохицуулаагүй орхигдуулсан нь эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйг харуулж байна.



Шигтгээ 1. ОХУ, БНХАУ, Австрали, Герман, Индонези, Казахстан зэрэг гадаад улс орнуудын нүүрсний үйлдвэрлэлээ хөгжүүлэхэд хэрэгжүүлж буй ажлын туршлага, стратеги төлөвлөлт, хууль тогтоомжийг нь харьцуулах судлахад:


- Хууль тогтоох дээд байгууллагаас батлан гаргасан “Нүүрсний үйлдвэрийн тухай” хуулийн хүрээнд нүүрс олборлох үйлдвэр байгуулах газраа сонгохоос эхлээд үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд баримтлах хууль хэрэгжүүлэх дүрэм, журмын дагуу өндөр хариуцлага, сахилга бат, хатуу хяналтын дор үйлдвэрлэл явуулдаг байна.
- Уул уурхайн хууль нь дотоодын ашигт малтмалын олборлолттой холбоотой тухайн орны хамгийн чухал хууль, эрх зүйн баримт бичиг болдог байна. Төрөөс нүүрсийг нэгдсэн төлөвлөлт, оновчтой хуваарилалтын дагуу иж бүрэн ашиглах бодлогыг хэрэгжүүлдэг. Мөн нүүрсний нөөц нь төрийн хамгаалалтад байж, төлөвлөсөн хэмжээнээс илүү олборлохыг хатуу хориглодог. Үүний зэрэгцээ уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх болон уурхайтай холбоотой хөрөнгө, дэд бүтцийг буулгах, зайлуулахад шаардлагатай тооцоолж буй зардлыг ирээдүйн нөхөн сэргээлтийн зардалд оруулахад онцгой анхаардаг байна. Нүүрсний үйлдвэр байгуулах, шинэчлэл хийхтэй холбогдох хөрөнгийг төр хариуцаж, төсвийн хуулийн дагуу тухайн жилийн төсөвт тусгадаг.
- Хууль тогтоомжид нүүрсний үйлдвэрийн аюулгүй байдлыг хангах бодлогыг нэн тэргүүнд баримталж, үйлдвэрлэлийн аюулгүй байдал, хариуцлага болон хяналтын тогтолцоог бий болгож, ажилтнуудын эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын журмыг тэргүүн зэнээнд мөрддөг. Түүнчлэн нүүрс олборлолтыг журмаар нарийвчлан зааж, олборлолтын оновчтой дарааллыг баримталж, нүүрсний нөөцийг тогтоосон хэмжээнд хүргэж (сорчлохгүйгээр) олборлодог. Хяналтын журмыг салбар бүрд хатуу мөрдөж ажиллахаар заасан байна. Уурхайн ажилтнуудыг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулдаг, мөн уурхайн удирдлага, ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахаар заасан байна.

1.19. Нүүрсний салбар ДНБ-ий 10.0 хувийг эзэлж, нэгдсэн төсвийн орлогын 7.0-10.0 хувь, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын 14.0-28.0 хувийг бүрдүүлж байгаагийн хувьд төрөөс эрх зүйн зохицуулалтаар хангах нь зүйтэй байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил нүүрсний салбараас шууд хамааралтай байгаа нь олон тулгуурт эдийн засгийн тогтолцоог бий болгох шаардлагатайг харуулж байна


1.20. Монгол Улсын ДНБ-д уул уурхайн салбар 2015 онд 18.0 хувийг эзэлж байсан бол 2021 онд 25.4 хувьд хүрч өссөн байна. Үүний дотор уул уурхайн салбарын олборлолтын дүнд нүүрс олборлолт 2015 онд 1.0 хувийг эзэлж байсан бол 2019 онд 12.6 хувь болсон нь нүүрс олборлолт эрчимтэй өссөнийг харуулж байна. Цар тахлын үед нүүрсний экспорт буурч байсан ч 2022 оноос өсөлт ажиглагдаж байна. (Дэлгэрэнгүйг график 3-аас харна уу)

График 3. ДНБ-д уул уурхайн олборлолтын салбарын эзлэх хувь



Эх сурвалж: ҮСХ, аудитын тооцоолол
*Урьдчилсан гүйцэтгэл

График 4. Монгол Улсын нүүрсний экспортод Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эзлэх хувь



Эх сурвалж: ҮСХ, аудитын тооцоолол

1.21. Монгол Улсаас экспортод гаргаж буй нийт эрдэс баялгийн бүтээгдэхүүнд нүүрсний экспорт 2015 онд 12.0 хувь байсан бол нүүрсний экспортын оргил үе болох 2019 онд 40.0 хувьд хүрч, 3.3 дахин өссөний дотор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн экспортолсон хэмжээ 4.3 дахин өсжээ. (Дэлгэрэнгүйг график 4-өөс харна уу)


1.22. Нөгөө талаар БНХАУ-ын Ганцмод боомтын нэг тонн коксжих нүүрсний үнэ 2015 онд 61.4 ам.доллар байсан бол 2022 онд 310.8 ам.доллар болж өссөн бөгөөд БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнийн өсөлтөөс шууд хамаарч⁵ Монгол Улсын нүүрсний экспортын орлого нэмэгдсэн байна. Харин тээвэрлэлт, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлээгүйн улмаас борлуулалтын дундаж үнэ (уурхайн “ам” нөхцөл) зах зээлийн үнээс 1.5-2.1 дахин бага байжээ.

1.23. Энэ нь олборлох салбарын түүхий эдийн үнэ буурахад нүүрсний экспортын хэмжээ шууд хамааралтайгаар буурч улмаар уул уурхайн томоохон ордуудын олборлолтоос олохоор тооцсон төсвийн орлого тасалдах, Монгол Улсын эдийн засагт хүндрэл үүсэх, ДНБ-ий өсөлт буурах эрсдэлтэй байна. (Дэлгэрэнгүйг график 5-аас харна уу)

1.24. Уул уурхайн орлого 2015 онд нэгдсэн төсвийн нийт орлогын 19.0 хувийг эзэлж байсан бол 2021 онд 30.0 хувь болж өссөн байна. Бусад эрдэс бүтээгдэхүүнээс орох орлого харьцангуй тогтвортой байхад нүүрсний салбарын орлого 2015 онд нэгдсэн төсвийн нийт орлогын 2.0 хувийг эзэлж байсан бол 2021 онд 7.0 хувь болж 5 пунктээр нэмэгдсэнээс харахад нүүрс нь Монгол Улсын эдийн засгийн стратегийн чухал бүтээгдэхүүн болохыг харуулж байна. (Дэлгэрэнгүйг график 6-аас харна уу)


⁵ Корреляцийн коэффициент 81.4

График 5. Нүүрсний экспортын Олон улсын зах зээлийн үнэ



Эх сурвалж: YCX, www.sxcoal.com

График 6. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээнд уул уурхайн орлогын эзлэх хувь




Эх сурвалж: YAG 2015-2021 оны аудитын тайлангууд

1.25. Харин уул уурхай, олборлолтын салбарт ажил эрхлэлт 2015 онд 3.7 хувь байсан бол 2022 онд 5.4 хувь болж нэмэгдсэн нь ажиллах хүчнийг нэмэгдүүлэхээс илүүтэй ашиглаж буй тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжтой салбарын онцлогтой холбоотой байна. (Дэлгэрэнгүйг график 7-оос харна уу)


1.26. Байгалийн баялгийг ашиглаж байгаагийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасны дагуу монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, ядуурлаас ангижруулахад чиглэдэг. Гэвч уул уурхайн салбараас олох орлого нэмэгдсээр байхад Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин буураагүй, 2020⁶ онд нийт хүн амын 27.8 хувь буюу 947,963 хүн ядуу амьдарч байна. (Дэлгэрэнгүйг график 8-аас харна уу)

График 7. Уул уурхай, олборлолтын салбарт ажил эрхлэлтийн байдал



Эх сурвалж: YCX

График 8. Монгол Улсын ядуурлын түвшин, хувь




Эх сурвалж: YCX

⁶ YCX-оос Дэлхийн банктай хамтран 2023 оны эхний хагаст багтаан 2022 оны ядуурлын түвшний мэдээллийг гаргахаар судалгаа авч байна.

1.27. Монгол Улс бүх төрлийн эрдэс баялгийг нэмүү өртөг шингээхгүй түүхийгээр нь экспортолж, ДНБ-ий тогтвортой өсөлтийг бий болгох боломжийг ашиглаж чадахгүй байгаа нь нөөц шавхагдах баялгийг үр ашигтай зарцуулах шаардлагатайг улам бүр сануулсаар байна.

График 9. ДНБ-ий өсөлт, оны үнээр




Эх сурвалж: УСХ

БҮЛЭГ 2.ТАВАНТОЛГОЙН ОРДЫГ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТӨД ҮНДЭСЛЭН ҮР АШИГТАЙ, ЦОГЦ БАЙДЛААР АШИГЛАХГҮЙ БАЙГАА НЬ ОРДЫН ҮНЭ ЦЭНИЙГ БУУРУУЛЖ БАЙНА

Хайгуулын ажлын хоцрогдол Тавантолгойн ордын баттай, бодитой нөөцийг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна

2.1 Тавантолгойн нүүрсний ордын нөөцийг тооцоолоход хайгуулын цооногийн торын нягтралыг ордын хэсэг бүр дээр харилцан адилгүйгээр сонгож хайгуулын өрөмдлөгийг хийсэн байна.

Зураг 1. Тавантолгойн орд газарт хайгуулдсан өрмийн цооногийн байршлын мэдээлэл



Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

Хүснэгт 5. Тавантолгойн орд газарт хайгуулдсан өрмийн торын нягтрал, метрээр

Талбайн нэр	III давхарга хүртэл	0 давхарга хүртэл
Цанхи Төв хэсэг	200 x 100	300 x 150
Цанхи Бусад	300 x 200	700 x 350
Оорцог	300 x 200	700 x 350
Талбайн нэр	VIII давхарга хүртэл	0 давхарга хүртэл
Бортээг төв хэсэг	200 x 100	1000 x 700
Бортээг бусад	350 x 250	1000 x 700
Оорцог	350 x 250	700 x 350
Бортолгой	1500 x 500	
Онч хараат	1500-2000 x 350-500	2000 x 1500

Эх сурвалж: Хайгуулын ажлын тайлан

2.2 Цанхийн төв, Бортээгийн төв хэсэгт хайгуулын ажлыг бодитой буюу Б зэргийн түвшинд хайгуулын торын нягтралыг 200x100 метрийн нарийвчлалтайгаар 2000 га талбай буюу нүүрс тогтоогдсон талбайн 10 хувьд, Цанхийн бусад Оорцог, Бортээгийн бусад хэсэгт 300x200 метр торын нягтралаар Б (бодитой) болон С (боломжтой) зэргээр 7800 га талбайд тус тус хайгуулын ажил хийсэн байна. Мөн Бортолгой, Онч хараат зэрэг талбайд хайгуулын

цооног 0.5-2.0 км зайтай байгаа нь цаашид геологи хайгуулын нөөцийг баттай, бодитой зэрэгт шилжүүлэх шаардлага үүсгэж байна.

Хүснэгт 6. Геологи хайгуулын ажлын 2018-2022 оны хэмжээ болон зардлын мэдээлэл

Үзүүлэлтүүд	Өрөмдлөг (тууш метр)	Лабораторийн сорьцын тоо (ширхэг)	Цооногийн геофизикийн хэмжилт (тууш метр)	Бусад зардал, сая төгрөг	Нийт		1 тууш метр өрөмдлөгийн өртөг
					Сая төгрөг	Хувь	
2018	Хэмжээ	85,927	17,612	85,927			120.0
	Зардал	10,459.0	2,145.0	1,001.0	1,058.0	14,663.0	
2019	Хэмжээ	39,798	8,119	39,798			140.0
	Зардал	5,748.0	1,251.0	401.0	567.0	7,967.0	
2020	Хэмжээ	50,000	14,514	50,000			100.0
	Зардал	5,164.0	2,100.0	510.0	192.0	7,966.0	
2021	Хэмжээ	2,048	1,824	2,048			150.0
	Зардал	297.0	428.0	40.0	42.0	807.0	
2022	Хэмжээ	20,202	3,508	20,113			163.0
	Зардал	3,311.0	624.0	415.0	317.0	4,668.0	
Нийт	Хэмжээ	197,975	45,577	197,886	0	0	126.0
	Зардал	24,979.0	6,548.0	2,367.0	2,176.0	36,071.0	
	Эзлэх хувь	69.2	18.2	6.6	6.0	100.0	

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хайгуулын ажлын тайлан

2.3 Ашиглалтын болон нарийвчилсан хайгуул нь өрөмдлөгийн торын нягтралыг нэмэгдүүлж, орд газрын нөөцийг өсгөх үндсэн зорилготой тогтмол хийх ажил боловч энэхүү ажлын жил бүрийн биет хэмжээг авч үзвэл харилцан адилгүй байна. Тухайлбал, 2018 онд 85.9 мянган тууш метр өрөмдлөгийн ажил хийсэн бол 2021 онд 2.0 мянган тууш метр өрөмдлөг хийж, хайгуулын өрөмдлөгийн хэмжээ 41.9 дахин буурсан бол 2022 онд өмнөх онтой харьцуулбал 9.9 дахин өссөн байна.

2.4 Геологи, хайгуулын зардалд 2018-2022 онд нийт 36.1 тэрбум төгрөг зарцуулж, зардалд өрөмдлөгийн ажил 69.2 хувь, лабораторийн сорьц 18.2 хувь, геофизикийн хэмжилт 6.6 хувь, бусад зардал 6.0 хувийг тус тус эзэлж байна. Геологи, хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгө 2018-2022 онд 1.8-18.2 дахин буурсан нь ордын нөөцийг нарийвчлан судлах, нөөцийн баттай болон бодитой зэрэглэлийг нэмэгдүүлэх, чанарын үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоох боломжийг хязгаарласан байна.

2.5 Мөн АМГТГ-ын даргын 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн “Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай” Н/26 дугаар тушаалаар баталсан Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайн нөөцийн шинэчилсэн тооцооны нэгтгэл тайланд Цанхийн баруун уурхайн геологийн нөөцөд тооцсон коксжих нүүрсний хэмжээг 772.1 сая тонноор тооцсон байхад үйлдвэрлэлийн нөөцийг 954.1 сая тонн гэж 182.0 сая тонноор илүү тооцож, тооцооллын алдаа гаргасан байна.

2.6 Иймд 2019 онд баталсан тайлангаарх Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайн нөөцийн шинэчилсэн тооцооны нэгтгэл тайланд тодотгол хийж алдааг залруулах шаардлагатай байна.

Техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу хөрсний овоолгыг үүсгээгүйгээс их хэмжээний үргүй зардал гаргах эрсдэлтэй байна

Цанхийн баруун уурхайн хөрс тээвэрлэх талбайд Цагаан-Овоо тосгон байрласны улмаас:

2.7 Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын (хуучин нэрээр) 2012 оны “Техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах тухай” 134 дүгээр тушаалаар баталсан “Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн баруун хэсгийг ашиглах уурхайн ТЭЗҮ”-д баруун уурхайгаас нийт 1,645 сая м.куб хөрс хуулж, үүний 3.3 хувь буюу 54.0 сая м.куб хөрсийг баруун уурхайгаас 2-3 км зайд байрлах I овоолго руу зөөхөөр (тус овоолго

2017 онд дүүрсэн), 36.2 хувь буюу 596.3 сая м.куб хөрсийг баруун уурхайгаас 3-5 км зайд байрлах II овоолго руу зөөхөөр, 60.5 хувь буюу 994.7 сая м.куб хөрсийг дотоод овоолго хийхээр төлөвлөжээ.

2.8 Цанхийн баруун уурхайгаас 2017-2022 онд хуулсан 124.9 сая м.куб хөрсийг ТЭЗҮ-ийн дагуу хоёрдугаар овоолго руу зөөвөрлөх байтал баруун уурхай болон II овоолгын хоорондох 109 га талбайд 213 өрх, 762 оршин суугчтай Цагаан-Овоо тосгон байрласны улмаас уг хөрсийг 5-7 км зайд байрлах 1.6 тэрбум м.куб хөрс овоолох багтаамжтай Бортээгийн уурхайн овоолгын талбай руу зөөвөрлөж байна. (Зургийг хавсралт 2-оос харна уу)

2.9 Хөрсийг ТЭЗҮ-д тусгасан 3-5 км зайд байрлах II овоолго руу зөөхгүйгээр 5-7 км зайд байрлах Бортээгийн уурхайн овоолгын талбай руу зөөж, дунджаар 2 км зайд илүү тээвэрлэсэн нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардлыг өсгөж, 124.9 сая м.куб хөрсийг 373.1 тэрбум төгрөгийн нэмэлт зардал гарган зөөсөн байх тооцоолол гарч байна.

2.10 Цаашид ТЭЗҮ-д тусгасан II овоолго руу зөөвөрлөх ёстой 596.3 сая м.куб хөрсийг Бортээгийн уурхайн овоолгын талбай руу зөөвөрлөснөөр ойролцоогоор 1.8 их наяд төгрөгийн үргүй зардал гарахаар байна.

2.11 Бортээгийг ашиглах 2020 оны ТЭЗҮ-ээр уурхайгаас гарах 868.3 сая м.куб хөрсний овоолго хийхээр төлөвлөсөн талбайд баруун, зүүн Цанхийн уурхайнуудаас одоогоор 124.9 сая м.куб хөрсний овоолго хийсэн нь Бортээгийн уурхайг ирээдүйд овоолго хийх талбайгүй болгож, хөрс тээвэрлэлтийн зай холдож, өртөг зардал нэмэгдэх эрсдэлийг үүсгэж байна.

2.12 Хөрс тээвэрлэх зардал өсөх шалтгаан болсон Цагаан-Овоо тосгоныг шинэ суурьшлын бүс рүү нүүлгэхэд шаардагдах хөрөнгийн үнэлгээгээр тогтоосон 204 иргэнд олгох 7.1 тэрбум, Тавантолгой ХК-д олгох 10.0 тэрбум, хөрөнгийн үнэлгээнд хамрагдаагүй 26 иргэний газрыг жишиг үнээр олгох 0.1 тэрбум, нийт 17.2 тэрбум төгрөг (Эрдэнэ-Тавантолгой ХК-ийн тооцоолсноор)-ийн зардлаар тосгоныг нүүлгэн шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулснаар ирээдүйд гарч болзошгүй компанийн үргүй зардлыг бууруулах боломжтой байна.

2.13 Өнөөгийн байдлаар нөхөн олговрын гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөр авсан 206 иргэн, үүнээс газраа бүрэн чөлөөлж акт үйлдэн нөхөн олговрыг 100 хувь авсан 183 иргэн байна. Үүнд 2022 онд 5.8 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нөхөн олговрын гэрээгээ дүгнээгүй 23 иргэний үлдэгдэл 0.9 тэрбум төгрөг, гэрээ байгуулаагүй 24 иргэний үлдэгдэл 0.5 тэрбум, нийт 1.4 тэрбум төгрөгийг зарцуулаагүй байна.

Цанхийн баруун, зүүн уурхайд дотоод овоолго хийх боломжгүйн улмаас:

2.14 ТЭЗҮ-ээр уурхайн ашиглалтын 30 жилийн хугацаанд Цанхийн зүүн хэсгээс 1,304.7 сая м.куб хөрс хуулж, үүнээс 51.2 хувь буюу 668.5 сая м.куб хөрсийг гадаад овоолго руу зөөх, 48.8 хувь буюу 636.2 сая м.куб хөрсөөр дотоод овоолго, Цанхийн баруун хэсгээс 1,645.0 сая м.куб хөрс хуулж, үүнээс 39.5 хувь буюу 650.3 сая м.куб хөрсийг гадаад овоолго руу зөөх, 60.5 хувь буюу 994.7 сая м.куб хөрсөөр дотоод овоолго үүсгэхээр тус тус төлөвлөсөн байна.

2.15 Эрдэнэс-Тавантолгой ХК уурхайг ашиглаж эхэлснээс хойш 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд Цанхийн зүүн хэсгээс 327.3 сая м.куб хөрс, Цанхийн баруун хэсгээс 183.7 сая м.куб хөрсийг тус тус гадаад овоолго руу зөөсөн байна.

2.16 Цанхийн зүүн, баруун уурхайд хөрсний дотоод овоолго үүсгээгүй нь уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэн тэргүүнд шаардагдах усны эх үүсвэрийг шийдвэрлээгүй, цахилгаан станц барих төсөл хэрэгжээгүй, нүүрс баяжуулах үйлдвэрийг

байгуулаагүйгээс III, IV давхаргын доорх коксжих чанар сул “II”, “I”, “0” давхаргын нүүрсийг олборлохгүй байна.

2.17 Мөн цаашид хөрсний дотоод овоолго хийхээр төлөвлөсөн Цанхийн зүүн хэсгийн 636.2 сая м.куб хөрс, Цанхийн баруун хэсгийн 994.7 сая м.куб, нийт 1,630.9 сая м.куб хөрсийг гадаад овоолго руу зөөснөөр их хэмжээний үргүй нэмэлт зардал гарахаар байна.

2.18 Иймд уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглах усны эх үүсвэрийг яаралтай тодорхойлж, “0” давхаргын нүүрсийг олборлож, ордыг сорчлохгүй, цогцоор нь үр ашигтай ашиглах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг тэргүүн ээлжид хийх шаардлагатай байна.

Уурхайд ашиглах усны эх үүсвэрийг шийдвэрлээгүйгээс нүүрсийг сорчлон олборлож байгаа нь ордын үнэ цэнийг бууруулж, насжилтыг богиносгож байна

2.19 ТЭЗҮ-д Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн зүүн хэсгээс 2018-2022 онд нийт 44.2 сая тонн коксжих, 24.8 сая тонн эрчим хүчний, нийт 69.0 сая тонн нүүрс, Цанхийн баруун хэсгээс 2018-2022 онд нийт 54.1 сая тонн коксжих, 27.8 сая тонн эрчим хүчний, нийт 81.9 сая тонн нүүрс олборлохоор тусгасан байна.

2.20 Гүйцэтгэлээр Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн зүүн хэсгээс 2018-2022 онд 34.9 сая тонн коксжих, 3.1 сая тонн эрчим хүчний, нийт 38.0 сая тонн нүүрс, Цанхийн баруун хэсгээс 19.9 сая тонн коксжих, 2.1 сая тонн эрчим хүчний нийт 22.0 сая тонн нүүрс олборлосон байна.

2.21 Цанхийн баруун болон зүүн хэсгийн ТЭЗҮ-ээр 2018-2022 онд олборлохоор төлөвлөсөн нийт нүүрсний 39.8 хувь, үүнээс коксжих нүүрсний 55.8 хувийг, эрчим хүчний нүүрсний 9.8 хувийг тус тус олборлосон байна.

Хүснэгт 7. ТЭЗҮ-д тусгасан нүүрс олборлох ажлын 2018-2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

Он	ТЭЗҮ-ээр төлөвлөсөн							Гүйцэтгэл				
	Нийт олборлох нүүрс		Үүнээс:				Нийт олборлосон нүүрс, төлөвлөлтөд эзлэх хувь		Үүнээс:			
			Коксжих нүүрс		Эрчим хүчний нүүрс				Коксжих нүүрс		Эрчим хүчний нүүрс	
мян.тонн	хувь	мян.тонн	хувь	мян.тонн	хувь	мян.тонн	хувь	мян.тонн	хувь	мян.тонн	хувь	
Цанхийн зүүн уурхай												
2018	15,000.0	100.0	7,500.0	50.0	7,500.0	50.0	7,045.0	47.0	6,610.0	88.1	435.0	5.8
2019	15,000.0	100.0	7,500.0	50.0	7,500.0	50.0	11,016.0	73.4	9,624.0	128.3	1,392.0	18.6
2020	15,000.0	100.0	7,500.0	50.0	7,500.0	50.0	8,851.0	59.0	8,008.0	106.8	843.0	11.2
2021	12,000.0	100.0	10,869.0	90.6	1,131.0	9.4	3,999.0	33.3	3,871.0	35.6	128.0	11.3
2022	12,000.0	100.0	10,869.0	90.6	1,131.0	9.4	7,110.0	59.3	6,800.0	62.6	311.0	27.5
Бүгд	69,000.0	100.0	44,238.0	64.1	24,762.0	35.9	38,020.0	55.1	34,913.0	78.9	3,108.0	12.6
Цанхийн баруун уурхай												
2018	20,000.0	100.0	11,000.0	55.0	9,000.0	45.0	3,945.0	19.7	3,570.0	32.5	375.0	4.2
2019	20,000.0	100.0	11,000.0	55.0	9,000.0	45.0	5,127.3	25.6	5,076.3	46.1	51.0	0.6
2020	8,440.0	100.0	6,371.0	75.5	2,069.0	24.5	4,219.0	50.0	4,033.0	63.3	186.0	9.0
2021	15,351.0	100.0	11,774.0	76.7	3,577.0	23.3	4,455.5	29.0	3,409.0	29.0	1,046.5	29.3
2022	18,095.0	100.0	13,933.0	77.0	4,162.0	23.0	4,196.4	23.2	3,809.0	27.3	387.4	9.3
Бүгд	81,886.0	100.0	54,078.0	66.0	27,808.0	34.0	21,961.0	26.8	19,906.0	36.8	2,055.0	7.4
Нийт дүн	150,886.0	100.0	98,316.0	65.2	52,570.0	34.8	59,981.0	39.8	54,819.0	55.8	5,162.0	9.8

Эх сурвалж: Тавантолгойн ордын Цанхийн баруун ба зүүн хэсгийн ТЭЗҮ, 2018-2022 оны уулын ажлын тайлан

Figure 1: Volume of waste in tons by type of waste and year.

Bar Chart Data (Volume in tons):

Year	III давхарга (Blue)	IV давхарга (Cyan)	Бусад давхарга (Green)
2018 он	2.72	8.20	0.07
2019 он	4.34	10.90	0.92
2020 он	3.95	6.97	2.15
2021 он	1.77	4.72	1.96
2022 он	5.66	4.89	0.76

Donut Chart Data (Percentage of Total Waste):

Waste Type	Percentage (%)
IV давхарга	59.5
III давхарга	30.7
Бусад давхарга	9.8

2.23 Цанхийн зүүн болон баруун уурхайгаас 2018-2022 онд нийт олборлосон нүүрсний 90.2 хувийг зөвхөн III, IV давхаргаас олборлосон байна. (Зураг 2-оос Цанхийн зүүн уурхайн, зураг 3-аас Цанхийн баруун уурхайн олборлолтын байдлыг харна үү)

А-А' дугамын зүсэлт

1540 1500 1460 1420 1380 1340 1300 1260 1220


144 319 651 325 711 501 650 1089 995 1087 1084 355 998 1081 326 1082 300 649 860 859 337 700

IV-ab IV-b IV-c IV-d IV-e IV-f IV-g IV-h IV-i IV-j IV-k IV-l IV-m IV-n IV-o IV-p IV-q IV-r IV-s IV-t IV-u IV-v IV-w IV-x IV-y IV-z

Газрын гадарга 372 Хайгуулын цооногийн дугаар 4 дугаар жил 11-15 дугаар жил 26-30 дугаар жил Хагарал Хайгуулын цоонг 5 дугаар жил 16-20 дугаар жил Нүүрсний давхарга 1-3 дугаар жил 6-10 дугаар жил 21-25 дугаар жил 2022.12.31-ний байдлаар уурхайн ёроол

Таних тэмдэг


Зураг 26. Цанхийн зүүн уурхайн ТЭЗҮ-ээрх төлөвлөлт 2021 он, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх уурхайн босоо зүсэлт




Эх сурвалж: Аудитын тооцоолол

Тайлбар: Цанхийн зүүн уурхайн 2011 оны болон 2021 оны ТЭЗҮ-ээрх төлөвлөлтийг харьцуулсан байдал

Зураг 3а. Цанхийн баруун уурхайн ТЭЗҮ-ээрх төлөвлөлт 2012 он, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх уурхайн босоо зүсэлт



Зураг 3б. Цанхийн баруун уурхайн ТЭЗҮ-ээрх төлөвлөлт 2021 он, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх уурхайн босоо зүсэлт




Эх сурвалж: Аудитын тооцоолол

Тайлбар: Цанхийн зүүн уурхайн 2011 оны болон 2021 оны ТЭЗҮ-ээрх төлөвлөлтийг харьцуулсан байдал

2.24 Цанхийн зүүн болон баруун уурхайн олборлолтын 2022 оны жилийн эцсийн байдлаарх зүсэлтийн зургаас харахад газрын гадаргууд ойр буюу 120 м хүртэлх гүнд орших сайн чанарын коксжих нүүрс болох III, IV, давхаргыг голчлон олборлож байгаа нь ирээдүйд уурхайн олборлолт явуулсан талбайд гүнд байрлах, коксжих чанар муу их хэмжээний нүүрс газрын хэвлийд орхигдох нөхцөлийг бүрдүүлж байна.


2.25 Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ХХ/2020-14-03 дугаар дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн Т/59 дугаар тушаалаар баталсан “Баруун Цанхийн хэсгийн талбай дахь нөөцийг ил уурхайн аргаар ашиглах ТЭЗҮ”, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн СТР/2021-05-01 дугаар дүгнэлтийг үндэслэн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Т/16 дугаар тушаалаар баталсан “Цанхийн болон Бортээгийн хэсгийн ТЭЗҮ (Зүүн Цанхи)”-гээр дээрх зурагт үзүүлснээр уурхай гүнзгийрэхгүйгээр, газрын гадаргууд ойрхон коксжих чанар өндөртэй, III, IV давхаргын нүүрсийг 2031 он хүртэл сорчлох байдлаар олборлохоор төлөвлөснийг харж болно. (Зураг 3-а, 3-б-ээс харна уу)

График 11. Цанхийн баруун уурхайн ТЭЗҮ-ийн олборлолтын дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Аудитын үр дүн

График 12. Цанхийн зүүн уурхайн ТЭЗҮ-ийн олборлолтын дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Аудитын үр дүн

2.26 Өндөр чанартай коксжих нүүрсийг дангаар олборлох ТЭЗҮ боловсруулж, баталсан нь Газрын хэвлийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2-т “*ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ордын зөвхөн баялаг хэсгийг сорчлон олборлохгүй байх*”, АМТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.5-д “*Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно*” гэж заасантай нийцэхгүй байна.

Уурхайг цогц байдлаар ашиглахад секундэд 328.4 литрийн ундаргатай усны нөөц шаардлагатай байгаагаас 63.5 литр секундийн эх үүсвэрт техник, эдийн засгийн үндэслэл хийсэн нь ордыг сорчилж олборлосон хэвээр байхад хүргэж байна

2.27 Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн зүүн болон баруун уурхай, цахилгаан станц, 30.0 сая тонн нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн болон ажиллагсдын тосгоны ахуйн ундны усны хэрэглээнд 219.4 л/секундийн усны ундарга шаардлагатай байна. Үүнд:

- Баяжуулах үйлдвэрт – 128.9 л/секунд
- Цахилгаан станцад – 33.0 л/секунд
- 10 мянган оршин суугчтай тосгоны усны хэрэглээнд – 57.5 л/секунд ундарга хэрэгтэй байна.

2.28 Уурхайн үйл ажиллагаанд шаардагдах усыг 2015-2016 онд “МИНИС” төслийн хүрээнд Тавантолгойн ордыг түшиглэн барихаар төлөвлөж буй нүүрс угаах үйлдвэрийн цогцолборын технологийн ус хангамжийн шинэ эх үүсвэрийг илрүүлэх газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажлын хүрээнд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн уурхайгаас 70 км-ийн зайд орших Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сүүжийн худгийн Загийн усны хоолойн хэсэгт тогтоосон 63.5 л/секунд ундаргаас авахаар тооцсон байна.

2.29 Энэхүү усны нөөцөөс нүүрс баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн асуудлыг шийдэхээр төлөвлөж, зүүн хойд зүгт 72.6 км зайд ус татах шугам хоолойн ТЭЗҮ, зураг төслийг Престиж инженеринг ХХК-аар 339.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна. (Тавантолгойн бүлэг ордын ойролцоох усны ундаргын байршлыг хавсралт 3-аас харна уу)

2.30 Загийн усны хоолойн гүний усны ордоос уурхайн үйл ажиллагаанд шаардагдах нийт усны хэрэглээг хангаж чадахгүй бөгөөд зөвхөн нүүрс баяжуулах 10.0 сая тоннын хүчин чадалтай үйлдвэрийг усаар хангах эх үүсвэрийг шийдвэрлэсэн гэж үзэхээр байна.

2.31 Гэтэл усны асуудлаа иж бүрэн шийдвэрлээгүй байхад Тавантолгой дулааны станц ТӨХХК-д 450 мВт хүчин чадалтай цахилгаан станцыг барьж, төвийн бүсийн сүлжээнд цахилгаан нийлүүлэх тусгай зөвшөөрлийг 2021 онд олгосон бөгөөд цахилгаан станцын хэрэглээнд 40 л/секундын усны ундарга шаардагдана.

2.32 Иймд уурхайн үйл ажиллагааг цогцоор нь үр ашигтай, сорчлохгүй явуулахын тулд нэн тэргүүнд усны нөөцийн асуудлыг бүрэн шийдвэрлэх хэрэгтэй тул цаашид усны эх үүсвэрийг хайх, шинэ эх үүсвэр олох ажлыг цаг алдахгүй зохион байгуулах шаардлагатай байна.

2.33 Эрдэнэс-Тавантолгойн ХК-ийн инженер техникийн ажилчдын компанийн ТЭЗҮ болон техникийн баримт бичигт үндэслэн тооцоолсноор 2026 онд цахилгаан эрчим хүчний хэрэглээ 281 МВт хүрэхээр байна. Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилга угсралтын ажил, Загийн усны ордоос нүүрсний уурхай хүртэлх ус хангамжийн шугам хоолойн барилга угсралтын ажил тус тус эхэлсэн хэдий ч ус хангамж хүрэлцээгүй, шаардагдах эрчим хүч байхгүйгээр үйлдвэр хэвийн ажиллах боломжгүйд хүрэх эрсдэлтэй байна.

Ордыг олон тусгай зөвшөөрөлд хувааж ашиглалт явуулж байгаа нь нэг уурхайн хөрсний овоолго нөгөө уурхайн хүрээг дарах, нэг компанийн лицензтэй талбайгаас өөр компани олборлолт явуулах нөхцөлийг үүсгэсэн байна

2.34 Тавантолгой бүлэг ордод Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой ХК, Энержи ресурс ХХК гэсэн 3 компани үйл ажиллагаа явуулж, нийт 10 тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Ордыг цогц байдлаар бус олон тусгай зөвшөөрөлд хуваан ашиглаж байгаа нь нэг уурхайн хөрсний овоолго нөгөө уурхайн хүрээг дарах, нэг уурхайн лиценз бүхий талбайгаас өөр уурхай олборлолт явуулах, нэг уурхайн тээвэрлэлтийн зам, гарц нөгөө уурхайн гарцыг хаах нөхцөл үүсгэсэн байна. Тухайлбал,

Нэг уурхайн хөрсний овоолго нөгөө уурхайн хилийг дарсан:

- Тавантолгойн ордын Цанхийн зүүн уурхайн зүүн хойд хүрэн дээр өмнөх жилүүдийн үйл ажиллагааны үед 45.8 сая м.куб хөрсний овоолго байрлуулсан нь уурхайг ТЭЗҮ-ээр тогтоосон хүрэн дотор ашиглах боломжгүйд хүргэсэн байна. (Зургийг хавсралт 4-өөс харна уу)
- Овоолго нь уурхайн ТЭЗҮ-ээр тогтоосон хүрээ рүү 400-450 метрээр цөмөрч орон “0”, “III” давхаргын гадаргад ойрхон жигүүр хэсгийн нүүрсийг дарж байршсан байна. Иймд төслийн хүрээг чөлөөлөхийн тулд 14.5 сая м.куб хөрс зайлуулах шаардлагатай болсон байна. (Зургийг хавсралт 5-аас харна уу)

Нэг уурхайн лиценз бүхий талбайгаас өөр уурхай олборлолт явуулсан:

- Тавантолгой ХК 2012-2014 онд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайгаас хууль бусаар нүүрс олборлосон” эрүүгийн хэрэгт гаргасан 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 180200174 дугаартай шинжээчийн дүгнэлтээр Тавантолгой ХК-ийн 4 дүгээр уурхайн олборлолтод Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайн нүүрс өртөж нийт 340,092.98 тонн нүүрсийг олборлосон байна.
- Дээрх нүүрснээс Тавантолгой ХК нь 2017, 2021 онд нийт 63,531.80 тонн нүүрсийг буцаан өгсөн байна.
- Үлдэх 276,561.18 тонн нүүрсийг 2022 онд олборлосон нүүрсний чанарын үзүүлэлттэй дүйцэх нүүрсээр хүлээлээн өгөхөөр гэрээ байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Тавантолгой ХК-аас 258.9 мянган тонн нүүрсний төлбөрт 13.9 сая ам.доллар буюу 48.0 тэрбум төгрөгийг төлсөн байна.

Тээвэрлэлтийн зам, гарц хаагдах:

- Тавантолгой ХК-ийн нүүрс, гадаад овоолго руу хөрс тээвэрлэх зам Цанхийн баруун уурхайн замтай давхцаж ачаалал үүсгэсэн.

2.35 Тавантолгой ХК-ийн Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн лицензийн талбайгаас олборлосон нүүрсний хэмжээг тогтоож, гэрээ байгуулж, буцаан авсан ч энэ асуудал дахин гарах эрсдэлтэй хэвээр байна.

Цанхийн баруун хэсгийн уулын цулыг хөдөлгөх ажлыг олборлолт, борлуулалтын төлөвлөгөөтэй уялдуулаагүй байна

2.36 Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн баруун хэсгээс 2018-2022 онд 328.5 сая м.куб хөрс хуулж, 81.9 сая тонн нүүрс олборлон нийт 387.1 сая м.куб уулын цулыг хөдөлгөхөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт 8. Цанхийн баруун уурхайн ТЭЗҮ-д тусгасан уулын цул хөдөлгөх ажлын 2018-2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

Он	ТЭЗҮ-ээр төлөвлөсөн			Гүйцэтгэл			Хөрс хуулалтын дундаж коэффициент
	Хөрс хуулалт	Нүүрс олборлолт	Нийт хөдөлгөх уулын цул	Хөрс хуулалт	Нүүрс олборлолт	Нийт хөдөлгөсөн уулын цул	
	сая м.куб	сая тонн	сая м.куб	сая м.куб	сая тонн	сая м.куб	
2018	74.4	20.0	88.7	15.2	4.1	18.0	3.7
2019	66.0	20.0	80.3	14.3	5.2	18.0	2.8
2020	43.8	8.4	49.8	28.2	4.2	31.2	6.7
2021	71.2	15.4	82.2	39.0	4.5	42.2	8.8
2022	73.1	18.1	86.1	22.9	4.2	25.9	5.5
ДҮН	328.5	81.9	387.1	119.6	22.2	135.3	5.5

Эх сурвалж: Тавантолгойн ордын Цанхийн баруун хэсгийн ТЭЗҮ, 2018-2022 оны уулын ажлын тайлан

2.37 Бодит гүйцэтгэлээр 2018-2022 онд ТЭЗҮ-тэй харьцуулахад 36.4 хувь буюу 119.6 сая м.куб хөрс хуулж, 27.0 хувь буюу 22.2 сая тонн нүүрс олборлон нийт 34.9 хувь буюу 135.3 сая м.куб уулын цулыг хөдөлгөж, хөрс хуулалтын дундаж коэффициент 2018 онд 3.7 м.куб/тонн, 2019 онд 2.8 м.куб/тонн буюу хөрсийг бүрэн хуулаагүй нь хөрс хуулалтын хоцрогдлыг үүсгэсэн, 2020 онд хөрс хуулалтын дундаж коэффициент 6.7 м.куб/тонн, 2021 онд 8.8 м.куб/тонн, 2022 онд 5.5 м.куб/тонн болсон ч нүүрсний олборлолт, борлуулалттай

уялдаагүйгээр уулын цулыг хөдөлгөсөн байна. Энэ нь нүүрсний дээд өнгөн давхарга бохирдох, өгөрших эрсдэлтэйгээс гадна нүүрс олборлогч компаниудад төлөх өр төлбөр үүсгэх эрсдэлтэй байна.

2.38 Мөн Эрдэнэс-Тавантолгой ХК нь олборлож буй нүүрсний дээжид гэрээт лабораториор шинжилгээг хийлгэж, сүүлийн 5 жилд нийт 3,938.0 сая төгрөг олгосон байна. Өнөөгийн нөхцөлд шинжилгээний дүнг зөвхөн бүтээгдэхүүний борлуулалтад ашиглаж байгаагаас бус үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдан явуулахад ашиглаагүй байна. Тухайлбал, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд шаардлагатай дүн шинжилгээний ажил, хорт бодисын найрлагын тэнцвэрийг хангах ажил хийгдээгүй байна.

Хүснэгт 9. Лабораторид шинжлүүлсэн шинжилгээний тоо, сая төгрөг

Он	Сорьцын тоо, төрлөөр					Нийт сорьцын тоо	Нийт төлбөр
	Яаралтай	Коксжих	Эрчим хүч	Өгөршсөн	Анхдагч буталгаа		
2018	37	1,761	451	2	6	2,257	446.2
2019	257	2,470	512	1	-	3,240	729.5
2020	1,522	3,865	672	20	-	6,079	1,418.2
2021	1,212	1,925	333	-	-	3,470	740.9
2022	791	1919	295	-	-	3,005	603.2
Нийт	3,819	11,940	2,263	23	6	18,051	3,938.0

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

2.39 Иймд компанийн урт хугацааны А6-20 бизнес төлөвлөгөөнд тусгасан “олон улсын стандартад нийцсэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дэлхийн брэндийн түвшинд үйлдвэрлэж, зах зээлд хүргэн борлуулна” гэсэн зорилгод хүрэхийн тулд лабораторийн шинжилгээний дүнг бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд ашиглах нь зүйтэй байна.

Цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлээгээс ТЭЗҮ-д тусгасан ашиглалтын системийн дагуу Цанхийн зүүн болон баруун уурхайд олборлолтыг зохих хүчин чадлаар явуулж чадахгүй байна

2.40 Цанхийн зүүн хэсгийг ил уурхайгаар ашиглах ТЭЗҮ-ээр жилд 15 сая тонн, Цанхийн баруун хэсгийг ил уурхайгаар ашиглах ТЭЗҮ-ээр жилд 20 сая тонн нүүрсийг олборлох уул геологийн нөхцөл, ашиглах стратеги, түүний төлөвлөгөө, уулын ажил гүйцэтгэх тоног төхөөрөмжийн хүчин чадал, олборлолтын үйл ажиллагаа зэргийг уялдуулан уурхайн төслийн хамгийн их гүнийг 300 метрээр тогтоосон байна.

2.41 Уурхайн ашиглалтын эхний жилүүдэд бага, дунд оврын гидравлик экскаватор-автосамосвалын хослолыг ашиглаж байгаад том оврын цахилгаан экскаватор-автосамосвалын хослол руу шилжихээр төлөвлөсөн⁷ боловч цахилгааны эх үүсвэргүйгээс өнөөдрийг хүртэл том оврын цахилгаан экскаватор ашиглаж эхлээгүй байна. Иймээс Цанхийн зүүн болон баруун уурхайн олборлолтыг ТЭЗҮ-д заасан хүчин чадлаар ажиллуулж чадаагүй байна.

⁷ Цанхийн зүүн уурхайн хөрс хуулалтад ТЭЗҮ-ийн дагуу 48 м.куб, баруун уурхайд 44 м.куб багтаамж бүхий утгууртай цахилгаан экскаватор ашиглана. Төслийн эхний жилүүдэд жижиг, дунд (зүүн уурхайд 5 м.куб -35 м.куб баруун уурхайд 18-26 м.куб утгуурын багтаамжтай) хүчин чадлын гидравлик экскаваторууд ашиглан хөрс хуулна. Цахилгаан болон гидравлик⁷ экскаваторуудыг уурхайн уулын ажлын өрнөл, уурхайн хүчин чадлаас хамаарч гурван өөр төрлийн хүчин чадалтай (зүүн уурхайд 50 тонн, 150 тонн, 240 тонн, баруун уурхайд 90 тонн, 136 тонн, 227 тонн даацтай) самосвалуудтай хослон ажиллуулахаар сонгосон байна. Бага хүчин чадлын гидравлик экскаваторууд зүүн уурхайд 50 тонн-ын, баруун уурхайд 90 тонн, 136 тонн-ын самосвалуудын хослолыг ашиглалтын эхний жилүүдэд хөрс хуулалт ба нүүрс олборлолтод ашиглана. Олборлолтын хүчин чадал нэмэгдэх жилүүдэд уг машинууд туслах ажил болох үржил шимт хөрс хуулах, уурхайн байгууламжийн ажил, ангилан ялгах, олборлолт болон бусад уурхайн туслах чанарын газар шорооны ажлуудад ашиглана. Ордын онцлог, төслийн шаардлага, уурхайг ашиглах арга, сонгож авсан экскаватор-самосвалын хослолд нийцүүлэн бусад туслах тоног төхөөрөмжүүдийг сонгохоор тусгасан байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн талбайн газар эзэмших эрхийг бүрэн аваагүйгээс ашиглалтын лиценз бүхий талбайгаас иргэн, аж ахуй нэгжид эзэмших, ашиглах, өмчлөх хэлбэрээр 4,937.8 га газрыг олгожээ

2.42 АМГТГ-аас 2006 онд Эрдэнэс-Тавантолгой ХК-д ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн талбайд 68,471.43 га газрыг олгосон байна.

Хүснэгт 10. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Д/д	Уурхайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн нэр	Хэмжээ (га)	Олгосон огноо	Дуусах огноо
1	Цанхийн зүүн уурхай	MV-016883	Шар тээг	700.39	2006.08.29	2036.08.29
2		MV-011943	Таван толгой	2,036.33	2006.08.28	2036.08.28
3	Цанхийн баруун уурхай	MV-016881	Бор тээг-1	556.72	2006.08.29	2036.08.29
4		MV-016882	Таван толгой-1	2,447.13	2006.08.29	2036.08.29
5	Бусад ашиглалтын тусгай	MV-011953	Бор толгой	12,864.47	2006.08.29	2036.08.29
6	зөвшөөрөлтэй талбай	MV-011954	Бор тээг-1	22,901.37	2006.08.29	2036.08.29
7		MV-011955	Шар тээг	23,813.10	2006.08.29	2036.08.29
8		MV-011956	Таван толгой-1	3,151.92	2006.08.29	2036.08.29
Нийт талбайн хэмжээ				68,471.43	2006.08.29	2036.08.29

Эх сурвалж: АМГТГ

2.43 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн 68,471.43 га талбайгаас Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу газар эзэмших хүсэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга 26 нэгж талбарт тус компанид 7,898.2 га газрыг олгосон байна.

2.44 Харин Эрдэнэс-Тавантолгой ХК өөрийн тусгай зөвшөөрлийн талбайн газар эзэмших эрхийг бүрэн аваагүйгээс тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа болон бусад хэлбэрээр ашиглалтын талбайгаас 4,937.8 га буюу тусгай зөвшөөрөл бүхий газрын 7.2 хувийг иргэн, аж ахуй нэгжид эзэмших, ашиглах, өмчлөх хэлбэрээр олгожээ. (Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт 6-аас харна уу)

Үүнд:

- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-011943, MV-016883 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд 3 аж, ахуй нэгж, 1 иргэнд 39.2 га газрыг эзэмших;
- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-016881, MV-016882 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд 5 иргэн, 2 аж, ахуй нэгжид 17.3 га газрыг эзэмших, 54 иргэнд 4.1 га газрыг өмчлүүлж, 1 аж, ахуй нэгжид 2.1 га газрыг ашиглах;
- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-011953 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд 11 иргэн, 34 аж, ахуй нэгжид 1,786.9 га газрыг эзэмших, 6 иргэнд 0.3 га газрыг өмчлөх, 3 аж ахуй нэгжид 6.5 га газрыг ашиглах;
- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-011954 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд давхардсан тоогоор 6 аж, ахуй нэгж, 14 иргэнд 94.4 га газрыг эзэмших, 10 иргэнд 0.8 га газар өмчлүүлж, 7 аж, ахуй нэгжид 165.8 га газар ашиглах;
- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-011955 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд давхардсан тоогоор 55 аж, ахуй нэгж, 18 иргэнд 2,820.4 га газрыг эзэмших;
- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн MV-011956 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд 1 аж ахуйн нэгжид 100.8 га газрыг эзэмших хэлбэрээр тус тус олгосон байна.

2.45 Энэ нь компани өөрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий газрын эзэмших эрхийг бүрэн баталгаажуулаагүйгээс шалтгаалсан бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайд иргэн, аж ахуй нэгжид эзэмших, ашиглах, өмчлөх хэлбэрээр газар олгосон нь уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад саад учруулах, газрыг чөлөөлөхөд их хэмжээний нөхөн төлбөр төлөх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад хугацаа алдах эрсдэлтэй нөхцөлийг бий болгожээ. Тухайлбал, Тавантолгойн бүлэг ордын нэг хэсэг болох Онч хараатын ордын хэсгийн тусгай зөвшөөрлийн MV-11955 дугаартай 1990 болон 2014 оны хайгуулын өрөмдлөгөөр тогтоогдсон нүүрсний давхарга дээр Шунхлай петролиум ХХК 13.8 га, Рэйлвэй сөүл менежмент ХХК 23.2 га, тусгай зөвшөөрлийн MV-11943 дугаартай нүүрсний давхарга дээр иргэн Д.Болор 2.3 га, нийт 39.2 га газрыг эзэмших эрхээр авч, бүтээн байгуулалтын ажил хийж байна.

2.46 Иймд Эрдэнэс-Тавантолгой ХК нь АМТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.12-д “Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд газар ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасны дагуу тусгай зөвшөөрөл бүхий талбайн газар ашиглах эрхээ улсын бүртгэлд бүртгүүлэх нь зүйтэй байна.

Хэт олон автомашинаар нүүрсийг тээвэрлэж байгаагаас байгаль орчинд нөлөөлөх эрсдэл нэмэгдэж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна

2.47 Эрдэнэс-Тавантолгой ХК-аас олборлосон нүүрсийг 2018 онд 10,955, 2019 онд 8,179, 2020 он 8,608, 2021 онд 9,890, 2022 онд 8,807 (давхардаагүй тоогоор) тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн байна. Харин ойролцоо орших Энержи ресурс ХХК нь 2018, 2019 онд 433 тээврийн хэрэгслээр, орон нутгийн өмчит Тавантолгой ХК 2018 онд 4,953, 2019 онд 3,282 тээврийн хэрэгслээр нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэжээ.

График 13. Нүүрс тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн тоо болон бүтээмж



Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн цахим систем

2.48 Бүтээмжийн хувьд нэг тээврийн хэрэгслийн тээвэрлэсэн нүүрсний дундаж хэмжээ Эрдэнэс-Тавантолгой ХК-д 2018-2022 оны 5 жилийн дунджаар 1,360.8 тонн, Энержи ресурс ХХК-д 9,794.9 тонн, харин Тавантолгой ХК-ийн хувьд 597.1 тонн байна.

2.49 Энэ нь Эрдэнэс-Тавантолгой ХК нүүрс борлуулах гэрээг “ам” нөхцөлөөр хийсэн, уурхай эзэмшигч өөрийн тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээнд тохируулан тээвэрлэгчтэй гэрээ байгуулаагүйгээс шалтгаалж, худалдан авагч тал болох 2018 онд 140, 2019 онд 177, 2020 онд 270, 2021 онд 634, 2022 онд 420 аж ахуйн

нэгжтэй тээвэрлэх гэрээ байгуулж, олон тооны тээврийн хэрэгслээр нүүрс зөөвөрлөсөнтэй холбоотой байна.

2.50 Мөн 2020 онд Мааньт, Ханги-Мандал, Чойр, Шивээговь чиглэлд 1591 тээврийн хэрэгслээр 189.5 мянган тонн, 2021 онд 4287 тээврийн хэрэгслээр 1603.6 мянган тонн нүүрс тээвэрлэснээс хүнд даацын тээврийн хэрэгслүүд их хэмжээний тоос шороо босгох, хөрсний эвдрэл үүсгэх, бэлчээр талхлах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.51 Харин 2022 онд Зүүнбаян, Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд дууссан хэдий ч зориулалтын бус замаар 3594 тээврийн хэрэгсэл 16,230 удаагийн рейсээр 3,594.0 мянган тонн нүүрсийг Мааньт, Өргөн, Ханги, Чойр чиглэлд тээвэрлэсэн байна.

2.52 Хүний эрхийн үндэсний комиссын захиалгаар 2018 онд Бодлогын инновацийн хүрээлэнгээс хийсэн “Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөл байдлын үнэлгээ” судалгааны тайлангаас харахад:

Энержи ресурс ХХК-аас бусад нүүрсээ тээвэрлүүлж буй компаниуд нүүрс худалдан авагч болон тээвэрлэгч компаниудаар холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж чадахгүй байгаагаас хөдөлгөөний

болон хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдаж, жолооч нарын эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх эрх зөрчилдсөн:

- Гашуунсухайтын нүүрс тээвэрлэлтийн зам эвдрэл ихтэй, тэмдэг тэмдэглэгээ байхгүй, жолооч нар ажил, амралтын горим баримталдаггүйгээс сард 125 орчим зам тээврийн осол гарч, 1 хүний амь эрсэддэг, зам дагуу хогийн цэгүүд болон нийтийн бие засах байхгүйгээс орчны бохирдол ихтэй, зам дагуу эмнэлгийн болон онцгой байдлын салбар нэгж байхгүй;
- Цагаан хадны нүүрс дамжуулан тээвэрлэх газруудад байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ огт хийгээгүй;
- Зөвхөн Энержи ресурс ХХК-ийн жолооч нарын хувьд тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоог тогтмол хийдэг, хөдөлмөр-амралтын горимыг мөрдүүлдэг, стандартын амралтын байраар хангагдсан, бусад жолооч нарт Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн болон цалингийн нөхцөл хангагдаагүй, нийт тээвэрлэлт хийж буй жолооч нарын 90 хувь нь эрүүл мэндийн анхан шатны тусламж, оношилгоо, эмчилгээнд хамрагдах боломжгүй;
- 2018 онд ЗТХЯ-аас хийсэн шалгалтаар нүүрс тээвэрлэлт хийж байгаа аж ахуйн нэгжүүдийн 60 орчим хувь нь стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэлтэй байсан;

Уурхайн олборлолт хийж буй 3 том компани агаарын чанар, тоосжилтын хэмжилт хийхдээ хэмжилтийн агуулга, хүрээ, аргачлал, үр дүнгийн мэдээллийн ил тод байдал хангалтгүй, уурхай бүрд өөр өөр хэмжилт хийдэг байна. Тухайлбал,

- Тавантолгойн бүлэг ордоос хилийн боомт хүртэлх 240 орчим км газарт зарим хэсэгтээ 41 км хүртэл өргөнтэй газар нутаг уурхайн нөлөөлөлд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэлд орж тоосжилт үүссэн.
- Дээрх уурхайнууд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, менежментийн төлөвлөгөөний дагуу уурхайн орчмын нарийн болон том ширхэгт тоосонцрын хэмжилтийг сар бүр, хүхэрлэг хий, нүүрстөрөгчийн дутуу исэл, азотын давхар ислийн хэмжилтийг хагас жилд нэг удаа, хөндлөнгийн хяналтыг жилд 2 удаа хийж байгаа ч салхины чиглэлийн хувьд баруун урдаас буюу уурхайн зүгээс салхилах үед хэмжилт хийсэн нэг ч тохиолдол байхгүй, хэмжилтийн агуулга, хүрээ, аргачлал, үр дүн ил тод бус байна.
- Цогтцэций сум орчмын тоосжилт хавар, зуны саруудад зөвшөөрөгдөх хэмжээнээс дунджаар 2.3 дахин хэтэрдэг боловч Агаарын тухай хуульд орон нутгийн нөлөөллийн бүсүүдэд тоосжилтыг хянах, бууруулах чиглэлээр авах арга хэмжээг орхигдуулсан, Байгаль орчны тухай хууль, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар аж ахуйн нэгжүүд гадаад, дотоод орчин дахь хими, физикийн гаралтай түгээмэл бохирдуулагч зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг хянах үүрэгтэй байдгаас тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй байна.
- Тоосонцроос үүдэлтэй амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөлийн тоо 2010 онд 841 гарч байсан бол 2017 онд 1691 тохиолдол болж өссөн.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын хүн ам болон түр оршин суугчдын тоо өссөнөөс сумын эрүүл мэндийн төвийн ачаалал нэмэгдэж, хүний нөөц, төсөв хүрэлцээгүйн улмаас эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон:

- Өмнөговь аймгийн Цогтцэций сум 2010 онд буюу уурхайн үйл ажиллагаа эхлэхэд 3366 хүн амтай байсан бол 2017 онд хүн амын тоо 7422, өрхийн тоо 2441 болж, уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалж 8000-10000 орчим хөдөлгөөнт хүн ам тус суманд ажиллаж, амьдарч байна. Хөдөлгөөнт хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зардал эрүүл мэндийн байгууллагын төсөвт тусдаагүй учраас төсөв, хүний нөөц хүрэлцээгүй байна.

Эх сурвалж: Хүний эрхийн Үндэсний комиссын захиалгаар 2012 онд НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хийсэн "Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас Хүний эрхэд үзүүлэх нөлөө", 2018 онд Бодлогын инновацын хүрээлэнгээс хийсэн "Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ" судалгааны ажлын тайлан

2.53 Шинжлэх ухааны академийн Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн цөлжилтийн судалгааны салбар, хөрс судлалын салбарын эрдэмтдийн 2017 онд хийсэн "Өмнөговь аймгийн цөлжилт, газрын доройтлын төлөв байдлын үнэлгээ"-ний тайлангаар Цогтцэций сумын төвийн суурьшлын бүсийн талбай 2000 онд 72.8 га байсан бол уул уурхайн нөлөөгөөр 2016 онд 1,103.5 га, уурхайн олборлолтын бүс нутагт эвдэрсэн хөрс бүхий талбай 11,615.2 га болж нэмэгдэн, бэлчээрийн эдэлбэр газрын хэмжээ багассан байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК болон эрх бүхий байгууллагууд хяналтаа бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажлын үр дүн хангалтгүй байна

2.54 Эрдэнэс-Тавантолгой ХК нь 2011 онд Их Айлчин ХХК-аар, 2012 онд Натур Фрейндли ХХК-аар Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн баруун, зүүн хэсгийг ил уурхайгаар ашиглах төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн бөгөөд тус тайлангаар уурхайн үйл ажиллагааны явцад хүн амын эрүүл мэнд, байгаль

орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тодорхойлж, уг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ хэрэгжүүлэх талаарх зөвлөмж өгсөн байна.

2.55 Эрдэнэс-Тавантолгой ХК дээрх үнэлгээний тайланд үндэслэн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хуульд заасны дагуу боловсруулж, АМТХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.1.5⁸, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”⁹-д заасны дагуу холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан байна.

2.56 Гэвч уурхайн үйл ажиллагаа эхлээд 10 жил болсон, Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн баруун, зүүн хэсгийн ТЭЗҮ-ийг 2020, 2021 онд шинэчлэн тодотгосон боловч Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг шинэчлэн боловсруулаагүй байх тул үнэлгээг шинэчилж, мөрдөж ажиллах нь зүйтэй байна.

2.57 Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг компанийн жил бүрийн БОМТ-ний биелэлтийг үнэлж, 2018 онд 81.3 хувь, 2019 онд 90.2 хувь, 2020 онд 91.6 хувь, 2021 онд 90.2 хувь, 2022 онд 90.5 хувьтай “хангалттай” гэж дүгнэж, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараа жилийнх нь төлөвлөгөөг баталсан байна.

2.58 Гэвч БОМТ-ний биелэлтийг ажлын хэсэг дүгнэхдээ зарим заалтыг “хангалтгүй” үнэлж, өгсөн зөвлөмж, хэрэгжүүлбэл зохих ажлуудыг 2019 оноос хойш өнөөг хүртэл биелүүлээгүй хэвээр байгаагаас түүвэрлэн үзүүлбэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан хэрэгжилт бүрэн хангагдаагүй ажил болон өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдал

Он	Хангалтгүй дүгнэгдсэн ажил	Биелэлтийн хувь	Хэрэгжүүлээгүй зөвлөмж
2018	Олон салаа зам гаргаснаас хөрсний элэгдэл, эвдрэл их, төлөвлөгөөнд туссан модлог ургамлын нөөц бүрдүүлэх ажил хангалтгүй, хайгуулын үеийн нөхөн сэргээлтийг орон нутагт хүлээлгэн өгөөгүй	70.0	
	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө гаргаагүй	70.0	
	Багуудын хуралд БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах ажил хийгээгүй	66.6	
2019	Техникийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж дуусаагүй	29.0	Уурхай болон лицензийн талбайн хэмжээнд эвдрэлд орж ашиглагдахгүй байгаа газрын техникийн нөхөн сэргээлт хийх
	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд туссан уст цэгийн судалгаа, бэлчээрийн судалгаа, мониторингийн судалгаа огт хийгээгүй	6.3	Хурын ус хуримтлуулах байгууламж /хөв цөөрөм/ байгуулах Сая тонн-Сая мод хөтөлбөрийн хүрээнд тарьсан 60,000 модны усалгаа, арчилгааг тогтмол хийж ургалтын хувийг нэмэгдүүлэх Хаягдал ус зайлуулах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулж, хаягдал усыг зориулалтын газарт нийлүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг гэрээт компаниудад үүрэг болгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
2020	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй	77.0	Сумын төвийн засмал замын дагуу хог хаягдлын ангилан ялгах зориулалт бүхий хогийн савыг байршуулах Туслан гүйцэтгэгч компаниудтай хамтран 2021 онд цэвэрлэх байгууламж барих ТЭЗҮ-г

⁸ Энэ хуулийн 39.1.1-д заасны дагуу боловсруулсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

⁹ 2.2-д Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон нэмэлт тодотгол үнэлгээний ажлын үр дүнгээр боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ. 2.5. Нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэхээр зөвшөөрөгдсөн төслийн тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор хүргүүлнэ.

					боловсруулж байгууламжийн эхлүүлэх	батлуулах, барилга угсралтын ажлыг	цэвэрлэх ажлыг
2021	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй	70.0	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй	50.0	Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хог хаягдлын нэгдсэн төв (хуучин хог хаягдлыг дарж булах, ландфилын цэг, ангилан ялгах, дахин боловсруулах) байгуулах ажлыг Энержи ресурс ХХК Тавантолгой ХК-уудтай хамтран хэрэгжүүлэх, БОАЖГ, Цогтцэций сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулах.		
2022	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт хангалтгүй	50.0					

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланд өгсөн үнэлгээ

2.59 Дээр дурдсан ажлуудаас нэн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын явцыг авч үзвэл,

- Уурхайн талбай болон лицензийн талбайн хэмжээнд эвдрэлд орж ашиглахгүй байгаа газраас нүүрс тээврийн хуучин 100 км замыг нөхөн сэргээхээр төлөвлөснөөс 40 км замд нөхөн сэргээлт хийсэн, Баруун, зүүн Цанх, Бортээгийн уурхайн нийт 1560 га талбайг хамарсан, 451.7 сая м.куб эзлэхүүнтэй 4 овоолгын талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийж эхлээгүй;
- Уурхай байрлаж буй Цогтцэций сумын хогийн цэгт тус суманд ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй уурхайнууд хог хаягдлаа төвлөрүүлж, хогийн цэг бүрэн дүүрч, талбайгүй болсноос байгаль орчныг бохирдуулж байна. Уурхайн хог хаягдал нийт хог хаягдлын 50-аас дээш хувийг эзэлж байна.



2.60 Энэ нь БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.12¹⁰, БОХТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.11¹¹-д заасны дагуу орон нутгийн засаг захиргаа, МХБ-ууд хяналтаа бүрэн хэрэгжүүлээгүй, нөгөө талаас компани Байгаль орныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.12¹²-д заасан эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

2.61 АМТХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.3-т “Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.9-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна” гэж заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохих арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

2.62 БОХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Байгаль орчны аудитыг ... хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ” гэж заасны дагуу компани 2018 онд Эко акюрэси ХХК-тай 15.0 сая төгрөг, 2020 онд БОАД ХХК-тай 25.6 сая төгрөг, нийт 40.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, аудит хийлгэсэн боловч өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх талаар тайлагнаагүй байна. Харин 2022 онд тендер шалгаруулалтын хугацаа оройдсон, зарлаагүй гэх шалтгаанаар байгаль орчны аудит хийлгээгүй байна.

¹⁰ Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.

¹¹ Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

¹² байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

2.63 Иймд хуульд заасны дагуу 2 жил тутам аудит хийлгэж, аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаж, үр нөлөөг тооцож хэвших ажлыг зохион байгуулах нь зүйтэй байна.

Хуулийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны хөрөнгийн төвлөрүүлэлт хангалтгүй, буцаан олголтын талаарх эрх зүйн орчин тодорхойгүй байна

2.64 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хуулийн дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 12. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 2018-2022 онд төвлөрүүлсэн барьцаа хөрөнгийн мэдээлэл, сая төгрөг

Он	БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардал	Нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлбэл зохих дүн	Компаниас нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгө (2022.12.31)	БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансны хуулгаар мөнгөн дүн (2022.12.31)	Аудитаар илрүүлсэн нэмж төвлөрүүлбэл зохих хөрөнгийн дүн
2018	622.9	311.5	397.9	397.9	
2019	878.0	439.0	41.1	41.1	
2020	841.3	420.7	150.0	150.0	
2021	752.7	376.4	-	-	
2022	1,137.6	568.8	-	-	
Бүгд	4,232.5	2,116.3	589.0	589.0	1,527.3

Эх сурвалж: БОМТ 2018-2022 он, БОАЖЯ-наас ирүүлсэн тусгай дансны хуулга (2012-2022 он), Эрдэнэс-Тавантолгой ХК-аас ирүүлсэн баримт

2.65 Компани 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 589.0 сая төгрөг төвлөрүүлсэн бөгөөд хуулийн дагуу төвлөрүүлбэл зохих 1,527.3 сая төгрөгийг байршуулаагүй тул хөрөнгийг нөхөн төвлөрүүлэх талаар хугацаатай албан шаардлагыг Санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүллээ.

2.66 АМТХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.4, БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.11-д байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршиж буй барьцаа хөрөнгийг уурхайн хаалтын үе шатанд буцаан олгохоор заасан байхад БОНХС-ын 2014 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 3.1-д тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлийг харгалзан буцаан олгохоор заасан нь хоорондоо нийцэхгүй байна.

2.67 Иймд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд хөрөнгө төвлөрүүлэх, буцаан олгох талаарх хууль, журмын заалтыг нийцүүлэх, эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлагатай байна.

2.68 Мөн БОАЖЯ хуулиар дээрх Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд хөрөнгийг хөдөлгөөнгүй байршуулж байгаа нь мөнгөний ханшийн уналттай үед уурхайн хаалтын үед ашиглах хөрөнгө хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байна.

Компани байгаль орчныг хамгаалах ажлыг төлөвлөсөн хэмжээнд гүйцэтгээгүй, тайлагнал бодитой бус, зарим хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй болжээ

2.69 Компанийн байгаль орчныг хамгаалах зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 5 жилээр авч үзэхэд дараах байдалтай байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хүснэгт 13. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны байгаль орчныг хамгаалах зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг, хувь

Он	Төсвийн гүйцэтгэлийн тайлан				БОМТ, түүний биелэлтийн тайлан				Гүйцэтгэл зөрүү
	Төлөв	Гүйцэтгэл	Хэмнэлт (+), хэтрэлт (-)	Биелэлт, хувь	Төлөв	Гүйцэтгэл	Хэмнэлт (+), хэтрэлт (-)	Биелэлт, хувь	
2018	120.2	97.2	23.0	80.9	622.9	269.2	353.7	43.2	172.0
2019	143.0	77.4	65.6	54.1	877.4	861.4	16.0	98.2	784.0
2020	2,067.6	2,486.9	(419.3)	120.3	841.3	644.3	197.0	76.6	1,842.6
2021	1,303.3	405.7	897.6	31.1	752.7	735.9	16.8	97.8	330.2
2022	1,771.6	174.8	1,596.8	9.9	1,137.6	1,231.1	(93.5)	108.2	1,056.3
Дүн	5,405.7	3,242.0			4,231.9	3,741.9			4,185.1

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, БОМТ, түүний биелэлтийн тайлан, 2018-2022 он

2.70 Хүснэгтээс харахад тайлант онд байгаль орчныг хамгаалах ажлыг төлөвлөсөн хэмжээнд гүйцэтгээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар биелэлт дунджаар 59.3 хувьтай байхад байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлтийн тайлангаар хэрэгжилт дунджаар 84.8 хувьтай, 4,185.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь БОМТ-ний биелэлтийн тайланд тухайн онд хэрэгжүүлээгүй ажлыг дараа онд хэрэгжүүлсэн байхаар тооцож, төлөвлөн нийт ажилд оруулан тайлагнаж байгаатай холбоотой байна.

2.71 Компани 2019 онд IPO гаргахтай холбоотой “Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үнэлгээний тайлан” боловсруулах зөвлөх үйлчилгээний ЭТТ-2019/779 дугаартай гэрээг Экологийн бүтээмж ХХК-тай 2,394.0 сая төгрөгийн дүнтэй байгуулж, 2,175.8 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн боловч гэрээ болон ажлын даалгаварт заасны дагуу гүйцэтгээгүй, чанар, стандартын шаардлагыг бүрэн хангаагүй, үргүй зардал болсон байна. Тухайлбал,

- Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үнэлгээний тайланг хэрхэн хүлээж авсан талаар хүлээлцсэн акт, гэрээ дүнгэсэн тэмдэглэл архивд байхгүй;
- Зөвлөх үйлчилгээний гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хооронд буюу өвлийн улиралд хийж гүйцэтгэхээр байгуулсан байгаа нь цаг хугацааны хувьд тохиромжгүй;
- Гэрээний 6.5-д тайланг англи, монгол хэл дээр гарган өгөх үүрэгтэй байгаа ч аль хувилбарыг албан хувь гэж үзэх эсэхийг гэрээнд тодорхой заагаагүй, англи, монгол хэл дээрх тайлангуудын нэршил зөрүүтэй, /Англи хувь “Байгаль орчны нийгмийн нөлөөллийн үнэлгээ-Environmental and social impact assessment, Монгол хувь “Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ”, англи тайлангийн агуулгын товчгө байхгүй, хуудас дугаарлалт алдаатай, хүснэгт, зураг, дүрслэлийн мэдээллийн гарчиг монгол хэл дээр, монгол тайлан хуудас дарааллын алдаатай үдэгдсэн зэрэг;
- Төслийн БОНЭЗНУ-ний тайланд тавигдах гол шаардлага нь уг тайлан нь Монгол Улсын холбогдох хууль, журам, стандартуудыг хангасан байхаас гадна Олон Улсын санхүүгийн корпорацийн гүйцэтгэлийн стандарт, заавруудыг хангасан байх шаардлагатай бөгөөд ингэснээр төсөл хэрэгжүүлэгчдэд Олон Улсын санхүүгийн байгууллагаас шаардлагатай санхүүжилт босгох боломжийг олгодог. Гэвч тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, Байгаль орчны нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхэд тавигдах Олон Улсын шаардлагад нийцээгүй ажлыг иж бүрэн гүйцэтгээгүй байна. Тухайлбал,
 - ✓ Төслийн бүрэлдэхүүн хэсэг, хүлэмжийн хийн ялгаралтыг техник, технологийн талаас тодорхойлж, тоогоор илэрхийлэх;
 - ✓ Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллүүдийг матрицын болон магадлан жагсаах аргаар олж тогтоох, тэдгээрийн харилцан үйлчлэлд дүн шинжилгээ хийж эрэмбэлэх;
 - ✓ Орон нутгийн ард иргэд болон төсөлд ажиллагсдын эрүүл, мэнд, аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийх, аюулгүй ажиллагааг хангахын тулд нөлөөллийг бууруулах арга хэмжээ боловсруулах;
 - ✓ Төслийн хөгжлийн явцад орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудын арга зам, хэлбэрийг тодорхойлох;
 - ✓ Төслийн эрчим хүчний хэрэглээг тооцох;
 - ✓ Аюултай хог хаягдлын тооцоолол хийх;
 - ✓ Ханган нийлүүлэлттэй (шахах тослох материал) холбоотой байгаль орчны эрсдэлийн үнэлгээ хийх зэрэг ажлуудыг гүйцэтгээгүй байна.

2.72 Компани 2022 оны 8 дугаар сарын 02-ны өдөр ЭТТ-2022/567 дугаартай **Тавантолгой ордын нүүрсний уурхайг гадаргын үерийн уснаас хамгаалах, түүнийг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулах** ажил гүйцэтгэх гэрээг 4,220.2 сая төгрөгийн дүнтэйгээр 2 жилийн хугацаатай Бодь плантиниум ХХК-тай байгуулсан байна. Тус байгууламжийн ажлын төсөвт өртөг 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 1357/2020 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр 5,091.2 сая төгрөгөөр баталгаажсан байна.

2.73 Гэтэл барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний хавсралт, ажлын даалгаварт 1 үерийн хамгаалалтын далан суваг, 8 ширхэг сайруудын усыг хуримтлуулах боомт нийтдээ 9 байгууламж барихаар төлөвлөснөөс 2022 онд Улаан нуурын сангийн боомт болон Жирмийн булгийн усан сангийн боомтын барилга бүтээцийн ажлуудыг гүйцэтгэж, нэмэлт 1 байршил буюу нийт 10 байршилд болгон өөрчилж, Грийн центрийн урд талбайд хиймэл нуур хөв цөөрөм байгуулах ажлыг батлагдсан зураг төсөвгүйгээр, нэмэлт ажлын гэрээ байгуулалгүй хийж гүйцэтгэсэн, төлөвлөлт оновчгүй, судалгаа тооцоолол муу хийсэн зэргээс шалтгаалан хууль хяналтын байгууллагад шалгагдаж байна. Улаан нуурын болон Жирмийн булгийн боомтын усан сангийн барилга бүтээцийн ажлын гүйцэтгэл 80.0 хувьтай байна.

2.74 Аудитаар ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь танилцахад дараах байдалтай байна. Үүнд:

- 2021 онд 58.3 сая төгрөгөөр уурхайн агаарын чанарыг хянах зорилгоор Тоос хэмжилтийн төхөөрөмж худалдан авсан боловч 17.9 сая төгрөгийн нэмэлт зардлаар үйлдвэрийн баталгаажилт хийж байгаа шалтгаанаар ашиглаж эхлээгүй;
- Тоос бууруулах бодис туршихаар 2019-2020 онд Спецпродукт Монгол ХХК-тай 50.0 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулсан боловч үр дүнгүй, мөн 2022 онд хийсэн туршилтын ажил үр дүнгүй болсон;
- БОМТ-ний дагуу 350.0 сая төгрөгийн өртөгтэй ойн зурвас бүс бий болгох зорилгоор хийсэн Дүйцүүлэн хамгаалах ажлын 4784 ширхэг суулгац, мод үржүүлгийн талбайд суулгасан боловч арчилгаа тордолт хангалтгүй, ургалтын хувь муу, зарцуулсан хөрөнгө үрэгүйдэх магадлалтай;
- Уурхайн талбайд нийт 15 шимт хөрсний овоолго бий болсон бөгөөд арчилгаа тордолт, хөрсийг хамгаалах, хадгалах ажлыг бүрэн хийгээгүй байна.

2.75 Цаашид байгаль орчныг хамгаалах чиглэлээр зарцуулах хөрөнгийг үр ашигтай төлөвлөх, арвилан хэмнэлттэй байх зарчмыг баримтлан, хэрэгжилтийг бүрэн хангуулах, бодитой тайлагнахад анхаарч, үр нөлөөг тооцдог байх нь зүйтэй.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль, журамд заасны дагуу уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулаагүй, хуримтлалын сангийн тооцооллыг бодитой хийгээгүй байна

2.76 Эрдэнэс-Тавантолгой ХК нь УУХҮС, БОАЖС нарын хамтарсан 2019 оны А/181, А/458 дугаар тушаалаар баталсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын 4.1-д Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн явцын болон хаалтын нөхөн сэргээлтийг БОХБҮТХ-ийн 9.4-д заасан журам, аргачлал болон холбогдох бусад хууль, журам, стандартын дагуу төлөвлөж, хаалтын менежментийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийг хангана”, 4.2-т “Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн явцын болон хаалтын нөхөн сэргээлтийн зардлыг энэ журам болон БОХТХ-ийн 15.1.2, 15.1.3-д заасан журмын дагуу тус тус тооцоолж хаалтын менежментийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийг хангана” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.77 ТЭЗҮ-д Уурхайн хаалтын менежмент, нөхөн сэргээлтийн нарийвчилсан зураг, төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр заасны дагуу компани 2019 онд ЭТТ-2019/782 дугаартай “Уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн сан үүсгэх” зөвлөх үйлчилгээний гэрээг Евро-хан ХХК-тай 799.4 сая төгрөгөөр байгуулж, 239.8 сая төгрөгийн урьдчилгаа

олгосон боловч хэрэгжилт хангагдаагүй үргүй зардал болж, өнөөг хүртэл уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулаагүй байна.

2.78 Иймд Евро-хан ХХК-тай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээний үүргийн биелэлтийг тооцож, гэрээг дүгнэн олгосон урьдчилгаа төлбөрийг гэрээнд заасны дагуу нөхөн төлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

2.79 Мөн дээрх журмын 5.8-д *“Төсөл хэрэгжүүлэгч нь уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хаалтын зардлын хэмжээгээр хаалтын зардлын хуримтлал үүсгэж, хаалтын санг байгуулна”* гэж заасны дагуу уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн хуримтлалын сан үүсгэн ажиллаж байгаа боловч тооцооллыг хийхдээ уурхайн ашиглалтын үйл ажиллагаа эхэлснээс хойших эвдрэлд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг одоогийн байдлаар тооцоолоогүй, зөвхөн 2021 онд тодотгосон ТЭЗҮ-д туссан уурхайн хаалтын болон нөхөн сэргээлтийн зардлын дүнг уурхайн ашиглалтын хугацаанд тэнцүү хуваарилан (52 жил, 43 жил) тооцсон байна.

2.80 Энэ нь дээрх журмын 5.4-д *“... зардлыг Сангийн сайдын 2016 оны 409 тушаалаар батлагдсан Хайгуулын болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын холбогдох стандартын дагуу бүртгэнэ”, 5.5-д “Хаалтын зардлыг тооцохдоо гуравдагч этгээд хаалтын ажлыг гүйцэтгүүлэхээр, өнөөгийн үнэ цэнээр тооцоолно”* гэж заасныг мөрдөөгүй, НББОУС 37-д заасан нөөцийг хүлээн зөвшөөрөх *“Өнгөрсөн үйл явдлын өнөөгийн үүрэг хариуцлага”* гэсэн шалгуурыг тус тус хангаагүй байна.

2.81 Иймд уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох журам, стандартад заасны дагуу хуримтлалын сангийн тооцооллыг бодитой хийж, хөрөнгийн хуримтлал үүсгэх шаардлагатай байна.

“Сая тонн-Сая мод” хөтөлбөрийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө, ТЭЗҮ батлагдаагүй, ажлын гүйцэтгэл хангалтгүй, түүнд тавих хяналт сул байна

2.82 Компани “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд “Сая тонн-Сая мод” хөтөлбөрийг хэрэгжүүлэн 180.0 сая мод тарихаар төлөвлөж, 2022 онд ТУЗ-өөр 32.7 тэрбум төгрөгийн төсөв батлуулж, гүйцэтгэлээр 28.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнд:

- ОБЕГ-тай 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр 28,045.8 сая төгрөгийн дүнтэй ЭТТ-2022/503 дугаар хамтран ажиллах гэрээ байгуулж 27.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон боловч гэрээний үүргийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй;
- Батлан хамгаалах яамтай 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдөр 9,972.8 сая төгрөгийн дүнтэй ЭТТ-2022/113 дугаар хамтран ажиллах гэрээ байгуулж 0.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгожээ.

2.83 Санхүүжүүлэгч байгууллагын хувьд гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулах, түүнд тавих хяналтыг сайжруулан арвилан хэмнэлттэй ажиллах зарчмыг баримтлан, үр дүн, үр нөлөөг тооцож ажиллах нь зүйтэй байна.

2.84 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд олон эх үүсвэрээс төрийн байгууллагууд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа тул тусгайлан эрсдэлийн аудит хийх шаардлагатай байна.

Тусгай зөвшөөрөл шилжүүлэх эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйгээс төлбөл зохих албан татварыг төлөөгүй байна

2.85 Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн “Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 296 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой

ХК-ийн хувьцааг гадаад улсын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, арилжаалах бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд **холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн** охин компани байгуулж, олон улсын хөрөнгийн зах зээлээс боломжит богино хугацаанд хамгийн бага зардлаар хөрөнгө босгох, Цанхийн зүүн хэсгийн MV-011943 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг охин компанид эзэмшүүлэхээр заасан.

2.86 Эрдэнэс-Тавантолгой ХК нь дээрх тогтоолын дагуу Эрдэнэс-Тавантолгой Майнинг охин компанийг байгуулж, 2019 онд өөрийн эзэмшлийн ашигт малтмалын ашиглалтын MV-011943 дугаартай тусгай зөвшөөрлийг шилжүүлэхдээ АМТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.3-т **“Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, баримт бичгийн хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан татвар төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид нь шилжүүлж болно”** гэж заасныг зөрчиж холбогдох татварыг төлөөгүй шилжүүлсэн байна.

2.87 АМТХ-д ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг худалдан борлуулж байгаа үед зохих албан татварыг төлсөн нь нотлогдсон тохиолдолд шилжүүлж болохоор зааснаас өөрөөр Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжүүлж болох эсэхийг заагаагүй нь хуулийн тус заалтыг зөрчихөд хүргэсэн байна.

Засгийн газрын эрх мэдлээ хэтрүүлэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бууруулсан байна

2.88 АМТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.2.1¹³-д экспортод бүтээгдэхүүн гаргасан бол Олон улсын жишиг үнэ, мөн хуулийн 47.2.2¹⁴ -т дотоодод борлуулсан буюу ашигласан бол дотоодын зах зээлийн үнийг, 47.2.3¹⁵ -т дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд гэрээний үнэд үндэслэн Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцохоор тодорхой заасан байна.

2.89 Засгийн газар нь эрх мэдлээ хэтрүүлэн 2014 оны 220, 2015 оны 102, 103, 2019 оны 342, 465 дугаар тогтоолуудаар нүүрс, төмрийн хүдэр, төмрийн баяжмалын хувьд АМНАТ -ийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үнээр тооцсон борлуулалтын үнэлгээнээс ногдуулж тооцох нөхцөлийг бүрдүүлж, бусад ашигт малтмал экспортлогч ААН-үүдэд давуу байдал олгосныг Засгийн газрын **“Тогтоол хүчингүй болгох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай”** 2021 оны 174 дүгээр тогтоолоор зогсоож, хуулийн дагуу АМНАТ-ыг ногдуулах боломж бүрдсэн байна.

2.90 Гэсэн хэдий ч Засгийн газрын дээрх хуулиас давсан шийдвэр нь зөвхөн Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьд 2018-2021 онд экспортолсон нүүрсэнд ногдох 419.7 тэрбум төгрөгийн АМНАТ-ыг улсын төсөвт төлөхгүй байх нөхцөл болсон байна.

Хүснэгт 14. Ногдуулсан болон жишиг үнээр тооцсон АМНАТ-ын зөрүүгийн тооцоо

Он	Тоо хэмжээ, сая тонн	Ногдсон АМНАТ, сая төгрөг	Жишиг үнээр тооцсон АМНАТ, сая төгрөг	Зөрүү, сая төгрөг
2018	13.1	227,500.8	366,737.8	139,237.0
2019	15.3	286,743.4	473,839.9	187,096.4
2020	11.1	271,962.1	327,203.4	55,241.3
2021	5.2	189,843.2	228,009.0	38,165.8
Нийт	44.6	976,049.6	1,395,790.1	419,740.5

Эх сурвалж: Аудитын тооцоолол

¹³ Экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан

¹⁴ Дотоодод борлуулсан буюу ашигласан бол тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэн

¹⁵ Дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэн

2.91 УИХ-аас Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр баталснаар ус, рашааны нөөцийг ашиглан хаягдал ус гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч иргэн, ААНБ ус бохирдуулсны төлбөр төлөхөөр хуульчилсан.

2.92 Гэвч хууль хэрэгжиж эхэлснээс хойш 8 жилийн дараа Эрдэнэс-Тавантолгой ХК-д ус бохирдуулсны төлбөрийг 2020 оны сүүлийн хагас жилээс эхлэн 2020 онд 2.9 сая, 2021 онд 4.7 сая, 2022 онд 2.5 сая, нийт 10.1 сая төгрөгийг төлөхөөр ногдуулсан нь “Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам”, Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцох аргачлал”-ыг БОАЖС, Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/406/226 дугаар хамтарсан тушаалаар баталсантай холбоотой байна.

2.93 Хуулийн хэрэгжилт хойшилсноор орон нутгийн төсөвт ойролцоогоор 27.9 сая төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлээгүй байна.

2.94 Тус компани дээрх ус бохирдуулсны төлбөрт лабораторийн шинжилгээгээр баталгаажсан ашигласан усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрлөөс хамаарч, 1 шоо метр тутамд 20-1000 төгрөг төлж байгаа ч лабораторийн шинжилгээг тогтмол авч баталгаажуулаагүй, хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулаагүй, ашигласан усны хэмжээ уурхайн хүний нөөц өссөөр байхад буурсан үзүүлэлттэй байгаа нь тооцооллыг бодитой хийсэн гэж үзэхээргүй байна. Тухайлбал,

2021 онд Усны газраас ирүүлсэн хаягдал усны дүгнэлтээр:

- Хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах;
- Хаягдал усыг байгальд нийлүүлэх стандартаас бол ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журмын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах;

2022 оны Усны газраас ирүүлсэн хаягдал усны дүгнэлтээр:

- Хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах;
- Хаягдал усанд тодорхойлох үзүүлэлтүүдийг бүрэн шинжлүүлэх, шинжлүүлээгүй тохиолдолд бохирдуулах бодисыг жишиг хэмжээгээр тооцно;
- Улирал бүр 2-оос доошгүй хаягдал усны сорьц авч, лабораторид шинжлүүлэн ирүүлэх зэрэг зөвлөмжүүдийг өгч хэрэгжээгүй байна.

2.95 Эрдэнэс-Тавантолгой ХК нь 2020 оноос өмнөх хугацаанд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй, харьяа татварын алба хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна.

Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналтын тогтолцоо үгүйлэгдэж байна

2.96 Эрдэнэс-Тавантолгой ХК уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг төлөвлөх, зураглах, геологи-геотехникийн нөхцөлүүдийг тооцох, өрөмдлөг тэсэлгээ, маркшейдер болон уурхайд 24 диспетчерийн цагийн хяналтыг хийх хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж програмчлаагүйгээс уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг үр ашигтай төлөвлөх, бүртгэл, тооцоо, мэдээллийг нарийвчлан боловсруулах, үр нөлөөтэй нэгдсэн хяналт тавих, удирдах боломжгүй байна.


2.97 Энэ нь Эрдэнэс-Тавантолгой ХК уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд цахим систем, программ хангамжийг нэвтрүүлэх талаар зохистой арга хэмжээг төлөвлөж, үр дүнтэй ажил зохион байгуулаагүйтэй холбоотой бөгөөд цаашид нэн тэргүүнд уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хяналтын тогтолцоог бүрдүүлж, үр ашигтай төлөвлөх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангах, бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох, үр нөлөөтэй нэгдсэн хяналт тавьж, удирдах боломжийг бий болгох шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАРЧМААР БУС ТӨРӨӨС ХЭТ ХАМААРАЛТАЙ БАЙГАА НЬ ОРДЫГ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ, ЦОГЦ БАЙДЛААР ҮР АШИГТАЙ АШИГЛАХ БОЛОМЖИЙГ ХЯЗГААРЛАЖ БАЙНА

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн засаглалыг сайжруулж, үр нөлөөтэй хяналтын тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна

3.1 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн засаглалын тогтолцоо, удирдлагын шийдвэр гаргалт нь Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагаас бүрдэж байна.

Дүрслэл 3. Компанийн засаглалын загвар



Эх сурвалж: Аудитын баг

3.2 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 15.0 тэрбум ширхэг хувьцааны 85.2 хувь буюу 12.8 тэрбум ширхэг хувьцаа нь төрийн мэдэлд (Эрдэнэс Монгол ХХК төрийн төлөөллийг хэрэгжүүлж байна), 14.75 хувь буюу 2.2 тэрбум ширхэг хувьцаа нь Монгол Улсын 2.5 сая иргэний, 0.05 хувь буюу 0.007 тэрбум ширхэг хувьцаа нь 486 ААН-н эзэмшилд байна.

3.3 ТУЗ 2018 онд хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг тус бүр 1 удаа, 2019 онд ээлжит хурлыг 1 удаа, 2020 онд ээлжит болон ээлжит бус хурал тус бүр 1 удаа, 2021 онд ээлжит хурлыг 1 удаа, 2022 онд ээлжит болон ээлжит бус хурал тус бүр 1 удаа зарлаж, хуралдааныг зохион байгуулсан байна.

3.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээний асуудал тухайлбал, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, дүрмийн шинэчилсэн найруулга зэргийг хэлэлцэж баталсан байна.

3.5 Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хуралд төрийг төлөөлж Эрдэнэс-Монгол ХХК, иргэдийг төлөөлж 83 иргэн, ААН-ийг төлөөлж 3 ААН, ээлжит бус хуралд төрийг төлөөлж УУХҮЯ, ТӨБЗГ, иргэдийг төлөөлж 59 иргэн, ААН-ийг төлөөлж 2 ААН, 2019 оны ээлжит хуралд төрийг төлөөлж УУХҮЯ, ТӨБЗГ, иргэдийг төлөөлж 90 иргэн, ААН-ийг төлөөлж 12 ААН, 2020, 2021 онд төрийг төлөөлөн УУХҮЯ, ТӨБЗГ оролцож, хуралдааны тухай иргэд, олон нийтэд телевизийн сувгаар мэдээлсэн байна.

3.6 Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшсэн иргэд, нэрлэсэн үнээр худалдаж авсан ААН-үүдийн хувьцаа нь хоёр дахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл саналын эрхгүй, тэдгээрийг аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байхаар зааснаар нийт хувьцаа эзэмшигчдийн 14.8 хувийг эзэлж байгаа иргэн, ААН-ийн төлөөллийг ТУЗ-ийн хараат бус 4 гишүүн хэлбэр төдий хэрэгжүүлж, тэдний эрх ашгийг хамгаалж чадахгүй байна.

3.7 Энэ нь компанид сайн засаглалын зарчим хэрэгжихгүй зөвхөн том хувьцаа эзэмшигч (Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэнэс Монгол ХХК зэрэг шийдвэр


гаргах эрх бүхий этгээд)-ийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах, тэдгээрийн төлөөлөл удирдлагаар томилогдох нөхцөлийг бүрдүүлж байна.

3.8 Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13¹⁶, Компанийн дүрмийн 8.16¹⁷-д заасан журамд тухайн зохицуулалтын суурь зарчмыг тусгасан боловч жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах засаглалын тогтолцоо бүрдээгүй байна.

3.9 Иймд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах нь компанийн нэр хүнд өсөх, хөрөнгө оруулалт татах нөхцөл бүрдэх, хяналт сайжрах зэргээр сайн засаглал бий болох боломжтой тул Эрдэнэс-Тавантолгой ХК-ийг нээлттэй хувьцаат компани болгох замаар хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжиж, эдийн засагт хувь нэмэр оруулж, үр нөлөөтэй хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй байна.

3.10 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийг засаглалын хувьд зах зээлийн зарчмаар ажиллуулахгүй Төр Ерөнхийлөгч, Засгийн газар)-ийн шийдвэрээр үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлж, компанийн орлого, ашгаар ТЭЗҮ-д тусгасан ордыг цогцоор нь үр ашигтай ашиглах, нэгдсэн төлөвлөлтийн хүрээний дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхгүйгээр нийгмийн болон төсвийн шинж чанартай асуудалд зарцуулсан нь ордын үнэ цэнийг бууруулах, насжилтыг богиносгон, сорчилж ашиглахад хүргэсэн байна.

Дүрслэл 4. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн засаглалын одоогийн загвар



Эх сурвалж: Аудитын баг

3.11 УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолын дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийг байгуулж, уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлснээс хойших компанийн орлого, ашгаас Төрийн шийдвэрээр нийт 1,196.5 тэрбум төгрөгийг нийгмийн болон төсвийн шинж чанартай асуудлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. Тухайлбал,

- Хүний хөгжил санд 2011 онд 217.6 тэрбум, 2012 онд 80.2 тэрбум, 2013 онд 120.6 тэрбум төгрөг нийт 418.4 тэрбум;
- Тавантолгой түлш ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлд 2018 онд 18.6 тэрбум, 2019 онд 111.8 тэрбум, 2020 онд 138.7 тэрбум, 2021 онд 180.8 тэрбум, 2022 онд Засгийн газрын 2021 оны 316 дугаар тогтоолоор Тавантолгой түлш ХХК-ийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөр болох 12.5 тэрбум, нийт 462.4 тэрбум;
- БНХАУ-д үзүүлэх буцалтгүй тусламж (30000 хонь)-д 2020 онд 2.9 тэрбум;
- “Азийн хүүхдүүд” олон улсын спортын VII наадмын хүрээнд 2019 онд 5.0 тэрбум;
- Засгийн 2022 оны 220 дугаар тогтоолоор Эрдэнэс Монгол ХХК-ийн МУХБ дахь 117.2 тэрбум төгрөгийг зээлийн төлбөрийг төлсөн (эх үүсвэр нь 2018 оны төрийн өмчийн ногдол ашиг болох 880.2 тэрбум төгрөгөөс 117.2 тэрбум төгрөгийг Эрдэнэс Монгол ХХК-д хуваарилж, МУХБ-ны өрийг төлсөн);
- Засгийн газрын 2022 оны 94 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг үндэслэн Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн БНХАУ-ын Норинко интернэйшнл күүлэрэшин компанитай 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан “Газрын тос дамжуулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулах,

¹⁶ төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;

¹⁷ Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын болон компанийн засаглалын холбогдох журмыг Компанийн тухай хуульд нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөл батална.

барилга угсралтын ажил гүйцэтгэх” гэрээний үнэ болох 388.1 сая ам.долларын санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар төлж барагдуулахаар шийдвэрлэж, 2022 онд 59.7 тэрбум;

- Засгийн газрын 2021 оны 206, 353 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлд үндэслэн “Богдхан төмөр зам” төслийн бүтээн байгуулалтын ажлын 1,404.9 сая ам.долларыг нүүрсээр болон бэлэн мөнгөөр төлж барагдуулахаар шийдвэрлэж, 2022 онд 130.9 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.12 Засгийн газрын тогтоолуудыг үндэслэн Эрдэнэс-Тавантолгой ХК-аас төсвийн шинж чанартай эдгээр төсөл, хөтөлбөрт улсын төсвөөс гадуур ДНБ-ий 2019 онд 2.3 хувь, 2020 онд 2.8 хувь, 2021 онд 1.6 хувь, 2022 онд 2.3 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилт олгосон нь төсвийн иж бүрэн байх зарчмыг¹⁸ алдагдуулж, хяналтаас гадуур зарцуулагдах эрсдэлтэй байна. (Төслүүдэд олгосон санхүүжилтийн судалгааг хавсралт 7-оос үзнэ үү)

Хүснэгт 15. Эрдэнэс-Тавантолгой ХК-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он
Нийт төсөл, хөтөлбөрт олгосон санхүүжилт	862.7	1,047.3	708.2	1,227.5
ДНБ, нэрлэсэн үнээр	37,839.2	37,453.3	43,555.5	52,867.4
ДНБ-д эзлэх төсөл, хөтөлбөрт зарцуулсан хувь	2.3	2.8	1.6	2.3

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, ҮСХ

Төрийн эрх хэрэгжүүлэгч нь удирдамж өгөх хэлбэрээр компанийн засаглалд оролцож байгаа нь төрийн оролцоог нэмэгдүүлж, “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчмуудыг алдагдуулж байна

3.13 Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13¹⁹ болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6²⁰-д ТУЗ-ийн төрийг төлөөлж буй гишүүн нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллахаар заасны дагуу төрийн төлөөллийг хэрэгжүүлэгчээс (УУХҮЯ, ТӨБЗГ, Эрдэнэс Монгол ХХК) удирдамж ирсний дараа компанийн Хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийг хуралдуулдаг бөгөөд хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр (заалт бүрээр) удирдамж авахыг шаарддаг байна.

3.14 Компанийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн төлөөллийг хэрэгжүүлэгчээс ирэх удирдамжийг заавал биелүүлэхээр тусгасан ба удирдамжийн агуулга, хүргүүлэх ажиллагаанд хяналт тавих харилцаа зохицуулагдаагүй бөгөөд удирдамжийн дагуу их хэмжээний санхүүжилт, зээл, хөрөнгө оруулалт хийх, бодлогын шийдвэр гаргахыг үүрэг болгосноос гадна удирдамжийг биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох талаар мэдэгдсэн хэлбэртэй байна. Тухайлбал,

- Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдөр ирсэн удирдамжаар МУХБ-д төлөх Эрдэнэс Монгол ХХК-ийн 117.2 тэрбум төгрөгийг төлөхийг 5 удаагийн бичгээр шаардсан;
- Засгийн газрын 2022 оны 25 дугаар тогтоол, Эрдэнэс-Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 25 дугаар тогтоол, 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 01/690 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжаар Нийслэлийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл, үйлдвэрлэлийн тасралтгүй бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Багануур ХК-д 23.9 тэрбум, Шивээ-Овоо ХК-д 24.1 тэрбум төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгох;
- Эрдэнэс-Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 01/743 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамж, Өмнөговь аймгийн Засаг даргатай байгуулсан ЭТТ-2021/407 дугаартай хамтын ажиллагааны гэрээнд үндэслэн ТУЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 36 дугаар тогтоолоор 2021-2024 онуудад Даланзадгадын ДЦС ТӨХК-ийн жилийн хэрэглээний 30 хувь болох 21.0 мянган тонн

¹⁸ Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;

¹⁹ Төр болон бусад хуулийн этгээд аливаа компанид хөрөнгө оруулсныхаа төлөө эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээ хэрэгжүүлэхдээ дүрэмдээ заасан эрх бүхий этгээдээс томилсон төлөөлөгчөөр дамжуулан төлөөллөө хэрэгжүүлэх бөгөөд энэхүү төлөөлөгч нь уг төлөөллийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль болон тухайн компанийн дүрэмд заасан эрх бүхий этгээдээс өгсөн удирдамжийг үндэслэх ба энэхүү удирдамжаас өөрөөр санал гаргасан нь түүнийг энэхүү төлөөллийг хэрэгжүүлэх эрхээс чөлөөлөх үндэслэл болно.

²⁰ Төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана. Удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно.

эрчим хүчний нүүрсийг үнэ төлбөргүй, үлдэгдэл 70 хувь болон 49.0 мянган тонн эрчим хүчний нүүрсийг эрчим хүчний нүүрс хангалттай байхад өртөг үнээр Цагаан-Овоо багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх нөхөн олговрын хэмнэлтээс олгохоор шийдвэрлэсэн.

3.15 Энэ нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ бие даан шийдвэр гаргах боломжийг хязгаарлаж, төрийн оролцоог хэтрүүлж, компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нөлөөлж, компанийн үнэ цэнэ, олон улсын зах зээлээс санхүүжилт босгох, компанийн сайн засаглалыг бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй удирдамжаар аливаа Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэр гарч байгаа нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчим алдагдсан тогтолцоо үүссэнийг харуулж байна.

3.16 Тухайн удирдамжаас үүсэх аливаа санхүүгийн болон үйл ажиллагааны сөрөг үр дагаварт хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт байхгүй тул төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн төлөөлөл хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

3.17 Компанийн Төрийн төлөөллийг хэрэгжүүлэх байгууллагыг Засгийн газрын тогтоолоор олон удаа өөрчилж байгаа нь Эрдэнэс-Тавантолгой ХК-д засаглал тогтворгүй байх, бодлогын залгамж алдагдах байдлыг үүсгэж байна.

- Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийг Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулсан;
- Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Эрдэнэс Монгол ХХК-аас шилжүүлж, УУХҮЯ 70 хувь, ТӨБЗГ 30 хувь тус тус хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн;
- Засгийн газрын 2021 оны 367 дугаар тогтоолоор тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааны эрх хэрэгжүүлэгчээр Эрдэнэс Монгол ХХК-ийг томилсон бөгөөд өнөөдрийг хүртэл жил гаруй хугацаанд Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч хувь хүн бүх удирдамжийг ирүүлсэн байна.

3.18 Мөн Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн гишүүдэд 2018 оны 01 дүгээр сараас 2019 оны 8 дугаар сарыг дуусталх хугацаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүдэд сарын 1.3 сая, хараат бус гишүүдэд 1.8 сая, 2019 оны 9 дүгээр сараас эхлэн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүдэд 2.2 сая, хараат бус гишүүдэд 3.1 сая төгрөгийн цалинг тус тус олгосон нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7²¹-д заасан түвшнээс дунджаар 3.5 дахин өндөр байснаас ТУЗ-ийн гишүүдэд 567.7 сая төгрөгийн цалинг илүү олгосон байна.

3.19 Харин ТУЗ-ийн 2022 оны 22/02 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн цалинг Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан цалингийн хэмжээнд тогтоосон байна.

Хүснэгт 16. ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалин, сая төгрөг

№	Цалин хөлс	2018 он	2019 он	2020 он	2021 он	Нийт
1	ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалин	169.0	232.4	231.0	240.9	873.3
2	Засгийн газрын 80 дугаар тогтоолын дагуу олгох дүн	52.8	78.1	73.9	100.8	305.6
	Илүү олгосон цалингийн дүн	116.2	154.3	157.1	140.1	567.7

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

²¹ “Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна”

Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог үр ашигтай зохион байгуулаагүй байна

3.20 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-өөс 2010-2022 онд нийт 13 удаагийн шийдвэр гаргаж, компанийн бүтэц, орон тоог шинэчлэн баталсан байна. Компанийн орон тоо 2011 онд 243 байсан бол 2021 онд 946, 2022 онд 1086 болж нэмэгджээ. Уурхайн үйл ажиллагааг өргөжүүлэхээр бүтцийн өөрчлөлт хийж, орон тоог нэмэгдүүлсэн ч бодит байдалд ТЭЗҮ-ийн дагуу үйл ажиллагааг өргөтгөх зорилтууд хэрэгжээгүй байхад бүтцийг хэвээр хадгалж, орон тоог тогтмол нэмэгдүүлсэн нь үйл ажиллагааны зардлыг өсгөж, ашигт ажиллагааг бууруулж байна. Тухайлбал,

- ТУЗ-ийн 2012 оны 05 дугаар тогтоолоор уурхай төслийн шатнаас - олборлолт, борлуулалт, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эхлүүлэх IPO²² төсөл хэрэгжүүлэхээр хувьцаа хариуцсан газарт 10, эрчим хүчний төсөлд 8, төмөр замын төсөлд 5, авто замын төсөлд 5, баяжуулах угаах үйлдвэрийн төсөлд 7, усан хангамжийн төсөлд 8 орон тоо зэргээр нийт 116 орон тоог нэмэгдсэн ч эдгээр төслүүд 10 жилийн дараа л эхэлсэн;
- ТУЗ-ийн 2018 оны 17 дугаар тогтоолоор олон улсын зах зээлд хувьцаа гаргах бэлтгэл ажил хангах, нүүрс тээврийн жолооч нарын ажиллах орчныг сайжруулах, шинээр нүүрс шинжилгээний лаборатори байгуулах, гаалийн хяналтын бүсэд ажиллаж байгаа иргэдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах үндэслэлээр 54 орон тоо нэмэгдсэн ч үр дүнд хүрээгүй;
- ТУЗ-ийн 2018 оны 26 дугаар тогтоолоор компанийн хувьцааг олон улсын болон дотоодын санхүүгийн зах зээлд арилжаалан эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгө оруулалтын менежментийг сайжруулах үндэслэлээр 21 орон тоог нэмсэн ч хувьцаа гаргах үйл ажиллагаа үр дүнд хүрээгүй;
- ТУЗ-ийн 2018 оны 33 дугаар тогтоолоор компанийн газар, хэлтэс алба нь орлогч даргагүй байхаар дахин бүтцийн өөрчлөлт хийсэн ч 30 орон тоо нэмэгдсэн;
- ТУЗ-ийн 2018 оны 43 дугаар тогтоолоор компанийн үйл ажиллагааны цар хүрээ, олборлолт, борлуулалт 2019 онд нэмэгдэж байгаа шалтгаанаар 75 орон тоо нэмэгдсэн. Гэвч Эрдэнэс-Тавантолгой ХК өөрийн техник, хүн хүчээр олборлолт явуулдаггүй гэрээт олборлогч компаниар ажлаа гүйцэтгүүлдэг тул орон тоо нэмэх шаардлагагүй байсан;
- ТУЗ-ийн 2020 оны 27 дугаар тогтоолоор орон тоог 986 болгож, Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК татан буудаж 138 ажилтныг шилжүүлэн авсан байна.

3.21 Бүтцийн олон удаагийн өөрчлөлт болон бусад хүчин зүйлээс шалтгаалж ажлаас халагдаад шүүхийн шийдвэрээр буцаан томилсон 2019 онд 5 ажилтанд 68.1 сая, 2020 онд 6 ажилтанд 391.2 сая төгрөг, 2021 онд 3 ажилтанд 104.3 сая, 2022 онд 1 хүнд 1.7 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

3.22 Иймд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасны дагуу буруутай албан тушаалтнаар 565.3 сая төгрөгийг төлүүлж зөрчлийг арилгах албан шаардлагыг дээрх хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасны дагуу буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төрийн төлөөлөл хэрэгжүүлэгч Эрдэнэс Монгол ХХК-д албан шаардлага хүргүүлэв.

3.23 Эрдэнэс-Тавантолгой ХК гэрээт олборлогч компаниудыг сонгон шалгаруулахдаа тендерт оролцогч ААН-үүдэд олборлолтын үйл ажиллагаанд шаардагдах ажлын байр, тэдгээрт ажиллах хүний орон тоо, ажиллуулах нөхцөлийн шаардлагыг тавьдаг боловч энэ нь компанийн өөрийн уурхайн салбарт ажиллаж буй хүний нөөц, зарим ажлын байрны чиг үүрэгтэй давхардал үүсгэсэн байна. Тухайлбал,

- Гүйцэтгэгч компани нь сард 2.0-2.5 сая м.куб уулын цулыг ухаж, ачиж, тээвэрлэх хүчин чадал бүхий нийт 100-104 ширхэг техник, тоног төхөөрөмжтэй байх бөгөөд эдгээрийг ажиллуулах операторууд нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд бүрэн хамрагдсан байх;
- Аливаа онцгой нөхцөл байдал үүсэх болон гал түймэр гарсан тохиолдолд ашиглах шаардлагатай техник тоног төхөөрөмж, тухайн үед ажиллах эрх бүхий баг бүрэлдэхүүнтэй байх;

²² Initial public offering – хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох

- Аливаа осол аваарын үед эмнэлгийн түргэн тусламж үзүүлэх зориулалтын машин тоног төхөөрөмж, эмч эмнэлгийн ажилтан, яаралтай тусламжийн нэгжтэй байх;
- Мэргэжлийн сургалт явуулах эрх бүхий зөвлөх, сургагч багш, сургалтын багтай байх.

3.24 Гэрээт олборлогч компаниудаас шаардаж буй дээр дурдсан ажлын байруудад ажиллах хүний нөөцийн баг бүрэлдэхүүн нь Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн өөрийн бүтцийн зохион байгуулалтын нэгж, хүний нөөцийн бүрэлдэхүүнд байдаг бөгөөд ажлын байрны нэршлийн хувьд авч үзэхэд мөн давхардалтай байна.

3.25 Уурхайн үндсэн үйл ажиллагаа болох олборлолтыг гэрээт компаниар гүйцэтгүүлж байхад Эрдэнэс-Тавантолгой ХК ийн уурхайн талбайд 2018-2022 онд жил бүр орон тоо нэмэгдсэн байна. Энэ нь гэрээт олборлогч компанийн ажлын байр, албан тушаал уурхай эзэмшигчийн орон тоотой давхардсан бүтэц ажиллаж байгааг харуулж байна.

Хүснэгт 17. Уурхайд ажиллаж буй нийт ажилтны тоо

№	Аж ахуйн нэгжийн нэр	2018	2019	2020	2021	2022
1	Эрдэнэс-Тавантолгой ХК	587	600	675	746	888
2	Ти Эн түншлэл (Ти Ти Жи Ви Си Өү ХХК, Нормант ХХК, Си Ар Найнтээн бюро ХХК)	328	981	906	563	1,127
3	Тавантолгой оператор түншлэл (Овоот толгой ресурсес ХХК, Эрдэс майнинг оператор ХХК, Голд магнет ХХК, Платинум ланд ХХК, Тэргэннүүр ХХК)				1,237	1,211
4	Хишиг Арвин индустриал ХХК	1,080	1,049	1,304	1,128	916
5	Моннис майнинг ХХК	47	195	318	548	310
6	Спейшл майнинг ХХК					125
7	Тэсүн майнинг ХХК					57
8	Геомин ХХК					90
9	Чин хутаг өндөр ХХК					48
10	Дотоодын цэрэг					108
	НИЙТ ДҮН	2,042	2,825	3,203	4,222	3,992

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.26 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 27 дугаар тогтоолоор баталсан бүтэц, орон тоогоор Улаанбаатар хотын төв салбарт нийт 311 орон тоо баталснаас гүйцэтгэх захирал 1, дэд захирал 7, газрын дарга 9, хэлтсийн дарга 22, албаны дарга 9, төлөөлөгчийн газрын дарга 1, төслийн нэгжийн захирал 1, нийт 50 удирдах албан тушаалтан ажиллаж, төв салбарын 6 хүн тутамд 1 удирдах албан тушаалтан ногдож байна. Үүнээс 7 дэд захирлын чиг үүрэг, бусад газар нэгжийн даргынхтай давхардаж байсан байна. Үүнд:

- Үйлдвэрлэл хариуцсан дэд захирлын чиг үүрэг Уул уурхайн газрын;
- Санхүү хариуцсан дэд захирлын чиг үүрэг Санхүүгийн удирдлагын газрын;
- Худалдан авалт хариуцсан дэд захирлын чиг үүрэг Худалдан авалтын газрын;
- Хууль, эрх зүй хариуцсан дэд захирлын чиг үүрэг Хууль эрх зүйн газрын;
- Ерөнхий удирдлага хариуцсан дэд захирлын чиг үүрэг Захиргаа удирдлагын газрын;
- Стратеги, хөгжил хариуцсан дэд захирлын чиг үүрэг Борлуулалт ложистикийн газар болон Бизнес хөгжлийн газрын;
- Хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирлын чиг үүрэг үнэт цаас санхүүжилтийн газрын даргын чиг үүрэгтэй тус тус давхардсан байна.

3.27 Харин 2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу ТУЗ-ын 2022 оны 27 дугаар тогтоолоор дэд захирлуудыг чөлөөлсөн байна.

3.28 Мөн дээрх тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан бөгөөд Улаанбаатар хотын төв салбарт нийт 200 орон тоо баталснаас гүйцэтгэх захирал 1, газрын дарга 10, хэлтсийн дарга 22, нийт 33 удирдах албан тушаалтан ажиллаж, төв салбарын 6 хүн тутамд 1 удирдах албан тушаалтан ногдсон хэвээр байна.

Засгийн газраас Онцгой бүрэн эрхт төлөөлөгч томилохоос өмнө орон тоо 1049 байсан бол оны эцэст 1026 болж, удирдах ажилтны тоо 30.9 хувиар буурсан байна.

3.29 Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 30 дугаар тэмдэглэлээр Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн ААН-үүдийн төв оффисыг үйл ажиллагаа явуулж буй орон нутагт шилжүүлэн байршуулах талаар санал боловсруулж танилцуулахыг УУХҮЯ, ТӨБЗГ, Эрдэнэс Монгол ХХК-д даалгасан боловч Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьд өнөөдрийг хүртэл ямар нэг шийдэл, үр дүнд хүрээгүй байна.

3.30 Эрдэнэс-Тавантолгой ХК тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд цомхон, ухаалаг бүтцээр гэрээт олборлогч компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, нэгдсэн төлөвлөлтөөр уурхайн үйл ажиллагааг зохион байгуулж, чиг үүргийн давхардалгүй ажиллах нь зүйтэй байна.

Компанийн дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаа жигдрээгүй, үр дүнд чиглэсэн үйл ажиллагаа явуулаагүй байна

3.31 Компанийн бүтцэд ТУЗ-ийн дэргэд Дотоод аудитын алба, Гүйцэтгэх захирлын удирдлагад Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар ажиллаж компанийн үйл ажиллагаанд хөндлөнгийн болон дотоод хяналтыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т "...ТУЗ нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх", уг хороо нь хуулийн 81.4-т заасны дагуу компанийн нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан болон санхүүгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, дотоод хяналтын албаны ажилтныг томилох, цалин хөлсийг тогтоох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах зэрэг үүрэгтэй" гэж заасны дагуу Дотоод аудитын алба ажиллаж байна.
- ✓ Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журам"-ыг мөрдөн ажиллаж байна.


3.32 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Дотоод аудитын албаны бүрэлдэхүүнийг дарга, 5 гишүүн, нийт 6 гишүүнтэй байхаар баталж үйл ажиллагаа явуулсан байна. Гишүүдийн бүрэлдэхүүнд ТУЗ-ийн хараат бус 4 гишүүн оржээ.

3.33 Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ томилдог бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын албаны ажилтнуудыг бусад бүтцийн нэгжийн нэгэн адил гүйцэтгэх захирлын тушаалаар томилж байгаа нь хараат бус байдал алдагдахад хүргэсэн байна.

3.34 Компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь аудитад хамрагдсан хугацаанд:

- ✓ ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 33 дугаар тогтоолоор 14 хүний бүрэлдэхүүнтэй;
- ✓ ТУЗ-ийн 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолоор 2 хэлтэс, 10 хүний бүрэлдэхүүнтэй;
- ✓ 2022 онд газрын бүтэц оронтой холбоотой ТУЗ-ийн тогтоол гараагүй боловч Засгийн газраас томилсон Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн шийдвэрээр 20 хүний бүрэлдэхүүн, 3 хэлтэстэй үйл ажиллагаа явуулсан байна.

Зураг 5. Компанийн дотоод хяналтын нэгжийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг зургаар харуулбал,



Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.35 Компанийн дотоод аудитаар илэрсэн зөрчлийг өгсөн зөвлөмжийн дагуу арилгах хариу арга хэмжээ аваагүй, эрсдэлийг тодорхойлж үнэлгээ хийсэн боловч бууруулах чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулаагүй байна.

3.36 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, уурхайн үйл ажиллагаа, хууль, журмын биелэлтэд тавих хөндлөнгийн болон дотоод хяналт үр нөлөөгүй байгаагаас компанийн бүтэц, зохион байгуулалт оновчгүй, зарим албан тушаалтнуудын чиг үүрэг давхацсан, ажлын ачаалал нь тэнцвэргүй, ажилтнуудын мэргэжил мэдлэг дутмаг, худалдан авах ажиллагаанд хууль, дүрмийн мөрдөлт хангалтгүй, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрт тавих хяналт сул, аливаа залилангаас ангид байх соёл тогтоогүй зэргээр илэрч байна.

3.37 Энэ нь Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн газар зэрэг эрх бүхий байгууллагаас 2022 онд тус компанийн ил уурхайн гэрээт олборлогч, ачилт, тээвэрлэлт, нүүрсний дээжид шинжилгээ хийх, харуул хамгаалалт, катеринг, даатгалын үйлчилгээ үзүүлэгч, барилга, байгууламжийн ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байдал, техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, программ хангамж, дизель түлш, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд хяналт хийж байгаагаар мөн харагдаж байна.

3.38 Түүнчлэн компанийн үйл ажиллагаанд хөндлөнгийн болон хараат бус, хуулийн хүрээний гэх мэт хяналт шалгалт байнга хийгдэж байгаа ч залилангийн эрсдэлээс сэргийлэх, илрүүлэх боломж муу, дотоод ажлын түвшинд хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй, мэдэгдэхүйц тодорхой, үр нөлөө бүхий ажлууд хийгдэж, тайлагнаж, хянагдаагүй байна.

3.39 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 19 зөвлөмж өгснөөс 5 нь хэрэгжсэн, 1 зөвлөмжийн үр дүнгээр ажил хийгдэж байгаа ч бүрэн хэрэгжээгүй, 13 зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна.

3.40 Иймд үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын түвшинд залилангийн эрсдэлийг тодорхойлж үнэлэх зохистой горим нэвтрүүлж, залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх журам (горим)-ыг нэвтрүүлэх, үйл ажиллагааныхаа гол зорилтыг хэрэгжүүлэхдээ төлөвлөгөөт ажлын нэг хэсэг болгон залилантай тэмцэх стратегийг

боловсруулан, урьдчилан сэргийлж, илрүүлэх арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК “ам” нөхцөлөөр борлуулалт хийхгүйгээр нүүрсийг баяжуулж, нэмүү өртөг шингээн эцсийн хэрэглэгчид борлуулах стратегийг баримтлах шаардлагатай байна

3.41 Эрдэнэс-Тавантолгой ХК борлуулсан бүтээгдэхүүний үнийг тогтоохдоо “Ex-Stock Ганцмод боомт”-ын үнийг хасагдах зардлаар хорогдуулж борлуулах бүтээгдэхүүний доод үнийг тооцоолж, түүнд үндэслэн сонгон шалгаруулалт зохион байгуулсны үндсэн дээр “FCA Уурхайн ам”²³ нөхцөлөөр борлуулах үнийг тогтоосон байна.

3.42 БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ганцмод боомтын түүхий коксжих нүүрсний тонн тутмын үнээс хилийн хураамж, агуулахын зардалд 5.9 ам.доллар, татварт 16.0-20.0 хувь, бусад тооцоологдоогүй зардалд 3.0 хувь, Ганцмод боомт болон Цагаанхад хоорондын тээврийн зардалд 18.6-30.2 ам.доллар, Цагаанхад дахь гаалийн хяналтын бүсийн агуулахын болон ачиж буулгах зардалд 1.7-1.9 ам.доллар, тээврийн болон талбайн хорогдолд 1.0 хувь, уурхайн ам болон Цагаанхад хоорондын тээврийн зардалд 12.4-14.3 ам.долларыг тус тус хасаж, “FCA Уурхайн ам” нөхцөлөөр борлуулах түүхий коксжих нүүрсний үнийг тогтоохоор байна. (Эдгээр хасагдах зардлуудын мэдээллийг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн тооцооллын эх сурвалжид үндэслэв.)

3.43 Эрдэнэс-Тавантолгой ХК 2018-2019 онд уурхайн амнаас худалдааны компаниудад коксжих нүүрсийг гэрээгээр борлуулахдаа “Ex-Stock Ганцмод боомт”-ын түүхий коксжих нүүрсний үнээс дээрх хасагдах зардлуудыг хасаж тооцсон уурхайн “ам” нөхцөлийн үнээс тонн тутамд 1.9-13.4 ам.доллароор бага үнээр худалдсан байна.

3.44 Дээрх тооцооллыг 2018 оны 01 дүгээр сараас 2019 оны 8 дугаар сарыг дуусах хүртэл хугацаанд борлуулсан коксжих нүүрсээр тооцвол ойролцоогоор 145.2 сая ам.доллар буюу 396.9 тэрбум төгрөгийг²⁴ худалдааны компаниудад ашиг хэлбэрээр олгох нөхцөл болжээ.

Хүснэгт 18. Уурхайн ам нөхцөлөөр коксжих нүүрсний борлуулах үнэ болон борлуулсан үнийн зөрүү, ам.доллар

Огноо	Ex stock Ганцмод боомтын коксжих нүүрсний үнэ	Ганцмод боомтын үнээс холбогдох хасагдах зардлыг хасаж, уурхайн амнаас борлуулах үнэ	Уурхайн амнаас борлуулсан коксжих нүүрсний жигнэсэн дундаж үнэ	Уурхайн ам нөхцөлөөр борлуулах болон борлуулсан коксжих нүүрсний үнийн зөрүү 4=2-3	Борлуулсан коксжих нүүрсний хэмжээ (тонн)	Борлуулалтаас алдсан үнийн зөрүү
A	1	2	3	4=2-3	5	6=4*5
2018.01	163.4	80.0	68.1	11.9	1,127,780.25	13,468,773.56
2018.02	166.1	81.5	68.1	13.4	728,485.20	9,730,844.05
2018.03	166.1	79.9	68.1	11.8	1,153,090.30	13,599,318.60
2018.04	161.6	76.1	68.1	8.0	768,723.15	6,175,821.67
2018.05	152.2	79.3	68.1	11.2	954,739.90	10,723,271.92
2018.06	150.0	78.1	68.6	9.5	1,010,970.95	9,605,642.34
2018.07	144.4	75.0	69.7	5.3	564,138.75	2,965,027.68
2018.08	141.6	72.7	69.9	2.8	488,220.15	1,355,534.53
2018.09	144.1	74.7	70.1	4.6	1,572,531.05	7,279,085.06
2018.10	142.7	74.2	70.6	3.6	1,529,650.05	5,482,824.52
2018.11	145.0	74.4	70.9	3.5	543,011.50	1,896,830.53
2018.12	145.9	75.6	71.0	4.6	1,271,404.80	5,866,554.39
2019.01	148.6	77.2	70.9	6.3	1,505,328.15	9,488,046.65
2019.02	150.8	78.6	71.3	7.3	927,989.45	6,808,368.26
2019.03	156.4	80.8	71.5	9.3	1,706,617.95	15,931,177.36
2019.04	152.5	77.7	71.6	6.2	1,479,342.70	9,109,069.64
2019.05	147.1	74.4	71.5	2.9	1,123,112.45	3,294,644.12

²³ Incoterms 2010

²⁴ 2019 оны Монголбанкны хаалтын ханш 2,734.33 төгрөгөөр тооцов.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2019.06	147.6	74.8	71.2	3.6	1,565,585.40	5,587,342.57
2019.07	146.6	75.3	71.3	4.1	1,167,473.55	4,731,327.66
2019.08	139.6	73.5	71.6	1.9	1,067,131.15	2,074,869.66
Нийт					22,255,326.85	145,174,374.77

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.45 Энэ нь Эрдэнэс-Тавантолгой ХК Ганцмод хилийн боомт хүртэл нүүрсний тээвэрлэлтийг өөрөө хийдэггүй, нүүрсийг уурхайгаас “ам” нөхцөлөөр борлуулж байгаатай холбоотой байна.

3.46 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Захирлын зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 16 дугаар шийдвэр, ТУЗ-ийн 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоол зэргийг үндэслэн доод үнийг Олон Улсын 5 индексийн хөдөлгөөний дагуу улирал тутам тогтоож эхэлсэн байна. Индексийн сагс нь дараах индексүүдээс бүрдэж байна. Үүнд:

- CR China Coking Coal Price Index (30%)²⁵
- Primary coking average price of Production areas (30%)²⁶
- Shanxi LiuLin Seam 4 Hard Coking Coal Price (10%)²⁷
- Metal Bulletin Coking Coal Price Index (20%)²⁸
- Platts, HCC 64 Mid Vol, CFR China (10%)²⁹

3.47 Эрдэнэс-Тавантолгой ХК 2020-2022 онд борлуулсан бүтээгдэхүүний үнийг тогтоохдоо Олон Улсын 5 индексийн хэлбэлзлээр тооцсон үнийг гарган, түүнийг хасагдах зардлаар хорогдуулж борлуулах бүтээгдэхүүний доод үнийг тооцоолж, түүнд үндэслэн сонгон шалгаруулалт зохион байгуулсны үндсэн дээр “FCA-Уурхайн ам” нөхцөлөөр нүүрс борлуулах үнийг тогтоосон байна.

3.48 Үнийг тогтоохдоо 2020-2022 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ганцмод боомтын түүхий коксжих нүүрсний тонн тутмын үнээс хилийн хураамж, агуулахын зардалд 4.7-7.0 ам.доллар, БНХАУ-ын НӨАТ-т 13.0 хувь, импортын татварт 3.0 хувь, Ганцмод боомт болон Цагаанхад хоорондын тээврийн зардалд 2020 онд 28.8 ам.доллар, 2021 онд 109.7 ам.доллар, 2022 оны эхний хагаст 99.9-121.8 ам.доллар, Цагаанхад дахь гаалийн хяналтын бүсийн агуулахын болон ачиж буулгах зардалд 1.4-1.6 ам.доллар, тээврийн болон талбайн хорогдолд 3.0 хувь, уурхайн ам болон Цагаанхад хоорондын тээврийн зардалд 10.0-14.2 ам.долларыг тус тус хасаж тогтоосон байна. (Эдгээр хасагдах зардлуудын мэдээллийг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн тооцооллын эх сурвалжид үндэслэв.)

3.49 Эрдэнэс-Тавантолгой ХК уурхайн амнаас худалдааны компаниудад коксжих нүүрсийг гэрээгээр борлуулахдаа Олон Улсын 5 индексийн хэлбэлзлээр тооцсон үнэ, түүнээс дээрх хасагдах зардлуудыг хассаны дараах сонгон шалгаруулалт зарлах үнийг тогтоосон байна.

3.50 Хасагдах зардлуудаар хорогдуулсан сонгон шалгаруулалтын үнэ болон Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн коксжих нүүрс борлуулсан жигнэсэн дундаж үнийн зөрүү нь тонн тутамд 10.30-30.38 ам.доллар болж байна. Энэ нь дээрх зөрүү тээврийн болон худалдааны компаниудад ашиг хэлбэрээр үлдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

²⁵ CR China Coking Coal Price Index – Хятад даяар борлогдож буй коксжих нүүрсний жигнэсэн дундаж үнийг илэрхийлдэг бөгөөд <http://en.sxcoal.com> сайтад долоо хоног тутам нийтлэгддэг.

²⁶ Primary coking average price of Production areas - БНХАУ-ын нүүрсний үйлдвэрлэлийн голлох мужууд болох Шаньси, Анхуй, Гуйжоу, Хейлонжанг, Хенан, Юннань, Өвөр Монгол зэрэг мужуудын коксжих нүүрсний дундаж үнийг илэрхийлдэг бөгөөд <http://en.sxcoal.com> сайтад долоо хоног тутам нийтлэгддэг.

²⁷ Shanxi LiuLin Seam 4 Hard Coking Coal Price - Хятадын төв Шаньси (Central Shanxi) мужийн Lvliang хэсгийн Liulin уурхайн 4-р давхаргын түүхий коксжих нүүрсний уурхайн амны үнэ бөгөөд <http://en.sxcoal.com> сайтад өдөр тутам нийтлэгддэг.

²⁸ Metal Bulletin Coking Coal Price Index – Их Британийн Лондон хотод төвтэй, дэлхийн томоохон улсуудад салбартай, мэдээллийн тив дамнасан магнат “Metal Bulletin”-ээс эрхлэн гаргадаг. Энэхүү индексийг 60 хоногийн дотор нийлүүлэх, нөхцөлтэй коксжих нүүрсний үнийг үндэслэн гаргадаг бөгөөд <https://www.metalbulletin.com> сайтад өдөр тутам нийтлэгддэг.

²⁹ Platts, Low Vol HCC, CFR China - “GFR China” нөхцөлтэй буюу Хятадад хүргэж өгөх нөхцөлтэй коксжих нүүрсний спот үнэ юм. S&P Global Platts-ийн “Coal Trader International” тайланд өдөр тутам нийтлэгддэг.

3.51 АМТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1.4-д “*ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий хуулийн этгээд ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах*” гэж заасан хэдий ч Эрдэнэс-Тавантолгой ХК өөрөө тээвэрлэлт хийх техникийн боломжгүй байгаа нь нүүрсний зах зээлийн жишиг үнийг хасагдах зардлаар хорогдуулж “ам” нөхцөлийн үнэ тооцох шалтгаан болсон байна.

3.52 Борлуулалтын үнийг “ам” нөхцөлөөр тооцох туршлага олон улсад бүртгэгдээгүй, ашигладаг эсэх талаар мэдээлэл байхгүй, энэ нь борлуулалтын үнэ зах зээлийн үнээс бага байх нөхцөл болж байх тул цаашид “ам” нөхцөлөөр борлуулах үйл ажиллагааг зогсоож, нүүрсийг шууд хэрэглэгчид хүргэх бодлого баримтлах шаардлагатай байна


3.53 Мөн Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын³⁰ 3.7.5-д “*Эрдэс баялгийн бүтээгдэхүүний гадаад, дотоодын зах зээл дээрх борлуулалтыг нээлттэй, оновчтой, өндөр үр ашигтай, зах зээлийн зарчимд нийцсэн аргаар хийх, шударгаар үнэ тогтоох, дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах зорилгоор эрдэс баялгийн бирж байгуулах*” гэж заасан зорилт аудитын хамрах хугацаанд бүрэн хэрэгжээгүй байна.

3.54 Энэ нь зорилтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Монгол Улсын Засгийн газар, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохистой стратеги, үр дүнтэй зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, олон улсын жишгийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг бүрдүүлээгүйтэй холбоотой байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн коксжих нүүрсний үнэ зах зээлийн үнийг дагаж өсөж, буурах нөхцөл бүрдээгүй байна

3.55 БНХАУ-ын импортолж байгаа коксжих нүүрсний дийлэнх хэсэг буюу 25.0-40.0 хувийг Монгол Улс нийлүүлж байна. Гэвч БНХАУ-ын боомтууд дээр тогтож байгаа үнээр Төрийн өмчийн Эрдэнэс-Тавантолгой ХК борлуулалтаа хийж чадахгүй байна. (Коксжих нүүрсний Ганцмод боомтын үнэ болон борлуулалтын гэрээний үнийн харьцуулалтыг график 14-өөс харна уу.)


График 14. Коксжих нүүрсний Ганцмод боомтын үнэ болон борлуулалтын гэрээний үнийн харьцуулалт



Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, <http://en.sxcoal.com/>

³⁰ УИХ-ын 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор баталж, УИХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор хүчингүй болсон.

График 15. БНХАУ-ын импортлосон нүүрсний тоо хэмжээ, үнийн харьцуулсан мэдээлэл (2019 он)



Эх сурвалж: <http://en.sxcoal.com/>

3.56 Монгол Улсаас БНХАУ-д нийлүүлж байгаа нүүрсний дийлэнх хувийг түүхий нүүрс эзэлдэг, нүүрсийг экспортолж байгаа Гашуунсухайт, Шивээхүрэн хилийн боомтуудаас БНХАУ-ын дийлэнх гангын үйлдвэрүүд байрладаг зүүн эргийн мужууд хүртэл тээврийн зардал өндөр байдаг зэрэг шалтгааны улмаас Монгол Улсаас БНХАУ-ын импортлож буй нүүрсний хил дээрх дундаж үнэ бусад орны үнэтэй харьцуулахад 1.4 дахин бага байна.

3.57 Эрдэнэс-Тавантолгой ХК бүтээгдэхүүнээ DAP нөхцөл буюу хүргэж өгөх нөхцөлийг баримтлан зах зээлийн үнэд хүргэн борлуулах санаачлагатай, бүх боломжийг ашиглаж явуулах шаардлагатай байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК нүүрс борлуулах гэрээ байгуулахдаа урьдчилгаа төлбөрийн хэмжээнээс хамаарсан хөнгөлөлт үзүүлж байгаа нь Ашигт малтмалын тухай хуультай нийцэхгүй байна

3.58 Нүүрс борлуулах гэрээ байгуулж урьдчилгаа төлбөрт 2020 онд 1,161.1 тэрбум, 2021 онд 1,140.3 тэрбум, 2022 онд 2,325.3 тэрбум, нийт 5,179.4 тэрбум төгрөг авч, 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,445.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 19. Төлбөрөө урьдчилж төлсөн борлуулалтын гэрээний өглөг, тэрбум төгрөг

Тайлант хугацаа	Төлбөрөө урьдчилж төлсөн борлуулалтын гэрээний		Өглөгийг барагдуулсан байдал	Үлдэгдэл (2022.12.31-ний өдрийн байдлаар), тэрбум төгрөг
	Эхний үлдэгдэл	Нэмж төлөгдсөн		
2020 он	23.6	1,161.1	845.2	339.5
2021 он	339.5	1,140.3	586.9	892.9
2022 он	892.9	2,878.0	2,325.3	1,445.6
ДҮН	23.6	5,179.4	3,757.4	1,445.6

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.59 Их хэмжээний урьдчилгаа төлбөр авч нүүрс борлуулах гэрээ байгуулсан нь хил, гаалийн нэвтрүүлэх чадамжаас шалтгаалж, дараа нийлүүлэх нүүрсний хэмжээ, борлуулалтын гэрээний өглөгийн үлдэгдэл нэмэгдэж, орлогыг урьдчилан авч зарцуулснаас тайлант хугацааны гадаад валютын орох урсгалыг бууруулж байна.

3.60 ТУЗ-ын 2021 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “нүүрсний борлуулалтын урьдчилгаа төлбөрөөс хамаарсан үнийн хөнгөлөлт үзүүлэх удирдамж”-ын 4 дэх хэсэгт заасны дагуу урьдчилгаа төлбөрийн хэмжээнээс хамаарч дараах үнийн хөнгөлөлт үзүүлэхээр байна. Үүнд:

- 5.0-7.5 сая ам.доллар хүртэл төлбөл 4.0 хувь;
- 7.5-10.0 сая ам.доллар хүртэл төлбөл 5.0 хувь;
- 10.0-15.0 сая ам.доллар хүртэл төлбөл 6.0 хувь;
- 15.0-20.0 сая ам.доллар хүртэл төлбөл 7.0 хувь;

- 20.0-50.0 сая ам.доллар хүртэл төлбөл 8.0 хувь;
- 50.0-100.0 сая ам.доллар хүртэл төлбөл 10.0 хувь;
- 100.0 сая ам.доллар буюу түүнээс дээш төлбөл 12.0 хувь.

3.61 Удирдамжид үндэслэн 2021 оны 5 дугаар сараас 2022 оныг дуусталх хугацаанд урт хугацааны гэрээт коксжих нүүрс худалдан авагчийн гэрээний үнийг индексжүүлснээс 81.1 сая ам.доллар, гэрээт олборлогч аж ахуйн нэгжүүдийн төлбөрийг нүүрсээр барагдуулахад 10.3 сая ам.долларын үнийн хөнгөлөлт үзүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 20. Урт хугацааны гэрээтэй коксжих нүүрс худалдан авагчийн гэрээний үнийг индексжүүлсэн болон урьдчилгаа төлбөрийн хэмжээнээс хамаарч үзүүлсэн үнийн хөнгөлөлт

Он	Нэр, төрөл	Хэмжих нэгж	Улирал бүр үнийг индексжүүлж үзүүлсэн хөнгөлөлт	Урьдчилгаа төлбөрийн хэмжээнээс хамаарч үзүүлсэн хөнгөлөлт		Эрчим хүчний нүүрсний үнийн хөнгөлөлт	Нийт дүн
				4 хувь	5 хувь		
2021	Коксжих нүүрс	Мян.тонн	382.9	115.5			498.4
	Үнийн хөнгөлөлт, мянган ам.доллар	Мянган ам.доллар	4,968.5	489.5			5,458.0
2022	Коксжих нүүрс, мян.тонн	Мян.тонн	4,613.2	1,799.6	127.7	98.8	6,639.2
	Үнийн хөнгөлөлт, мянган ам.доллар	Мянган ам.доллар	65,457.6	9,004.5	811.7	390.4	75,664.2
Нийт хөнгөлөлт тооцож борлуулсан нүүрс		Мян.тонн	4,996.1	1,915.1	127.7	98.8	7,137.6
Нийт хөнгөлөлт, мянган ам.доллар		Мянган ам.доллар	70,426.1	9,494.0	811.7	390.4	81,122.2

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

Хүснэгт 21.Гэрээт олборлогчдын уулын ажлыг гүйцэтгэлийн төлбөрийг барагдуулахад үзүүлсэн хөнгөлөлт

Он	Нэр, төрөл	Үнийн хөнгөлөлт үзүүлсэн хэмжээ					Нийт дүн
		4 хувь	5 хувь	6 хувь	8 хувь	10 хувь	
2021	Коксжих нүүрс, мян.тонн	-	64.2	5.2	3.3	-	72.7
	Үнийн хөнгөлөлт, мянган ам.доллар	-	406.3	39.7	33.3	-	479.3
2022	Коксжих нүүрс, мян.тонн	36.3	3.6	93.2	204.2	444.0	781.4
	Үнийн хөнгөлөлт, мянган ам.доллар	208.0	27.4	797.0	2,374.9	6,438.4	9,845.7
Нийт хөнгөлөлт тооцож борлуулсан нүүрс		36.3	67.8	98.5	207.5	444.0	854.1
Нийт хөнгөлөлт, мянган ам.доллар		208.0	433.7	836.7	2,408.2	6,438.4	10,325.0

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.62 Үнийн хөнгөлөлт үзүүлсэн нүүрсний хэмжээг борлуулсан нүүрсний хэмжээтэй харьцуулахад 2021 онд борлуулсан коксжих нүүрсний 9.4 хувьд, 2022 онд борлуулсан коксжих нүүрсний 76.4 хувьд, эрчим хүчний нүүрсний 6.0 хувьд үнийн хөнгөлөлт үзүүлсэн байна. Нийт борлуулалтын орлогод үнийн хөнгөлөлтийн эзлэх хувийг авч үзвэл (Монгол банкны оны эцсийн хаалтын ханшаар тооцсон) 2021 онд 1.5 хувийг эзэлж байсан бол 2022 онд 8.4 хувь болж нэмэгджээ. Иймд аудитаар ТУЗ-ийн дээрх тогтоолыг хүчингүй болгох албан шаардлага хүргүүлээ.


3.63 Компани сорчлон олборлож буй коксжих нүүрсээ зах зээлийн үнэд хүргэн борлуулаагүй байхад дахин гэрээний хямдрал үзүүлж байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-д “ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий хуулийн этгээд ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах” гэж заасныг зөрчиж, компанийн орлого буурах үр дагаварт хүргэж байна.

3.64 Удирдамжаар баталсан үнэ бууруулах үндэслэл нь эрх зүйн хувьд чадамжгүй байх тул “нүүрсний борлуулалтын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах удирдамж” баталсан ТУЗ-ын 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг хүчингүй болгох албан шаардлагыг хүргүүлэв.

Эрдэнэс-Тавантолгой ХК Чалко трейдинг хонконг ХХК-д борлуулалтын дундаж үнээс доогуур үнээр борлуулж 306.2 тэрбум төгрөгийн орлого олох боломжийг алдсан байна

3.65 Эрдэнэс-Тавантолгой ХК 2018-2022 онд Чалко трейдинг хонконг ХХК-д Цанхийн зүүн уурхайгаас 14.4 сая тонн коксжих нүүрс борлуулахдаа бусад компанид коксжих нүүрс борлуулсан үнээс тонн тутамд 0.4-13.5 ам.доллараар доогуур үнээр борлуулахаар гэрээ байгуулснаар 107.3 сая ам.доллар буюу 306.2 тэрбум төгрөгийн орлого олох боломжийг алдсан байна.

График 16. Чалко трейдинг хонконг ХХК болон бусад компанид борлуулсан коксжих нүүрсний үнэ, ам.доллар



Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.66 Энэ нь Цагаан хад хүртэл тээвэрлэх нөхцөлтэй коксжих нүүрсний үнийг тонн тутамд тухайн үеийн Ганцмод боомтын түүхий коксжих нүүрсний үнэ болох 124.3 ам.доллараас хилийн хураамж, агуулахын зардалд 6.4 ам.доллар, БНХАУ-ын НӨАТ-т 17 хувь, импортын татварт 3 хувь, Ганцмод боомт болон Цагаанхад хоорондын тээврийн зардалд 4.0 ам.доллар, нийт татвар хураамжид 35.3 ам.долларыг хасаж 89.0 ам.доллараар тогтоохоор байхад Эрдэнэс-Тавантолгой ХК, Чалко трейдинг хонконг ХХК-тай 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан А/11/040 дугаартай гэрээний 8.1-д 70.0 ам.доллар буюу 19.0 ам.доллараар бага тогтоосноос шалтгаалсан байна.

3.67 Чалко Трэйдинг Хонгконг компанитай байгуулсан гэрээний дагуу анхны үнэ нь 70 ам.доллараар тогтсон боловч гэрээний нэмэлт өөрчлөлтөөр гэрээний үнэ, үнэ тогтоох аргачлал болон бусад сайжруулах нөхцөлүүдийг оруулсан байна. Тухайлбал,

- 2014, 2016, 2018 онуудад нүүрсний үнэ тогтоох индекс тооцох аргачлалд өөрчлөлт оруулж, индексийн багцад 2 индексийг өөр индексээр орлуулж, 1 индексийг шинээр нэмснээр Чалко Трэйдинг Хонгконг компанийн үнэ бусад спот гэрээний үнээс 24 хувиар бага байсныг өөрчилж, 2022 оны 4 дүгээр сар хүртэл тус гэрээний үнэ нь бусад гэрээний спот үнээс 17.0 хувиар бага байна.
- Мөн 2022 оны 3 дугаар сард гэрээний үндсэн хугацаа дуусаж³¹, 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэлт гэрээ 5 жилийн хугацаа хэрэгжиж эхэлсэн тул спот үнээс 17.0 хувиар бага тогтдог байсан хувийг бууруулж, нүүрсний суурь үнийг тонн тутамд 6.63 ам.доллараар нэмэгдүүлснээр тус гэрээний үнэ нь бусад богино хугацаат гэрээний үнээс 12.5 хувиар бага байхаар шинэчлэн тогтсон байна.

3.68 Чалко Трэйдинг Хонгконг компанийн борлуулалт нийт борлуулсан нүүрсний 22.1 хувийг эзэлж байгаа бөгөөд борлуулалтын өгөөжийг тооцож үзвэл нүүрс нийлүүлснээс хүртсэн санхүүгийн өгөөж тус компанид нийлүүлэх нүүрсний үнийн хөнгөлөлтөөс шалтгаалсан алдагдсан боломжийн өртөгтэй ойролцоо дүнтэй байна.

³¹ 2017 онд уг гэрээний хугацааг 5 жилээр сунгадаг нь үндсэн гэрээний заалттай шууд холбоотой. Үндсэн гэрээнд урьдчилгаа төлбөр төлөгдөж дууссаны дараа гэрээний хугацааг ямар нэгэн маргаангүйгээр 5 жилээр сунгах талаар тусгасан тул уг заалтын хүрээнд гэрээний хугацааг 5 жилээр сунгасан байдаг.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хүснэгт 22. Чалко Трэйдинг Хонгконг компанийн борлуулалт, түүний тооцсон өгөөж, сая ам.доллар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	Нийт дүн
Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нийт борлуулалт	Сая ам.доллар	801.6	1,000.5	591.7	396.1	1,109.5	3,899.2
Чалко Трэйдинг Хонгконг компанийн борлуулалт	Сая ам.доллар	209.7	386.1	140.2	45.6	79.5	861.0
Чалко Трэйдинг Хонгконг компанийн борлуулалтын Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нийт борлуулалтад эзлэх хувь	Хувь	26.2	38.6	23.7	11.5	7.2	22.1
Чалко Трэйдинг Хонгконг компаниас авсан урьдчилгаа төлбөр	Сая ам.доллар	-	-	50.0	55.8	250.0	-
Монголбанкны бодлогын хүү	Хувь	10.0	11.0	6.0	6.0	9.0	-
Хөгжлийн банкны бонд (DBM 2023)-ын өгөөж	Хувь	7.3	7.3	7.3	-	-	-
Эрдэнэс-Тавантолгой бонд (USD бонд)-ын өгөөж, хувь	Хувь	-	-	-	5.8	5.8	-
Монголбанкны бодлогын хүүгээр тооцсон өгөөж	Сая ам.доллар	75.4	86.8	21.8	4.1		188.0
Бондын хүүгээр тооцсон өгөөж	Сая ам.доллар	60.3	77.4	16.7	2.6		157.1
Чалко Трэйдинг Хонгконг компани болон Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн бусад нүүрсний борлуулалтын үнийн зөрүү	Сая ам.доллар	801.6	1,000.5	591.7	396.1	1,109.5	3,899.2

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, аудитын тооцоолол

Нүүрс олборлох нэгжийн өртгийг Цанхийн баруун болон зүүн хэсэгт олборлогч компанитай харилцан адилгүй нөхцөлөөр гэрээ байгуулж зардал хэмнэх боломжийг алдсан байна

3.69 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нэг тонн коксжих нүүрсний олборлох өртөг Цанхийн зүүн болон баруун уурхайд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 23.Цанхийн зүүн болон баруун уурхайн өртөг, төгрөг

Уурхайн хэсэг	Нүүрсний төрөл	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Цанхийн зүүн хэсэг	Коксжих нүүрс	85,626.56	78,644.81	89,012.75	124,059.97	166,023.06
	Исэлдсэн нүүрс	30,884.99	28,512.16	42,922.74	33,003.91	68,419.72
Цанхийн баруун хэсэг	Коксжих нүүрс	69,346.00	55,622.17	120,286.69	162,221.90	178,777.15
	Исэлдсэн нүүрс	37,134.86	41,259.06	43,727.63	37,274.41	68,733.86

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

График 17. Цанхийн зүүн хэсгийн коксжих нүүрсний өртгийн бүтэц





График 18. Цанхийн баруун хэсгийн коксжих нүүрсний өртгийн бүтэц



Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, аудитын тооцоолол

График 19. Цанхийн зүүн хэсгийн исэлдсэн нүүрсний өртгийн бүтэц





График 20. Цанхийн баруун хэсгийн исэлдсэн нүүрсний өртгийн бүтэц



Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, аудитын тооцоолол

3.70 Өртгийн бүтцээс харвал Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нийт зардалд эзлэх гэрээт олборлогчийн зардал 2018 онд 49.4 хувь, 2019 онд 65.1 хувь, 2020 онд 67.3 хувь, 2021 онд 53.1 хувь, 2022 онд 43 хувийг тус тус эзэлж байна. Гэрээт олборлогчоор Цанхийн зүүн уурхайд аудитын хамрах хугацаанд Ти Эн түншлэл, Цанхийн баруун уурхайд Хишиг Арвин Индустриал ХХК, Моннис Майнинг ХХК, Таван толгой оператор түншлэл ХХК-ууд хөрс хуулалт, нүүрс олборлолт, ачилтын ажлыг гүйцэтгэж, Бортээгийн уурхайд МТАС түншлэл хөрс хуулалт, өрөмдлөг тэсэлгээ, нүүрс олборлолт, нүүрс баяжуулалт, ачилтын ажлыг тус тус гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна.

3.71 Гэрээт олборлогч компанийн 1 м.куб уулын цул хөдөлгөх зардлыг Цанхийн зүүн уурхайд 2018, 2019, 2020, 2021 оны 2 дугаар сар хүртэл 4,389 ам.доллар буюу 12,000.9³² төгрөгөөр, Цанхийн баруун уурхайд Хишиг Арвин Индустриал ХХК 2018, 2019 онд 6,475.0

³² Монголбанкны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хаалтын ханшаар 1 ам.долларын 2,734.33 төгрөгөөр тооцов.

төгрөгөөр³³, Эм Эм И Кью ХХК 6,384.0 төгрөгөөр³⁴ тус тус тооцсон нь Цанхийн зүүн уурхайн уулын цул хөдөлгөх зардал Цанхийн баруун уурхайн уулын цул хөдөлгөх зардлаас 46.8 хувиар өндөр байна.

3.72 Харин 2021 оноос эхэлж Цанхийн баруун болон зүүн хэсгийн 1 м.куб уулын цул хөдөлгөх гэрээний үнэ ойртож, хамгийн сүүлд 2022 оны 8 дугаар сарын 12-ны өдөр орсон гэрээний нэмэлт өөрчлөлтөөр Цанхийн баруун хэсэгт 1 м.куб уулын цулыг 11,904.70-11,940.20 төгрөгөөр, Цанхийн зүүн хэсэгт Ти Эн түншлэл 2021 оны 11 дүгээр сараас 1 м.куб уулын цулыг 10,366.00 төгрөг, Бортээгийн уурхайд МТАС түншлэл 2021 оны 11 дүгээр сараас 1 м.куб уулын цулыг 9,707.00 төгрөгөөр тус тус хийсэн байна.

Хүснэгт 24. Гэрээт олборлогчийн гэрээний үнээрх хөрс хуулалт, олборлолтын үнэ

Гэрээт олборлогч	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Цанхийн зүүн хэсэг	Ти Ти Жи Ви Си	Хөрс хуулалт	м.куб.ам.доллар	4,389	4,389	4,389	
	Өү ХХК	Олборлолт	м.куб.ам.доллар	4,389	4,389	4,389	
	Хишиг Арвин	Хөрс хуулалт	м.куб.төгрөг				10,085.10
	Индустриал ХХК	Олборлолт	м.куб.төгрөг				10,085.10
	Эм Эм И Кью ХХК	Хөрс хуулалт	м.куб.төгрөг				10,115.20
		Олборлолт	м.куб.төгрөг				10,115.20
	Тавантолгой	Хөрс хуулалт	м.куб.төгрөг				10,113.00
	Оператор Түншлэл	Олборлолт	м.куб.төгрөг				10,113.00
Цанхийн баруун хэсэг	Хишиг Арвин	Хөрс хуулалт	м.куб.төгрөг	6,475	6,475	6,475	10,085.10
	Индустриал ХХК	Олборлолт	м.куб.төгрөг	6,475	6,475	6,475	10,085.10
	Эм Эм И Кью ХХК	Хөрс хуулалт	м.куб.төгрөг	6,384	6,384	6,384	10,115.20
		Олборлолт	тонн төгрөг	4,111	4,111	4,111	10,115.20
	Тавантолгой	Хөрс хуулалт	м.куб.төгрөг				10,113.00
	Оператор Түншлэл	Олборлолт	м.куб.төгрөг				10,113.00
Бортээгийн хэсэг	МТАС түншлэл	Хөрс хуулалт	м.куб.төгрөг				9,707.00
		Олборлолт	м.куб.төгрөг				9,707.00

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн гэрээт олборлогч компанитай байгуулсан гэрээ

3.73 Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогчийн уулын ажил гүйцэтгэсэн үнийг Цанхийн баруун уурхайн үнээр тооцон харьцуулж үзэхэд 2018 онд 185.3 тэрбум, 2019 онд 293.8 тэрбум, 2020 онд 103.7 тэрбум төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь олборлолт хийж байгаа 2 хэсгийн 1 м.куб уулын цул олборлох үнэ зөрүү ихтэй байгаагаас 2018-2020 онд 582.8 тэрбум төгрөгийн зардал хэмнэх боломжийг алджээ.

Хүснэгт 25. Цанхийн зүүн уурхайн олборлолтыг Цанхийн баруун уурхайн үнээр тооцсон байдал

Харьцуулсан үзүүлэлт	2018 он			2019 он			2020 он		
	Хөдөлгөсөн уулын цул	1 м.куб уулын цул олборлох үнэ	Гэрээт ажлын төлбөр	Хөдөлгөсөн уулын цул	1 м.куб уулын цул олборлох үнэ	Гэрээт ажлын төлбөр	Хөдөлгөсөн уулын цул	1 м.куб уулын цул олборлох үнэ	Гэрээт ажлын төлбөр
Хэмжих нэгж	сая м.куб		тэрбум төгрөг	сая м.куб		тэрбум төгрөг	сая м.куб		тэрбум төгрөг
Ти Ти Жи Ви Си	41.6	4,389	454.7	59.4	4,389	678.4	21.2	4,389	240.8
Өү ХХК		ам.доллар			ам.доллар			ам.доллар	
Ти Ти Жи Ви Си	41.6	6,475.0	269.4	59.4	6,475.0	384.6	21.2	6,475.00	137.1
Өү ХХК-ийн олборлосон уулын цулыг Цанхийн баруун хэсгийн үнээр тооцоход		төгрөг			төгрөг			төгрөг	
Зөрүү			185.3			293.8			103.7
Нийт зөрүү									582.8

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн гэрээт олборлогч компанитай байгуулсан гэрээ, олборлолтын дүн, аудитын тооцоолол

3.74 Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогчтой байгуулсан гэрээнд аливаа төлбөрийг ам.доллароор төлөхөөр зааснаас нийт 5.0 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн (ҮАГ-аас өмнөх хийсэн аудитад 2013-2018 онд 28.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээснийг нийлүүлж тооцвол 33.1 тэрбум төгрөг болно) нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1³⁵ дэх заалттай нийцэхгүй байна.

³³ Хишиг Арвин Индустриал ХХК-ийн 2020 оны 1 м.куб уулын цул олборлох үнэ 9,399.0 төгрөг болж нэмэгдсэн.

³⁴ Эм Эм И Кью ХХК-ийн 2020 оны 1 м.куб уулын цул олборлох үнэ 9,427.0 төгрөг болж нэмэгдсэн.

³⁵ Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.

3.75 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 4/79 дугаар албан бичгээр Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогч Ти Ти Жи Ви Си Өү ХХК-ийн гэрээг цуцлах зөвлөмж, чиглэл өгсөн ч одоог хүртэл хэрэгжээгүй байна.

3.76 Энэ нь Эрдэнэс-Тавантолгой ХК, Ти Ти Жи Ви Си Өү ХХК хоорондын 2015 онд байгуулсан нэмэлт гэрээний үндсэн хугацаа 38 сар³⁶ бөгөөд гэрээний гүйцэтгэл 70 хувиас дээш бол 2 удаа 24 сараар³⁷ сунгахаар зааснаас эхний сунгасан хугацаа 2021 оны 3 дугаар сард дууссан байна. Харин гэрээний үүргээ 2018 онд 128 хувь, 2019 онд 100 хувиар биелүүлсэн гэж талууд дүгнэсэн тул гэрээ шууд сунгах нөхцөл бүрдсэн байна.

3.77 Эрдэнэс-Тавантолгой ХК, Ти Ти Жи Ви Си Өү ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний хугацаа 2021 оны 3 дугаар сард дуусаж, 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр ЭТТ-2021/705 дугаартай гэрээг Ти Эн түншлэлтэй 3 жилээр байгуулсан. Ти Эн түншлэлд Ти Ти Жи Ви Си Өү ХХК, Норманд ХХК, Си Ар Найнтээн Бюро ХХК-ууд багтаж байна.

3.78 Мөн 2021 онд Бортээгийн уурхайг ашиглах зорилгоор ТУЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоолын дагуу тендер зарлаж, 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр МТАС түншлэлтэй ЭТТ-2021/750 дугаартай хөрс хуулалт, өрөмдлөг тэсэлгээ, нүүрс олборлолт, нүүрс баяжуулалтын ажил гүйцэтгэх гэрээг байгуулжээ.

3.79 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нүүрс ачилтын ажлыг 2018, 2019 онд Цанхийн зүүн уурхайд Ти Ти Жи Ви Си Өү ХХК, Цанхийн баруун уурхайд 2018 онд Олборлогч ХХК, 2019 онд Хишиг Арвин Индустриал ХХК-ийн ачигч техникийг түрээсэлж өөрөө гүйцэтгэж байсан бол 2020-2022 онд Эрдэнэс-Тавантолгой ХК, Ти Ти Жи Ви Си Өү ХХК, Хишиг Арвин Индустриал ХХК, МПМ Ресурс ХХК, Алтан Говь Транс ХХК, Таван толгой оператор түншлэл, Тэсүн Майнинг ХХК, Моннис Майнинг ХХК, Кэй Эй Рентал Сервис ХХК-ууд гүйцэтгэж байна.

3.80 Ачилтын зардал 2018 онд нийт зардлын 1.9 хувь буюу 22.3 тэрбум, 2019 онд нийт зардлын 2.0 хувь буюу 25.8 тэрбум, 2020 он 27.9 тэрбум, 2021 он 8.7 тэрбум, 2022 онд 17.3 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 26. Цанхийн зүүн, баруун уурхайгаас ачсан нүүрсний нийт хэмжээ, ачилтын зардал

Уурхайн нэр	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Цанхийн зүүн уурхай	Нийт ачсан нүүрс	Сая тонн	13.1	15.5	8.1	3.6	7.1
	Ачилтын зардал	Сая төгрөг	18,926.3	22,643.0	21,299.0	6,235.8	11,779.9
Цанхийн баруун уурхай	Нийт ачсан нүүрс	Сая тонн	4.6	5.1	3.8	2.7	3.3
	Ачилтын зардал	Сая төгрөг	3,404.4	3,201.0	6,565.8	2,490.7	5,524.7
Нийт	Нийт ачсан нүүрс	Сая тонн	17.7	20.6	11.9	6.3	10.5
	Ачилтын зардал	Сая төгрөг	22,330.7	25,844.8	27,864.8	8,726.5	17,304.7

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ачилтын дүн

3.81 Эрчим хүчний нүүрсийг 2020-2021 онд 464.5 мянган тонн нүүрсийг өртгөөс бага үнээр борлуулсан байна. Энэ нь нүүрс баяжуулах үйлдвэр байхгүй, тээвэрлэх дэд бүтэц хөгжөөгүйгээс холбоотойгоор эрчим хүчний нүүрсийг ашигтай байхаар борлуулах боломжгүй байдалд хүргэсэн байна.

³⁶ 2018 оны 3 дугаар сарын 04-ний өдөр дуусна.


³⁷ 1 дүгээр сунгалт 2021 оны 3 дугаар сарын 04-ний өдөр дуусна.

Хүснэгт 27. Эрчим хүчний нүүрсний үнэ өртгийн харьцуулалт, ам.доллар

Он	Эрчим хүчний нүүрсний зах зээлийн үнэ /sxcoal.com/	Эрчим хүчний нүүрсний жигнэсэн дундаж үнэ	Эрчим хүчний нүүрс олборлож байгаа өртөг
2018	41.2	15.4	14.0
2019	39.5	10.7	10.9
2020	40.4	9.9	15.5
2021	59.5	13.1	11.4
2022	84.3	36.5	21.8

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, sxcoal.com

График 21. Эрчим хүчний нүүрсний үнэ өртгийн харьцуулалт, ам.доллар



Компанийн борлуулсан бүтээгдэхүүний нэгжийн үнэ өссөн байна

3.82 Эрдэнэс-Тавантолгой ХК 2018 онд 11.7 сая тонн коксжих нүүрс борлуулж 780.7 сая ам.доллар, 1.4 сая тонн исэлдсэн нүүрс борлуулж 20.8 сая ам.доллар, 2019 онд 15.0 сая тонн коксжих нүүрс борлуулж 994.8 сая ам.доллар, 0.5 сая тонн исэлдсэн нүүрс борлуулж 5.6 сая ам.доллар, 2020 онд 11.6 сая тонн коксжих нүүрс борлуулж 588.1 сая ам.доллар, 0.3 сая тонн исэлдсэн нүүрс борлуулж 3.4 сая ам.доллар, 2021 онд 6.0 сая тонн коксжих нүүрс борлуулж 393.3 сая ам.доллар, 0.2 сая тонн исэлдсэн нүүрс борлуулж 2.8 сая ам.доллар, 2022 онд 8.9 сая тонн коксжих нүүрс борлуулж 1,052.5 сая ам.доллар, 2.5 сая тонн исэлдсэн нүүрс борлуулж 92.7 сая ам.долларын орлоготой ажилласан байна.

Хүснэгт 28. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн борлуулалтын мэдээ

Он	Исэлдсэн нүүрс (эрчим хүчний нүүрс)			Коксжих нүүрс		
	Хэмжээ, мян. тонн	Мөнгөн дүн, мян.ам.доллар	Жигнэсэн дундаж үнэ, ам.доллар	Хэмжээ, мян. тонн	Мөнгөн дүн, мян.ам.доллар	Жигнэсэн дундаж үнэ, ам.доллар
Цанхийн зүүн уурхай						
2018	593.5	8,949.7	15.08	7,855.7	513,518.3	65.37
2019	509.1	5,541.5	10.88	9,380.9	600,784.1	64.04
2020	216.6	2,164.3	9.99	7,907.9	400,215.3	50.61
2021	189.3	1,995.0	10.54	3,460.3	218,771.0	63.22
2022	889.7	31,670.7	35.60	6,641.3	784,154.0	112.70
Цанхийн баруун уурхай						
2018	783.8	11,848.7	15.12	3,857.0	267,229.3	69.28
2019	8.8	92.0	10.50	5,598.9	394,031.0	70.38
2020	131.5	1,265.5	9.62	3,642.9	187,918.5	51.58
2021	64.8	843.9	13.02	2,592.0	174,540.0	67.34
2022	1,648.7	61,051.7	37.00	2,267.5	268,381.9	118.40

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны борлуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

3.83 Борлуулалтын гүйцэтгэлийн тайлангаас харахад коксжих нүүрсний тонн тутмын борлуулалтын үнэ 2022 онд сүүлийн 5 жилийн дунджаас 2.2 дахин, эрчим хүчний нүүрсний тонн тутмын борлуулалтын үнэ 2022 онд сүүлийн 5 жилийн дунджаас 1.6 дахин нэмэгдсэн байна. Борлуулалтын гүйцэтгэлийн тайлангаарх борлуулсан нүүрсний тоо хэмжээ компанийн уулын ажлын тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. (Зөрүүг хавсралт 8-аас харна уу.)

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2019-2022 оны борлуулалтын 7.2-39.8 хувь нь төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг нүүрсээр барагдуулахад зарцуулагдаж байгаа нь тус компанийг мөнгөн хөрөнгийн дутагдалд оруулах эрсдэлтэй байна

3.84 Эрдэнэс-Тавантолгой ХК борлуулалтын орлогын 2020 онд 31.0, 2021 онд 39.8, 2022 онд 22.2 хувийг нүүрсээр төлбөр барагдуулахад зарцуулсан нь компани мөнгөн хөрөнгийн дутагдалд оруулах эрсдэлтэй тул төсөл хөтөлбөрийг эрэмбэлэх замаар үе шаттайгаар хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна.

Хүснэгт 29. Гэрээний төлбөрийг нүүрсээр барагдуулсан тоо хэмжээ, үнийн дүн

Төслийн нэр	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022
Тавантолгой-Гашуунсухайт төмөр зам	мян.тонн	-	1,200.0	3,686.8	1,982.4	1,242.4
	сая ам.доллар	-	72.0	183.5	122.1	126.9
Богдхан төмөр зам	мян.тонн	-	-	-	-	257.8
	сая ам.доллар	-	-	-	-	26.3
Газрын тос боловсруулах үйлдвэр	мян.тонн	-	-	-	-	154.5
	сая ам.доллар	-	-	-	-	18.3
Тавантолгой түлш ХХК-ийн сайжруулсан түлш болон тоног төхөөрөмжийн санхүүжилт	мян.тонн	-	-	-	-	49.9
	сая ам.доллар	-	-	-	-	6.0
Гэрээт олборлогч компанийн төлбөрт өгсөн нүүрс	мян.тонн	-	-	-	264.9	525.0
	сая ам.доллар	-	-	-	35.7	68.6
Нийт нүүрсээр төлсөн дүн	мян.тонн	-	1,200.0	3,686.8	2,247.3	2,229.6
	сая ам.доллар	-	72.0	183.5	157.8	246.0
Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нийт борлуулалт	мян.тонн	13,090.2	15,497.6	11,905.0	6,309.5	11,459.1
	сая ам.доллар	801.5	1,000.4	591.6	396.1	1,109.3
Нийт борлуулалтад нүүрсний төлсөн төлбөрийн эзлэх хувь	Тоо хэмжээнд	-	7.7	31.0	35.6	19.5
	Борлуулалтын орлогод	-	7.2	31.0	39.8	22.2

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

Тайлбар: Гэрээт олборлогч компанид 2021-2022 онд өгсөн нүүрсний тоо хэмжээ, үнийн дүнг хавсралт 9-өөс харна уу.

3.85 Мөн Эрдэнэс-Тавантолгой ХК нь гэрээт олборлогчдын уулын ажлын гүйцэтгэлд бондоор татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 319.6 тэрбум төгрөг, гэрээний төлбөрт 2021-2022 онд 316.0 тэрбум төгрөгийн 789.9 мянган тонн нүүрсийг хөнгөлөлттэй үнээр олгож байгаа нь үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагааг уялдуулж ажиллаагүй гэж үзэхээр байна.

3.86 Дээрх гэрээнээс “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг санхүүжүүлэх гэрээ”-ээр гүйцэтгэгчид дараах давуу байдал³⁸ олгосон байж болзошгүй тул Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ” гэж заасны дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй байна. Үүнд:

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээний хавсралт “В” болох Эрдэнэс-Тавантолгой ХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан нүүрс нийлүүлэх гэрээний (ЭТТ-2019/784/BI-TTGS-CONT-0003 дугаартай) 3.2-т “Худалдагч нь энэхүү гэрээний 3.1³⁹-д заасан санхүүжилтийг мөн гэрээгээр тохирсон нөхцөл шаардлагын дагуу Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчдад Гэрээт талбайгаас олборлосон нүүрс нийлүүлэх замаар нөхөн төлж барагдуулах бөгөөд Талууд нүүрс худалдах, худалдан авах гэрээг тусдаа байгуулна” гэж заасныг үндэслэн Бодь интернэшнл ХХК-д төлөх төлбөрийг түүний сонгосон нэрлэсэн худалдан авагчтай нүүрс борлуулах гуравласан гэрээ байгуулж, нүүрсээр төлж байна. Энэ нь гэрээг бусдад шилжүүлсэн гэх

³⁸ Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “давуу байдал” гэж энэ хуулийн 4.1³⁸-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг

³⁹ Гүйцэтгэгч нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дуусгахад шаардагдах 682,199,507 ам.доллар буюу энэхүү гэрээний 3.3-т заасны дагуу тодотгосон мөнгөн хөрөнгийг олон улсын банк, санхүүгийн байгууллага болон бусад талуудаас хөрөнгө босгох замаар санхүүжүүлнэ.

агуулга биш, харин уг гэрээний 7.1⁴⁰ дэх хэсэгт зааснаар гүйцэтгэгч буюу Бодь интернэшнл ХХК нэрлэсэн худалдан авагчийг шууд сонгон, нүүрс худалдах, худалдан авах гуравласан гэрээ байгуулах боломжийг олгосон байна.

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээний 3.3.1-д “Гүйцэтгэгч нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дуусгахад шаардагдах 682,199,507 ам.доллар буюу энэхүү гэрээний хавсралт “Б”-д заасны дагуу тодотгосон мөнгөн хөрөнгийг олон улсын банк, санхүүгийн байгууллага болон бусад талуудаас хөрөнгө босгох замаар санхүүжүүлнэ. Хөрөнгө босгохтой холбогдсон санхүүгийн болон бусад зардлыг энэхүү гэрээний хавсралт “Б” болох нүүрс нийлүүлэх гэрээний дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Гүйцэтгэгчид нийлүүлэх нүүрсний үнэд хөнгөлөлт үзүүлэх замаар нөхөн төлнө”⁴¹ гэж үнийн хөнгөлөлт үзүүлэх замаар давуу байдал тус тус олгосон байж болзошгүй байна.

3.87 Төлбөрийг нүүрсээр барагдуулах гэрээнээс 4 нь Цанхийн болон Бортээгийн уурхайг ашиглах ТЭЗҮ-д тусгагдаагүй, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн үйл ажиллагаанд хамааралгүй гэрээ байна. Үүнд:

- Газрын тос дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээ (Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай газрын тос дамжуулах хоолой);
- Богдхан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээ (Улаанбаатар хот болон Төв аймгийн нутаг дэвсгэрт баригдах төмөр замын бүтээн байгуулалт);
- Импортын түлшний арилжааны гэрээ (Тавантолгой түлш ХХК-ийн импортоор худалдан авч буй сайжруулсан шахмал түлш);
- Тавантолгой Түлш ХХК санхүүжилтийг нүүрсээр барагдуулах гэрээ; (Тавантолгой түлш ХХК-д хэрэглэх нүүрс баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, барьцалдуулагч бодис).

3.88 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн байгуулсан төлбөрийг нүүрсээр барагдуулах доорх 4 гэрээний үлдэгдэл 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Монгол банкны хаалтын ханшаар тооцсон дүнгээр 5,850.1 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 30. Төлбөрийг нүүрсээр барагдуулах гэрээний төлбөрийн үлдэгдэл

№	Төслийн нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний үнийн дүн		Гэрээний төлбөрийг барагдуулсан					Үлдэгдэл	
			Сая ам.доллар	Тэрбум төгрөг	Мөнгөн хэлбэрээр Сая ам.доллар	Тэрбум төгрөг	Хэмжээ, тонн	Нүүрсээр Сая ам.доллар	Тэрбум төгрөг	Сая ам.доллар	Тэрбум төгрөг
1	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл	2019.10.29	792.2	2,728.8*							
		2020.06.10 ⁴²	1,005.6	3,463.9*	115.6**	308.9	8,111,528.5	504.5	1,479.0	385.5	1,327.9*
2	Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл	2022.04.14		955.9		95.6					860.3
3	Газрын тос дамжуулах хоолойн төсөл	2022.04.22	388.1	1,336.8*			154,540.6	18.3	59.7	369.8	1,273.8*
4	Богдхан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилт	2022.06.27	734.6	2,530.4*	15.0**	42.7	257,783.2	26.2	11.1	693.5	2,388.1*
Дүн				8,287.0			8,523,852.3				5,850.1

Эх сурвалж. Төлбөрийг нүүрсээр барагдуулах гэрээ, санхүүгийн дансны тайлан

* 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Монголбанкнаас зарласан ханшаар 1 ам.долларыг 3,444.60 төгрөгөөр тооцов.

**Тухайн гүйлгээ гарсан өдрийн Монголбанкнаас зарласан түүхэн ханшаар тооцсон дүн.

Техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу хөрөнгийн болон үйл ажиллагааны урсгал зардлыг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна

⁴⁰ Гэрээний дагуу Худалдагчаас жил бүр Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчид нийлүүлэх нүүрсний нийт мөнгөн дүн тэнцүү байх ба Худалдагчаас гэрээний хугацаанд Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн худалдан авагчид нийлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон нүүрсний хэмжээ, хуваарийг гэрээний хавсралт “А”-аар баталгаажуулж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчид нийлүүлнэ. Нүүрс нийлүүлэх хэмжүүр нь тонн байна. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу нийлүүлэх нүүрсийг хүлээн авах нэрлэсэн Худалдан авагч ийн талаарх мэдээллийг тухайн нүүрсийг нийлүүлэхээс 14 хоногийн өмнө Худалдагчид мэдэгдэнэ.

⁴¹ Гэвч Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээний 7.2-т “Гүйцэтгэгч нь ЭТТ-тэй байгуулсан “Нүүрс нийлүүлэх гэрээ” болон энэхүү гэрээний хавсралт “А”-д заасан санхүүжилтийн хуваарь (урьдчилсан байдлаар)-ийн дагуу энэхүү гэрээний 3.3.1-д заасан мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлж, төслийн санхүүжилтэд зарцуулах үүрэгтэй бөгөөд уг санхүүжилттэй холбоотой зардал болон аливаа эрсдэлийг дангаар хариуцна.” гэж заасан нь санхүүжилттэй холбоотой зардлыг гүйцэтгэгч хариуцахаар заажээ.

⁴² Нэмэлт өөрчлөлт

3.89 Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын (хуучин нэрээр) 2011 оны “Техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах тухай” 080 дугаар тушаалаар Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн зүүн хэсгийг ил уурхайгаар ашиглах ТЭЗҮ-г, 2012 оны 134 дүгээр тушаалаар Цанхийн баруун хэсгийг ил уурхайгаар ашиглах ТЭЗҮ-г, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ХХ/2020-14-03 дугаар дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн Т/59 дугаар тушаалаар Баруун Цанхийн хэсгийн талбай дахь нөөцийг ил уурхайн аргаар ашиглах ТЭЗҮ-г, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн СТР/2021-05-01 дугаар дүгнэлтийг үндэслэн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Т/16 дугаар тушаалаар Цанхийн болон Бортээгийн хэсгийн ТЭЗҮ (Зүүн Цанхи)-г тус тус хүлээн авсан байна.

3.90 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн хүрээнд нэгдсэн ТЭЗҮ боловсруулаагүй, тусгай зөвшөөрөл бүрд ТЭЗҮ хийж, нэгдсэн төлөвлөлтгүйгээр ордыг ашиглаж байгаа нь хөрөнгө, нөөцийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг үүсгэж Тавантолгойн ордыг ашиглах нэгдсэн бодлого, төлөвлөлтгүй байгааг харуулж байна. Тухайлбал,

- Цанхийн баруун хэсгийн ТЭЗҮ-д жилд 20 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийг ордыг ашиглаж эхлэх жилээс ажиллуулахаар, харин Цанхийн зүүн хэсгийн ТЭЗҮ-д жилд 15 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийг ордыг ашиглах 4 дэх жилээс эхлэн ажиллуулахаар хоёр өөрөөр;
- Цанхийн баруун хэсгийн ТЭЗҮ-д 300 мВт-ийн хүчин чадалтай цахилгаан станц, Цанхийн зүүн хэсгийн ТЭЗҮ-д 600 мВт-ийн хүчин чадалтай цахилгаан станцыг барихаар хоёр өөрөөр тус тус төлөвлөсөн байна.
- Мөн Цанхийн баруун хэсгийн ТЭЗҮ-д нүүрсний тээврийг 2015 оноос эхэлж Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар, харин Цанхийн зүүн хэсгийн ТЭЗҮ-д Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогод заасны дагуу баригдах төмөр замаар тээвэрлэхээр төлөвлөсөн;
- 2021 оны “Баруун Цанхийн хэсгийн талбай дахь нөөцийг ил уурхайн аргаар ашиглах ТЭЗҮ”, “Цанхийн болон Бортээгийн хэсгийн ТЭЗҮ (Зүүн Цанхи)”-гээр уурхай гүнзгийрэхгүйгээр, газрын гадаргууд ойрхон коксжих чанар өндөртэй, III, IV давхаргын нүүрсийг 2031 он хүртэл сорчлох байдлаар олборлохоор тус тус төлөвлөсөн нь Тавантолгойн ордыг ашиглах нэгдсэн бодлого, төлөвлөлтгүй байгааг харуулж байна.

3.91 Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн баруун, зүүн хэсгийг ашиглах уурхайн ТЭЗҮ-д олборлох үйл ажиллагааг өөрийн тоног, төхөөрөмж, ажиллах хүчээр гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч одоог хүртэл гэрээт олборлогч компаниар гүйцэтгүүлж байна.

3.92 Гэтэл УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт “Тавантолгойн нүүрсний ордод төрийн өмчит компани ашиглалтын үйл ажиллагаа явуулах, Эрдэнэс-Тавантолгой компанийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, оператор аж ахуйн нэгжээр олборлолтын үйл ажиллагааг тодорхой хугацаанд гүйцэтгүүлэх” гэж заасан байхад одоо мөрдөж байгаа Цанхийн баруун болон зүүн хэсгийн ТЭЗҮ-д үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өөрийн тоног, төхөөрөмж, ажиллах хүчээр гүйцэтгэхээр тооцож боловсруулсан нь УИХ-ын дээрх тогтоолууд болон бодит нөхцөл байдалтай нийцэхгүй, үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөх компанийн урт хугацааны стратеги боловсруулах боломжгүйд хүргэсэн байна.

3.93 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Тавантолгойн бүлэг ордын Цанхийн зүүн, баруун хэсгийн ТЭЗҮ-ийн дагуу төсөл, хөтөлбөрт 5,262.4⁴³ тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байхад ТУЗ-өөс 2010-2019 онд нийт хөрөнгө оруулалтын 0.05 хувь буюу 287.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг баталсан нь шаардлагатай хөрөнгө оруулалтыг хангалттай төлөвлөж, компанийн үйл ажиллагааг дэмжиж өгөөгүйг харуулж байна.

⁴³ 1 ам.долларыг 2010-2019 оны дундаж 1988.36 төгрөгөөр тооцсон.

Хүснэгт 31. ТЭЗҮ-д заасан хөрөнгө оруулалт

Ордын хэсгийн нэр	Нийт хөрөнгө оруулалт (30 жил)	Анхны хөрөнгө оруулалт /эхний 4 жил/			Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа (сараар)
		Өөрийн хөрөнгө	Зээл	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	
Цанхийн зүүн хэсэг (сая ам.доллар)	1,357.7	185.8	433.5	116.0	84
Цанхийн баруун хэсэг (тэрбум төгрөг)	2,562.8	428.1	998.8	-	60
Нийт (1 ам.долларыг дунджаар 1,988.36 төгрөгөөр тооцоход)	5,262.4	892.6	2,082.6	116.0	144

Эх сурвалж: Цанхийн зүүн болон баруун хэсгийн ТЭЗҮ

3.94 Компанийн 2010-2019 онд ТУЗ-ийн баталсан 287.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас 30.1 хувь буюу 86.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь мөн ТУЗ-ийн шийдвэр хэрэгжихгүй байсныг харуулж байна.

3.95 Харин 2020 оноос эхэлж төмөр зам, усан хангамж, нүүрс баяжуулах үйлдвэрт хөрөнгө оруулж, барилга угсралтын ажил эхэлж, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд дэд бүтцийн 14 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Эдгээр төслүүдийг 2010 оноос эхлүүлсэн ч одоог хүртэл ТЭЗҮ-г эцэслэн боловсруулаагүй 6 төсөл байна. Үүнд:

- Нэгдсэн терминал (Эрдэнэс терминалын төв, Гашуунсухайт төмөр замын ШАТ, Хил холболтын төмөр зам);
- Кокс-эрчим хүчний үйлдвэрийн төсөл;
- Цагаан цавын ордоос ус ашиглах төсөл;
- Гадаргын ус (Орхон Онги) төсөл;
- Метан хийн төсөл;
- Үйлдвэрлэл технологийн паркийн ачилтын нэгдсэн төв байгуулах төсөл.

3.96 Загийн усны хоолойн гүний усыг Тавантолгой уурхай хүртэлх хоолойгоор татах төслийн барилга угсралтын ажлыг Набсан ХХК, ЧММ ХХК, Эс Энд Эй трейд ХХК зэрэг ус хангамжийн барилга угсралтын 3 компани түншлэн гүйцэтгэж байгаа бөгөөд төсөвт өртгийн тооцоонд шугам хоолойг худалдан авсан үнээс илүү үнээр тооцож, нийт 6,769.8 төгрөгийн зөрүүтэй олгосон тооцоолол гарч байна. Энэ нь төслийн нийт төсөвт өртгийг өндрөөр тооцсон байх эрсдэлтэй байна. Иймд төсөвт өртгийг дахин магадлах шаардлагатай байна. Тухайлбал,

- Зөөлөн ширмэн хоолой Ф350 – төсөвт тооцсон 1 метрийн үнэ 388.0 мянган төгрөг, худалдан авсан үнэ 364.4 мянган төгрөг, 62.1 мянган метрийн зөрүү 1,468.0 сая төгрөг;
- Хуванцар хоолой Ф355 – төсөвт тооцсон 1 метрийн үнэ 349.7 мянган төгрөг, худалдан авсан үнэ 279.5 мянган төгрөг, 60.9 мянган метрийн зөрүү 4,272.7 сая төгрөг;
- Хуванцар хоолой Ф280 – төсөвт тооцсон 1 метрийн үнэ 285.2 мянган төгрөг, худалдан авсан үнэ 237.9 мянган төгрөг, 4.4 мянган метрийн зөрүү 207.3 сая төгрөг;
- Хуванцар хоолой Ф225 рп 10 – төсөвт тооцсон 1 метрийн үнэ 185.0 мянган төгрөг, худалдан авсан үнэ 94.6 мянган төгрөг, 2.8 мянган метрийн зөрүү 251.2 сая төгрөг;
- Хуванцар хоолой Ф225 рп 10 – төсөвт тооцсон 1 метрийн үнэ 185.0 мянган төгрөг, худалдан авсан үнэ 94.6 мянган төгрөг, 2.8 мянган метрийн зөрүү 251.2 сая төгрөг;
- Хуванцар хоолой Ф225 рп 16 – төсөвт тооцсон 1 метрийн үнэ 201.2 мянган төгрөг, худалдан авсан үнэ 158.2 мянган төгрөг, 9.4 мянган метрийн зөрүү 404.3 сая төгрөг;
- Хуванцар хоолой Ф160 рп 16 – төсөвт тооцсон 1 метрийн үнэ 126.7 мянган төгрөг, худалдан авсан үнэ 104.9 мянган төгрөг, 7.3 мянган метрийн зөрүү 158.8 сая төгрөг;
- Хуванцар хоолой Ф125 – төсөвт тооцсон 1 метрийн үнэ 89.2 мянган төгрөг, худалдан авсан үнэ 85.9 мянган төгрөг, 2.3 мянган метрийн зөрүү 7.5 сая төгрөг.

3.97 Компани уурхайн үндсэн үйл ажиллагаанд хөрөнгө оруулах чиглэлээр 2020-2022 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээс харахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг төсөвлөөгүй, төсөл арга хэмжээний төсөвт өртөгт нийцсэн санхүүжилт төлөвлөөгүй, уурхайд нэгдмэл байдлаар ажиллах явуулах техникийн шийдлийг сонгоогүй буюу Беларусь улсын BELAZ, Герман улсын LIEBHERR, Хятад улсын XCMG (Xuzhou Construction Machinery Group co ltd) маркийн техник хэрэгслийг сонгосон нь хослон ажиллах боломжгүй, засвар үйлчилгээний төв нь тус тусдаа байхаар байна. Тухайлбал,

2020 онд:

- Уурхайн олборлолтыг өөрийн техникээр хийх зорилгоор Белаз75135 маркийн 12 ширхэг автосамосвалыг 56.2 тэрбум төгрөгөөр худалдан авсан байна.

2021 онд

- Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах чиглэлээр 6 ХАА зохион байгуулснаас хуулийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ авах, талбайн инженер геологийн дүгнэлт гаргуулах төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, техникийн зөвлөх үйлчилгээ, захиалагчийн хяналт үзүүлэх ажилд гэрээ байгуулаагүй он дамжсан, зөвхөн нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх 955.9 тэрбум төгрөгийн гэрээг Норинко интернэйшнл ХХК-тай байгуулсан байна.
- Ус хангамжийн чиглэлээр 121.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ХАА зохион байгуулснаас зөвхөн 0.2 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд хэрэгжих төслүүдийн БОНУ хийлгэх гэрээг Хатандалай ХХК-тай байгуулсан.
- Конвейерын системийн ТЭЗҮ боловсруулах 3.5 тэрбум төгрөгийн өртөгтэй ажлын тендер шалгаруулалтыг оны эцэст зарласан боловч тодорхойгүй шалтгаанаар 2022 онд төсвийг бууруулахаар төлөвлөсөн.
- Олборлолтын техник худалдан авах чиглэлээр 77.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний ХАА-г зохион байгуулахаар төлөвлөсөн боловч 27.5 тэрбум төгрөгийн 5 гэрээ байгуулсан бөгөөд худалдан авч буй техник хэрэгслийн марк, нэр төрөл, хүчин чадлаас харахад цогц байдлаар ажиллах техникийн шийдэл болж чадаагүй байна.

2022 онд:

- Олборлолтын техник худалдан авах чиглэлээр 1,266.6 тэрбум төгрөгийн өртөгтэй 8 багц ажлыг 88.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, ХАА-ны үр дүнгээр 1,170.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 10 гэрээ байгуулсан байна. Дээрх гэрээний хэрэгжилтэд Засгийн газрын Онц бүрэн эрхт төлөөлөгчийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А147 дугаар тушаалаар байгуулсан төслийн удирдлагын баг хяналт хийж, Уулын үндсэн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх ЭТТ-2022/573, ЭТТ2022/534, ЭТТ-2022/574 дугаартай гэрээний дагуу нийлүүлэх XCMG XDE130 маркийн 9 автосамосвал, XCMG XE2000 маркийн 1 экскаватор, XCMG GR3505T PRO маркийн 2 автогрейдерт дүгнэлт гаргасан байна. Үүнд:
 - **Автосамосвал** 68-аас 103 мот/цаг хэтрэлттэй, шаардлага хангахгүй дугуйтай, ослын тормосгүй, галын автомат системгүй, даац, явалтын мэдээлэх системгүй;
 - **Экскаватор** 40 мот/цаг хэтрэлттэй, галын болон байршил тогтоогч системгүй, өндөр даралтын шлаг, гидро шахуурга хөлрөлт, гоожилт ихтэй;
 - **Автогрейдер** соёогүй, шаардлага хангахгүй дугуйтай, галын, тосолгооны болон байршил тогтоогч системгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.
- Дээрх худалдах, худалдан авах гэрээний хавсралтад заасан техникүүдийг 2023 оны 1 дүгээр сард багтаан нийлүүлээгүй, мөн гэрээнд заасан техникийн тодорхойлолтын шаардлагуудтай нийцээгүй зөрчлүүд илэрсэн тул захиалагч гэрээнүүдээс татгалзаж байгаагаа нийлүүлэгчид 2023 оны 01/460 дугаар албан бичгээр мэдэгдсэн байна.

3.98 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр төмөр замын 5 төсөл хэрэгжиж байгаагаас 2019-2022 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажилд Бодь Интернэшнл ХХК-д 1,478.9 тэрбум, Тавантолгой төмөр зам ХХК-д 308.9 тэрбум, холболтын төмөр замын төслийн гүйцэтгэгч Бодь Интернэшнл ХХК-д 218.0 тэрбум, нүүрс ачих логистикийн төвийн ажлын гүйцэтгэлээр 169.8 тэрбум, Тавантолгой Зүүнбаян төмөр замын төсөлд 1,283.7 тэрбум, нийт 3,459.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулсан байна. Үүнд:

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 километр төмөр зам барих төслөөр Хилийн хяналтын бүс хүртэл төмөр зам тавьсан боловч хил холболтын төмөр замын ажил эхлээгүйгээс мухар төмөр зам болсон.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр зам барих ажил хийгдсэн ч үйл ажиллагаа нь жигдрээгүй;
- Холболтын төмөр замын ТЭЗҮ, нүүрс ачих ачилтын байгууламжийн төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж байна.

3.99 ТЭЗҮ-ээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар төслийн эхний жилд 10.56 сая тонн ачаа тээвэрлэхээр байгаа бол 2023 оны 4 дүгээр сарын 10-ны байдлаар 0.2 сая тонн, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар жилд 10.0 сая тонн ачаа тээхээр төлөвлөсөн бол 0.3 сая тонн нүүрс тус тус тээсэн байна.

3.100 Энэ нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын хил холболтын төмөр замын ТЭЗҮ бүрэн хийгдээгүй, барьж байгуулах хөрөнгө оруулалт шийдэгдээгүй, зүтгүүрүүд

нь хугацаандаа нийлүүлэгдээгүй, нүүрс ачих байгууламжийн ажил дуусаагүй, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын зүтгүүр, вагон хүрэлцээгүй, Хангийн төмөр замын хил холболтын ажил хийгдээгүй, Зүүнбаян-Сайншанд чиглэлийн төмөр замын нэвтрүүлэх хүчин чадал хүрэлцэхгүй байгаатай тус тус холбоотой байна.

3.101 Эрдэнэс Тавантолгой ХК өнөөг хүртэл өөрийн лабораторигүйгээс нүүрсний чанарын шинжилгээг гэрээгээр бусдаар гүйцэтгүүлж байна. Гэтэл ХАА-ны төлөвлөгөөнд 2018 онд нүүрсний лабораторийн барилга угсралтын ажилд 3.0 тэрбум, 2019 онд нүүрс шинжилгээний лабораторийн багаж хэрэгсэл худалдан авахад 0.9 тэрбум, 2022 онд нүүрс шинжилгээний лабораторийн байгууламж, тоног төхөөрөмж, тавилга, дагалдах хэрэгсэл нийлүүлэх түлхүүр гардуулах нөхцөлтэй ажилд 13.9 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөөд хэрэгжүүлээгүй байна. Тендер шалгаруулалтын ЭТТ/202201645 дугаартай ажлын гүйцэтгэгч шалгарсан боловч тендерийн хүчинтэй хугацаанд гэрээ байгуулаагүй байна.

3.102 ХАА-ны төлөвлөгөөнд 2018 онд нүүр баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулахад 0.9 тэрбум, 2019 онд 0.5 тэрбум, 2020 онд 0.7 тэрбум, нийт 2.1 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч хэрэгжээгүй. Мөн 2019-2020 оны ХАА-ны төлөвлөгөөнд 2.4 тэрбум төгрөгөөр төсөвлөж, Нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ, FEED боловсруулах зөвлөх үйлчилгээний ЭТТ-2020/213 дугаартай 2.4 тэрбум төгрөгийн гэрээг 2022 онд China Metallurgical Engineering Co., Ltd, Beijing Yuan Zhi Han Engineering Technology Co., Ltd, Амгалан хас ХХК-ийн консорциумтай байгуулсан байна. Гэтэл Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын **зураг төсөв боловсруулах**, барилга угсралтын ажил гүйцэтгэх 955.9 төгрөгийн дүнтэй түлхүүр гардуулах нөхцөлтэй ЭТТ-2022/222 дугаартай гэрээг Норинко Интернэйшнл Корпорэйшн болон Дади Инженеринг Группийн түншлэлтэй байгуулжээ.

3.103 Мөн нүүрсийг машин, галт тэрэгт ачих зориулалтай 12 м.куб шанагатай дугуйт ачигч авахаар 2018 онд 10.7 тэрбум, 2019 онд 11.6 тэрбум төгрөгийг тус тус төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

3.104 Тавантолгойн ордыг цогцоор нь ашиглахад шаардагдах усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Цагаанцав усны ордоос Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн уурхай хүртэл ус татах шугам хоолойн ТЭЗҮ боловсруулахад 2021 онд 0.9 тэрбум, 2022 онд 1.5 тэрбум, Хэрлэн-тооно төслийн ТЭЗҮ боловсруулахад 7.4 тэрбум төгрөгийг төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

3.105 Иймд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хэрэгжүүлж буй дээрх төсөл, хөтөлбөрт тусгайлан эрсдэлийн аудит хийх шаардлагатай байна.

Бусад үйл ажиллагааны зардлын хувьд:

3.106 Эрдэнэс-Тавантолгой ХК гадаад томилолтод 2018 онд 826.8 сая, 2019 онд 1,173.3 сая, 2020 онд 24.9 сая, 2021 онд 64.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.107 Эрдэнэс-Тавантолгой ХК гадаад томилолтод 2019 онд зарцуулсан нийт зардлын 92.5 хувь буюу 1,085.6 сая төгрөгийг гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргах бэлтгэл ажлыг хангах зорилгоор санхүүжүүлсэн ч хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргах ажил 2020 оны 4 дүгээр сард цуцлагдаж, ажлын үр дүн гараагүй байна.

3.108 Мөн 2018 онд 264.8 сая, 2019 онд 154.5 сая төгрөгөөр УИХ-ын гишүүд, УУХҮЯ-ны ажилтнууд, сэтгүүлчид гадаад томилолтоор ажиллажээ. УИХ-ын гишүүд, УУХҮЯ-ны төлөөлөл Эрдэнэс-Тавантолгой ХК-д зардал гаргуулах хүсэлт өгч гадаадад томилолтоор явсан ч тус компанийн үйл ажиллагаанд дэмжлэг болох дэд бүтцийн бүтээн байгуулалт бий

болгоогүй, одоогийн байдлаар хөрөнгө оруулалт орж ирээгүй байна. Иймд цаашид гадаад томилолтыг үр дүнтэй болгох шаардлагатай байна.

Хүснэгт 32. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн зардлаар гадаад томилолтоор ажилласан байдал

№	Томилолтоор ажиллагсдын харьяалал	Аялсан улс	Хугацаа	Зардал /сая төгрөг/	Зорилго, тайлбар
1	УУХҮЯ	БНХАУ	2018.08.15-2018.08.19	14.1	Нүүрс-хими, нүүрс-эрчим хүчний үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцсан.
2	УУХҮЯ	ОХУ	2018.09.23-2018.09.26	23.4	Уулзалт, арга хэмжээнд оролцсон
3	УУХҮЯ	Австрали улс	2018.10.29-2018.11.03	54.8	Хөрөнгө оруулагчид болон хөрөнгийн биржийн төлөөлүүдтэй уулзалт хийсэн
4	УИХ-ын гишүүд, УУХҮЯ	АНУ, Канад	2018.10.08-2018.10.14	114.8	Нью Йорк болон Торонтогийн хөрөнгийн биржийн үйл ажиллагаатай танилцсан
5	УУХҮЯ	Лондон	2018.11.22-2018.11.29	5.8	Лондон хотод жил бүр зохион Mines and Money London үзэсгэлэнд оролцсон
Нийт				264.8	
1	УУХҮЯ	БНХАУ	2019.01.13-2019.01.17	5.1	Нүүрс баяжуулах үйлдвэртэй танилцсан
2	УУХҮЯ	ОХУ	2019.01.24-2019.01.27	10.4	Нүүрс борлуулах чиглэлээр уулзалт хийсэн
3	УУХҮЯ	БНХАУ	2019.02.10-2019.02.13	2.8	Конвейерийн системийн технологитой танилцсан
4	УУХҮЯ	БНХАУ	2019.03.03-2019.03.06	4.7	
5	УИХ-ын гишүүд, УУХҮЯ, сэтгүүлчид	Канад	2019.03.01-2019.03.07	131.4	Уул уурхайн үзэсгэлэнд оролцсон
Нийт				154.5	

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018, 2019 оны санхүүгийн тайлан

3.109 Олон Улсад компанийн нийгмийн хариуцлагыг тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрээр үнэлж байна.⁴⁴ Эрдэнэс-Тавантолгой ХК нийгмийн хариуцлага нэрээр 2018 онд 531.5 сая төгрөг, 2019 онд 1,274.5 сая, 2020 онд 4,490.2 сая, 2021 онд 17,427.3 сая, 2022 онд 1,217.0 төгрөгийг баяр тэмдэглэх, арга хэмжээ зохион байгуулах зэрэгт зарцуулжээ. Тухайлбал,

2018 онд

- Цагаан сарын баяраар ахмадуудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны зардалд 20.7 сая;
- "Сонирхогчдын улсын аварга шалгаруулах сум дундын волейболын тэмцээн"-ий зардалд 3.7 сая;
- Монгол Улсын хурц Арслан Г.Дэмүүл агсны нэрэмжит барилдаан зохион байгуулах зардалд 3.0 сая;
- Орон нутгийн албан байгууллагуудад тараах материалын зардалд 2.0 сая;
- "Аз жаргалтай гэр бүл" аяны зардалд 2.4 сая;
- 6 дугаар сургуулийн ойн арга хэмжээнд 1.5 сая;
- Ажилтнуудын хүүхдүүдийг зусланд амруулахад 18.7 сая;
- Цогтцэций сумын цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих ажилд 59.3 сая;
- Азийн наадамд оролцох тамирчдын зардалд 8.8 сая;

2019 онд:

- Зүүн бүсийн "Тэмээний баяр-2019" наадмын зардалд 1.9 сая;
- Өмнөговь аймгийн Даланзадгад суманд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нэрэмжит гудамж байгуулах ажилд 105.7 сая;

2020 онд:

- Би багш реалити тэмцээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардалд 100.0 сая;
- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 27 дугаар цэцэрлэгийн дуу хөгжмийн танхимд хөгжмийн хэрэгсэл олгоход 13.8 сая;
- Будда 55 анги киноны эрх худалдан авах, олон нийтийн хүртээл болгох үйл ажиллагаанд тусламж үзүүлэх ажилд 150.0 сая;
- Цогтцэций сумын Цагаан-Овоо хайрхан, Хонгор хайрханы овоо тахилгын үйл ажиллагааны зардалд 0.6 сая;
- Монголын оюутны спортын түүхэн хөгжил ном бүтээлгэх ажлын төлбөрт 30.0 сая;
- Үндэсний их баяр наадмын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх төлбөр 30.0 сая;
- Нийгмийн харууцлагын хүрээнд БНХАУ-д өгөх 30,000 хонь хандив тусламжийн төлбөрт 2,852.9 сая;
- Монголын оюутны спортын Универсиад 5 наадмын үйл ажиллагааны зардалд 110.0 сая;

2021 онд:

⁴⁴ www.wikipedia.com

- COVID-19 цар тахлын үед ажилласан эмчийн цалин, дотоодын цэрэг байршуулсан зардал зэрэгт нийт 17,427.3 сая;

2022 онд:

- Борын сургуулийн гадна талбай, дотуур байрны гадна талбайд камер суурилуулахад 12.0 сая;
- Адуучин тэмцээнд 20.0 сая;
- 5 бүлгийн санаачилсан ажилд дэмжлэг үзүүлэхэд 25.0 сая;
- Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад багийн нутаг дахь Тайван зогсоолын эмнэлгийн тоног төхөөрөмж, үйл ажиллагааны зардалд 1,060.0 сая;
- Малчдын хороо бууц, гар худгийг сэргээн засварлахад 100.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.110 Харин Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2017-2020 оны стратегийн төлөвлөгөөнд маркетинг борлуулалтын дараах ажлуудыг хийхээр төлөвлөжээ. Үүнд:

- БНХАУ-ын коксжих нүүрсний импортын зах зээлийн 15 хувиас багагүй хувийг дангаар эзлэх;
- Хэбэй, Өвөр Монгол, Шандун, Шаньси мужуудад борлуулалтын суваг нээх;
- БНХАУ-д баяжмал нийлүүлэх борлуулалтын төлөвлөгөө боловсруулах;
- Борлуулалтын тогтвортой хамтын ажиллагаа, харилцааг тогтоох;
- Нүүрсний чанарын үзүүлэлтээс шалтгаалсан үнэ тогтоох аргачлал боловсруулах;
- ОХУ болон гуравдагч зах зээл болох Япон, Өмнөд Солонгос улсуудын зах зээлд нэвтрэх бэлтгэл хангах;
- Эрчим хүчний нүүрсийг дотоод, гадаадын зах зээлд их хэмжээгээр нийлүүлэх борлуулалтын төлөвлөгөөг боловсруулах;
- Нүүрсний давхаргын метан хий, антрацит, гөлтгөнө, галд тэсвэртэй шавар, хайрга дайрга зэрэг дагалдах ашигт малтмалыг ашиглах төсөл хэрэгжүүлэх;
- Брэнд имиж, маркетинг идэвхжүүлэлтийг сайжруулах;
- Нүүрсний үнийн уналтаас сэргийлэх гэх мэт.

3.111 Дээрх ажлыг хэрэгжүүлэхээр 2018 онд 4,374.5 сая, 2019 онд 7,188.5 сая, 2020 онд 5,129.0 сая, 2021 онд 2,496.1 сая төгрөг баталснаас 2018 онд 134.8 сая, 2019 онд 519.5 сая, 2020 онд 343.8 сая, 2021 онд 211.0 сая төгрөгийг стратеги төлөвлөгөөнд тусаагүй хэвлэл мэдээллийн хэрэгслээр (PR) компанийг сурталчлахад тус тус зарцуулсан байна.

3.112 Орон нутгийн иргэдэд компанийн үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагын утга учрыг сурталчлах, таниулах замаар байгаль орчинд ээлтэй байх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь цахилгаан, дулаан, усны хэмнэлттэй байх, хог хаягдлын хэмжээг бууруулдаг байх, мэдээллийн нээлттэй ил тод, ёс зүйтэй, хуулийн дагуу ажилладаг байх, эрүүл аюулгүй ажлын байр бий болгох, засаглалыг сайжруулах чиглэлээр үлгэр жишээ байдлаар ажиллах нь зүйтэй байна.

Худалдан авах ажиллагааг тооцоо судалгаагүйгээр төлөвлөж, гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтын хэрэгжилт хангалтгүй байна

3.113 ТУЗ-өөс Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг 2018 онд 274.6 тэрбум төгрөгөөр баталж хоёр удаагийн тодотгол хийснээр 813.0 тэрбум, 2019 онд 1,557.1 тэрбум төгрөгөөр баталж 3 удаагийн тодотгол хийснээр 3,723.6 тэрбум төгрөгөөр, 2020 онд 799.6 тэрбум төгрөгөөр баталж 3 удаагийн тодотгол хийснээр 978.3 тэрбум төгрөгөөр, 2021 онд 3,037.1 тэрбум төгрөгөөр, 2022 онд 3,676.3 тэрбум төгрөгөөр баталж 1 удаагийн тодотгол хийснээр 4,225.3 тэрбум төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт 33. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, тэрбум төгрөг, хувь

Он	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			Хэрэгжээгүй		
	Төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн
2018	549	813.0	813.0	92	225.0	225.0	457	588.0	588.0
2019	512	3,725.8	1,345.5	157	2,043.7	1,345.5	355	1,682.1	1,682.1
2020	366	978.3	184.4	76	937.8	184.4	290	40.6	40.6
2021	489	4,613.4	1,461.1	278	4,013.9	1,169.6	211	599.6	291.5

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2022	746	4,225.3	2,579.4	371	2,785.4	1,273.5	375	629.4	559.9
НИЙТ	2,662	14,355.8	6,383.4	974	10,005.8	4,198.0	1,688	3,539.7	3,162.1

3.114 Эрдэнэс-Тавантолгой ХК 2018-2022 онд 14,355.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2662 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 10,005.8 тэрбум төгрөгийн 974 төсөл, арга хэмжээний гэрээг гүйцэтгэгчтэй байгуулсан байна.

3.115 ХАА-ны төлөвлөгөөний хэрэгжилт 16.8-56.9 хувьтай, “хангалтгүй” байгаа нь хэрэгцээ шаардлагаа оновчтой тодорхойлоогүй, төлөвлөгөөнд олон удаа өөрчлөлт хийсэн, төсөвт өртөг, хэрэгжүүлэх хугацааг үндэслэлгүйгээр төлөвлөснөөс шалтгаалсан байна. Тухайлбал,

- 2018 онд Тавантолгойн ордын нөөцийн нэгтгэл тайлан батлуулахаар 45.0 сая төгрөг төсөвлөсөн боловч тодотголоор 3.2 дахин нэмэгдүүлж, 145.0 сая төгрөгөөр харьцуулалтын аргаар ХАА-г зохион байгуулсан боловч хэрэгжээгүй;
- Цанхийн баруун уурхайн хөрс хуулалтад авто-конвейерийн хосолсон тээвэртэй мөчлөг-урсгал технологийн ТЭЗҮ боловсруулахад анх 17,961.2 сая төгрөг төсөвлөсөн бол тодотголоор ТЭЗҮ боловсруулахад 3,500.0 сая төгрөг, технологийн иж бүрдэлд 248,500.0 сая төгрөг болгон нэмж төлөвлөн ТЭЗҮ боловсруулах ХАА-г зохион байгуулсан боловч оролцогчоос шүүхэд гомдол гаргасан тул зогссон;
- 2018 онд хувьцаа гаргах зорилгоор төлөвлөгөөний тодотголоор нэмэлт 270,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 18 төсөл, арга хэмжээг, 2019 онд мөн 30,037.7 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг оны дундуур нэмж төлөвлөсөн боловч үр дүн хангалтгүй;
- 2022 онд 629.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 559.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 375 хэрэгжээгүй төсөл арга хэмжээний 293 нь хэрэгжээгүй шалтгаан тодорхойгүй, 1 нь ТӨБЗГ-аас тендер шалгаруулалтыг цуцалсан, 75 нь тендер шалгаруулалтыг 1-7 удаа зохион байгуулсан боловч гүйцэтгэгч шалгараагүй, 4 нь тендер шалгаруулалтыг зохион байгуулсан боловч тендерийн хүчинтэй хугацаанд багтааж гэрээ байгуулаагүй, 2 нь тендер шалгаруулалт үргэлжилж байна гэж тайлагнажээ.
- Мөн 2018-2022 оны бараа, ажил үйлчилгээ ХАА-ны төлөвлөгөөнд туссан зарим ТАХ-ий гэрээний дүн төсөвт өртгөөс 34.5-50.0 хувь доогуур байгаагаас харахад төлөвлөлтийг хэлбэр төдий хийсэн байна.

3.116 Эрдэнэс-Тавантолгой ХК нүүрс ачилтыг утгуурт ачигч 2 ширхгийг худалдан авч, өөрийн хүчээр гүйцэтгэвэл жилд 6.0 тэрбум төгрөгийн зардал гарч жил бүр 20.4 орчим тэрбум төгрөгийн зардлыг хэмнэх тооцоо гарч байна.

3.117 Гэвч 2018-2021 оны ХАА-ны төлөвлөгөөгөөр 2 ширхэг авто ачигчийг худалдан авахаар жил бүр төлөвлөж, өртөг нь анхны өртгөөс 32.3 хувиар нэмэгдсэн боловч худалдан авалтыг үр дүнтэй зохион байгуулаагүйгээс 2019-2022 онд нийт 57.7 тэрбум төгрөгийн зардал хэмнэх боломжийг алджээ.

Хүснэгт 34. Авто ачигч болон эксковатор худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байдал

№	Төсөвт өртөг, сая төгрөг	Тендерийн			Оролцогчийн нэр
		Зарласан огноо	Нээсэн огноо	Оролцогч тоо	
1	10,648.0	2018.08.23	2018.09.25	3	Майнс ап ХХК, Барловорлд ХХК, Трансвест ХХК
		2018.12.26	2019.01.28	3	Майнс ап ХХК, Барловорлд ХХК, Трансвест ХХК
2	11,616.0	2019.10.16	2019.11.18	2	Майнс ап ХХК, Барловорлд ХХК
3	15,363.7	2020.08.13	2020.10.06	3	Замайнсервисиз ХХК, Барловорлд ХХК, Майнс ап ХХК
		2020.11.10	2020.12.14	2	Майнс ап ХХК, Барловорлд ХХК
		2020.12.31	2021.01.14	2	Майнс ап ХХК, Барловорлд ХХК
		2021.01.27	2021.02.02	2	Майнс ап ХХК, Барловорлд ХХК

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны ХАА-ны тайлан

3.118 ХАА-нд байнга оролцсон эдгээр компаниуд нь уул уурхайн техник хэрэгслийн албан ёсны дистрибьютер компаниуд байх бөгөөд ХАА хүчингүй болсон шалтгаан нь ихэвчлэн баримтын иж бүрдэл хангаагүйтэй холбоотой байна.

3.119 Засгийн газрын 2017 оны 17 дугаар хуралдааны тэмдэглэлээр ХАА-ны цахим www.tender.gov.mn нэгдсэн системийг нэвтрүүлэн ХАА-г 100 хувь цахимаар зарлах чиглэл

өгсөн бөгөөд 2018 онд нийт тендерийн 41.4 хувь, 2019 онд 93.6 хувийг, 2020 онд 94.9 хувийг, 2021 онд 68.3 хувийг, 2022 онд 56.6 хувийг тус тус цахимаар зохион байгуулсан байна.

3.120 ХАА-ны үр дүнгээр гэрээ байгуулсан зарим барилга байгууламж барих төсөл, арга хэмжээнд дараах зөрчлүүд илэрсэнд нийт 302.5 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

- Уурын зуухны зураг төсөл, төсөв боловсруулах, халаалтын халуун тогоо угсрах, барилгын ажил гүйцэтгэх ЭТТ-2021/52 дугаартай анхны гэрээг 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Эниржи Конвертер ХХК-тай 1,951.8 сая төгрөгийн дүнтэй байгуулжээ. Барилгын хөгжлийн төвийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 697/2021 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр тус барилгын төсөвт өртөг 2,473.5 сая төгрөгөөр баталгаажсан. 2021 оны 3 дугаар сарын 16, 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэл, нэмэлт ажлын төсөв, актыг үндэслэн 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр ЭТТ-2021/52-01 дугаартай 262.4 сая төгрөгийн дүнтэй нэмэлт санхүүжилтийн гэрээг байгуулсан байна. Барилгын талбай 35 м.кв-аар нэмэгдсэн байхад 63 м.кв-аар тооцож 55.6 сая төгрөгийг хасаж тооцоогүй байна;
- Уурхайн ажилчдын хотхоны барилга угсралтын ажил гүйцэтгэх ЭТТ-2020/188 дугаартай анхны гэрээг 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Лаки Лайф ХХК-тай 8,599.9 сая төгрөгөөр, Уурхайн захиргааны барилга угсралтын ажил гүйцэтгэх ЭТТ-2020/79 дугаартай анхны гэрээг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Голден Лайт Групп ХХК-тай 3,663.3 сая төгрөгөөр тус тус байгуулсан байна. Мөн захиргаа, хотхоны барилгын интерьерийн зураг төсөв боловсруулах, засварын ажил гүйцэтгэх (Түлхүүр гардуулах нөхцөлтэй) ЭТТ-2021/449 дугаартай гэрээг 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Геатера Тех ХХК-тай 691.5 сая төгрөгөөр байгуулсан. Гэтэл Лаки Лайф ХХК болон Голден Лайт Групп ХХК-ийн гэрээгээр гүйцэтгэх байсан үүдний хэсэг, хооллох танхим-VIP өрөөнүүдийн дотор засал, гэрэлтүүлгийн ажлуудын тоо хэмжээ нь Геатера Тех ХХК-ийн гүйцэтгэсэн интерьерийн ажилтай давхардсанаас Лаки Лайф ХХК-д 28.2 сая төгрөгийн, Голден Лайт Групп ХХК-д 83.1 сая төгрөгийн дүнтэй хийгээгүй ажлын гүйцэтгэлийг хасаж тооцоогүйгээр олгосон. Мөн тус барилгын 1551.04 м.кв дотор шалны ажлыг шахмал чулуу дэвсэж хийхээр байсныг плитагаар сольж хийсний зөрүү Лаки Лайф ХХК-ийн 48.3 сая, Голден Лайт Групп ХХК-ийн 30.7 сая төгрөгийг тус тус хасаж тооцоогүй байна;
- Захиргаа, хотхоны барилгын интерьерийн зураг төсөв боловсруулах, засварын ажил гүйцэтгэх (Түлхүүр гардуулах нөхцөлтэй) ажлын худалдан авах ажиллагааг 2020 онд 787.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр зарлаж барилгын угсралтын ажил гүйцэтгэх ЭТТ-2021/449 дугаартай гэрээг 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Геатера Тех ХХК-тай 691.5 сая төгрөгийн дүнтэй байгуулжээ. Гэтэл барилга угсралтын ажлын гэрээнд зураг төслийн үнэ багтсан байхад захиргаа, хотхоны барилгын интерьерийн зураг төсөл, төсөв магадлалаар баталгаажаагүй, интерьерийн зураг төсөл, төсөвт туссан 52.6 сая төгрөгийн дүнтэй ажлын санхүүжилтийг бүрэн олгосон;
- Компанийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил гүйцэтгэх ЭТТ-2020/328 дугаартай анхны гэрээг 2020 оны 5 дугаар сарын 08-ны өдөр Анверса ХХК-тай 1,175.0 сая төгрөгийн дүнтэй байгуулжээ. Тус ажлын төсөвт өртөг 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1610/2018 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр 1,262.6 сая төгрөг, 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 1153/2022 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр 272.1 сая төгрөг, 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 2146/2021 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр 212.6 сая төгрөгөөр тус тус баталгаажсан байна. Барилга угсралтын ажил гүйцэтгэх 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн ЭТТ2020/328-03 дугаартай нэмэлт ажлын гэрээг 2020 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийсэн 01 дугаартай дүгнэлт, 2020 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэл, 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн барилгын буурь хөрсний хяналтын акт, 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн Буурь хөрс ХХК-ийн чулуулгийн өгөршлийн зэрэг тодорхойлох туршилтаар инженер геологийн судалгааны дүгнэлтээс зөрсөн тул газар шорооны ажилд 170.5 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээг байгуулжээ. Гэвч 170.5 сая төгрөгийн ажлын төсвийг магадлалаар баталгаажуулаагүй, 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1610/2018 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан ажлын тоо хэмжээтэй харьцуулахад 4.0 сая төгрөгийн зөрүүтэй тооцсон байна.


3.121 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт баригдаж буй төсөл, арга хэмжээний барилга, байгууламжийн чанар байдалтай танилцахад ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт үр нөлөөгүй, барилгын материал сольж чанар байдлыг доройтуулсан, илүү санхүүжилт авсан зэрэг илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Уурхайн ажилчдын хотхоны барилгын зураг төсөл, төсөвт туссан барилгын гадна ханын (консолын) зарим хэсэгт дулаалгыг галд тэсвэртэй чулуун хөвөнгөөр хийхээр байсныг хөөсөөр, өргийн ажлын цутгамал төмөр бетон ялууг арматураар өөрчилж хийсэн. Мөн дотор цахилгаан, холбоо дохиоллын ажлыг хийхдээ цутгамал төмөрбетон дам нуруунд CD хар хоолой хийж гүйцэтгэсэн, барилгын зураг төсөл, төсөвт суурийн дулаалгыг 10 см зузаантай шилэн хөвөн хавтангаар бүрэх, суурийн хананд 1/2-ын тоосго өрөх, суурийн бетон ханыг шохойн зуурмагаар гараар ердийн шавар хийсэн, 10 см

зузаантай шилэн хөвөн хавтан, полестрал хавтангаар, ариун цэврийн өрөөний хөнгөн цагаан дүүжин таазыг шохойн дүүжин таазаар тус тус өөрчилж хийсэн;

- Захиргаа, хотхоны барилгын интерьерын зураг төсөө боловсруулах, засварын ажил гүйцэтгэх (Түлхүүр гардуулах нөхцөлтэй) ажлын тендерийг 2020 оны 5 сард 787.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр зарлаж, Барилга угсралтын ажил гүйцэтгэх ЭТТ-2021/449 дугаартай гэрээг 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Гегатера Тех ХХК-тай 691.5 сая төгрөгийн дүнтэй байгуулж, 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаартай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр хүлээж авсан байна. Гэвч ажлын зураг төсөл, төсөв магадлалаар баталгаажаагүй тул төсөвт өртгийг хянан үзэх боломжгүй байна.
- Загийн усны хоолой гүний усны ордоос Эрдэнэс таван толгой ХК-ийн нүүрсний уурхай хүртэлх ус хангамжийн шугам хоолойн барилга угсралтын ажил гүйцэтгэх ЭТТ-2022/34, ЭТТ-2022/35, ЭТТ-2022/36 дугаар гэрээнүүдийг байгуулсан байна. Насос Станц №1 барилгын гадна ханын дулаалгыг галд тэсвэртэй чулуун хөвөнгөөр хийхийг хөөсөнцөр хавтангаар, металл дам нуруу болон баганыг зураг төслийн дагуу угсарч гүйцэтгээгүй, 1500 мЗ-ын усан сангийн байгууламжийн цутгамал төмөрбетоны ажлыг хийж гүйцэтгэхдээ цутгамал төмөр бетон бүтээц БНБД 52-02-05-ын 2. Хэвний, 3. Арматурын, 10. Орчны агаарын температур 25°C-дээш гарсан нөхцөлд бетон цутгах технологийг тус тус зөрчиж гүйцэтгэсэн.

Зураг 6. 1500 м.куб усан сангийн барилгын ажил болон бетон зуурмагт гарсан ан цавыг зургаар харуулбал,



- Хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардал:
 - Уурхайн ажилчдын хотхоны барилга 199.8 сая;
 - Цэвэрлэх байгууламж 20.4 сая;
 - Уурхайн захиргааны барилга 63.6 сая;
 - Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолой 3,442.6 сая;
 - Уурын зуухны барилга 19.0 сая;
 - Захиргаа, хотхоны барилгын интерьерын зураг төсөө боловсруулах, засварын ажил 11.6 сая, нийт 3,757.0 сая төгрөгийг зарцуулаагүй, захиалагчийн хяналт хэрэгжээгүй байна.
- Аудитаар Загийн усны хоолойн гүний усны ордоос Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нүүрсний уурхай хүртэлх ус хангамжийн шугам хоолойн барилга угсралтын ажил гүйцэтгэх ЭТТ-2022/34, ЭТТ-2022/35, ЭТТ-2022/36 дугаартай гэрээний хэрэгжилтэд захиалагчийн техникийн хяналтын хэрэгжүүлэх зардал 4,944.4 сая төгрөг боловч төслийн хэрэгжилтэд хяналт тавих гэрээ байгуулалтгүйгээр ажлын гүйцэтгэлд 3,442.6 сая төгрөгийн захиалагчийн техникийн хяналтын зардлыг оруулан баталгаажуулсанд төлбөрийн акт тогтоолоо.

Засгийн газрын шийдвэрийн дагуу охин компанийг байгуулсан ч тодорхой үр дүнд хүрээгүй 48.1 тэрбум төгрөгийг үргүй зарцуулсан байна

3.122 Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийг байгуулахаар шийдвэрлэн, Цанхийн зүүн хэсгийн MV-011943 дугаартай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг шилжүүлж, 300.0 сая төгрөгийг компанийн дүрмийн санд оруулсан байна.

3.123 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн судалгааны үндсэн дээр Хонконгийн хөрөнгийн биржид 2020 оны эхний хагас жилд багтаан үнэт цаас гаргахаар төлөвлөн Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийг байгуулсан ч тухайн биржээс тавьдаг сүүлийн гурван жил санхүүгийн тайлангаар ашигтай ажилласан, менежментийн ямар нэгэн өөрчлөлт ороогүй байх зэрэг шаардлагыг уг компани хангаагүй байна.

3.124 Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 146 дугаар тогтоолоор Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсоноор Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК татан буугдсан байна.

3.125 Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-д Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн үйл ажиллагааны орлогоос 2019 онд 26.7 тэрбум, 2020 онд Цанхийн зүүн уурхайн нүүрсний борлуулалтаас 129.9 тэрбум төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

3.126 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн судалгааны үндсэн дээр Хонконгийн биржид 2020 оны эхний хагас жилд багтаан үнэт цаас гаргахаар төлөвлөн УИХ-аар 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан ТБОНӨХБАУХАТХ-д оруулсан нэмэлт өөрчлөлтийн 3 дугаар зүйлийн 3.10-т *“Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй”* гэж заасны дагуу 2019-2020 онд нийт 40.3 тэрбум төгрөгийн 24 гадаад, дотоодын зөвлөх үйлчилгээ авахаар шууд гэрээ байгуулсан байна. Үүнээс төсөл хэрэгжих хугацаанд 21.2 тэрбум төгрөгийг гэрээний дагуу шилжүүлсэн бөгөөд Эрдэнэс-Тавантолгой ХК 2021-2022 онд 12.5 тэрбум төгрөгийг барагдуулж, 8 гэрээний 6.6 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

3.127 Засгийн газрын хуралдааны 27 дугаар тэмдэглэлийн 5 дахь хэсэгт⁴⁵ заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 27 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг хариуцлагыг Эрдэнэс-Тавантолгой ХК-д шилжүүлэх, мөн тогтоолын 2.1-д Эрдэнэс-Тавантолгой ХК болон Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийн хооронд нэгтгэх гэрээг байгуулах, 2.5-д Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийн гэрээ, хэлцлээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага болон компанийн баримт бичгүүдийг Эрдэнэс-Тавантолгой ХК-д шилжүүлэхийг хоёр компанийн Гүйцэтгэх захиралд даалгасан байна.

3.128 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 27 дугаар тогтоолыг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/160 дугаар тушаалаар Эрдэнэс-Тавантолгой ХК болон Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-уудын хооронд “Компанийг нэгтгэх гэрээ”-г 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байгуулж, 2020 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн

⁴⁵ Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК татан буугдаж байгаатай холбогдуулан тус компанийн хувьцаа гаргах бэлтгэл ажлын хүрээнд олон улсын санхүүгийн, татварын, аудитын, компанийн засаглалын, хуулийн зөвлөх компаниудтай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээний Монголын талын эрх үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүлээн авахыг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Гүйцэтгэх захирал (Б.Ганхуяг)-д даалгав.

баталгаажуулж, 2 компанийн хамтарсан ажлын хэсгийг байгуулан охин компаниас нийт 27.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 гэрээний тооцоог нягтлан ажлын баримт материалыг хүлээн авсан ч зөвлөхийн ажлын тайланг хүлээн авч, гэрээт ажлын гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгч, зөвлөхүүдээс нэхэмжилсэн үнийн дүнг бууруулах талаар санал тавьж, хэлэлцээр хийгээгүй байна.

3.129 Гадаадын хөрөнгийн биржид хувьцаа гаргах зөвлөх үйлчилгээний компаниудтай байгуулсан дээрх гэрээний заалтын⁴⁶ дагуу гэрээний үлдэгдэл 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 8 гэрээний 6.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.130 Засгийн газрын шийдвэрээр гадаадын хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах ажил 9 сарын хугацаанд үргэлжилж зөвлөх үйлчилгээ, албан хаагчдын цалин, гадаад томилолт зэрэг зардалд 48.1 тэрбум төгрөгийг⁴⁷ үргүй зарцуулсан байна.

3.131 Засгийн газар Эрдэнэс-Тавантолгой ХК гадаад хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах зорилтоо хэрэгжүүлээгүй байхад өмнөх шийдвэрийг үгүйсгэсэн шийдвэр гаргасан нь хөрөнгийг үргүй зарцуулах үр дагаварт хүргэсэн төдийгүй УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолын 1.6 дахь хэсэг хэрэгжээгүй тул дээрх асуудлыг аудитаар хууль хяналтын байгууллагад шилжүүлээ.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 1072 ширхэг хувьцааны нэрлэсэн үнийн тооцооллыг хийгээгүй нь Тавантолгойн бүлэг ордын үнэ цэнийг бууруулж байна

3.132 УИХ-ын 2010 оны 39, 2011 оны 57, 2012 оны 18, 2018 оны 73 дугаар тогтоолуудаар Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөлд үндэслэн төрийн өмчит компанийг байгуулах, тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэл хувийг Монгол Улсын иргэн аж ахуй нэгжид эзэмшүүлэх, 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шийдвэрийг тус тус гаргасан байна.

3.133 Дээрх тогтоолоор Засгийн газарт үүрэг даалгавар өгснөөр, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд төрийн өмчийн оролцоотой компанийг байгуулж, иргэдэд хувьцааг эзэмшүүлэх, “хишиг хувь” олгох зэрэг шийдвэрийг гаргаж, тухайн шийдвэрийг Эрдэнэс-Тавантолгой ХК хэрэгжүүлж ирсэн байна.

3.134 Гэвч 2010 оноос хойш УИХ-аас гаргасан шийдвэрүүдийг Засгийн газар, Эрдэнэс-Тавантолгой ХК хэрэгжүүлэхээр ордын үнэлгээг хийж, хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцсоны үндсэн дээр⁴⁸ компанийн хувьцааны нэрлэсэн үнийг тогтоохгүйгээр Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор нэгж хувьцааны үнийг 933 төгрөгөөр шууд тогтоож, иргэдэд эзэмшүүлсэн нь Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нийт үнэлгээг бодит бусаар тооцож, компанийн үнэ цэнийг бууруулах эрсдэлтэй байна.

3.135 Засгийн газрын 181 дүгээр тогтоолын 3 дахь хэсэгт иргэдэд эзэмшүүлсэн хувьцаа нь хоёр дахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд саналын эрхгүй, Засгийн газарт

⁴⁶ “Гэрээг дуусгавар болгох /цуцлах/ нөхцөл”-ийг судлан үзэхэд хэрэв Зөвлөх нь гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцалж болохоор заасан, мөн уг гэрээнүүдийг цааш үргэлжлүүлэлгүй зогсоож мөн тодорхой хэмжээгээр үйлчилгээг түр зогсоох буюу түдгэлзүүлсэн тохиолдолд зөвлөхөд мэдэгдлийг хүргүүлж Гэрээг цуцалж болно. Хэрвээ Захиалагч өөрийн эрх мэдлийн хүрээнд зохих үндэслэлийн дагуу энэхүү Гэрээг дуусгавар болгох шийдвэр гаргавал Зөвлөх нэхэмжлэх хүргүүлэх бөгөөд Захиалагч нь тухайн мэдэгдэл хүргүүлсэн өдөр хүртэлх Зөвлөхийн гүйцэтгэсэн ажлын тэнцүү хуваарилагдсан гүйцэтгэлийн дүнг төлнө гэж заасан бөгөөд хэрвээ маргаан гарвал Монголын Олон Улсын арбитраар шийдвэрлүүлэх гэрээний зохицуулалттай байна.

⁴⁷ Цалин, томилолт, бусад зардал 7.7 тэрбум төгрөг, зөвлөх үйлчилгээний зардал 40.3 тэрбум төгрөг.

⁴⁸ Хувьцааны үнэлгээг гаргах ерөнхий зарчим

нэрлэсэн үнээр нь худалдахаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэй байна. Гэтэл 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс өмнө төрөөд нас барсан 163,067, харьяатаас гарсан 13,529, нийт 176,596 иргэний ⁴⁹ хувьцааны өв залгамжлах, ногдол ашиг авах эрх Иргэний тухай хуулийн 515 дугаар зүйлийн 515.1-д “Өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өвлөгдөнө” гэж заасны дагуу хувьцааны эрхийг өвлүүлэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

3.136 Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөр тасалбар болгон гаргаж, Үндэсний аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/2022 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээллээр 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс өмнө төрөөд нас барсан 163,067, харьяатаас гарсан 13,529, нийт 176,596 иргэн хувьцаа эзэмшиж байна гэсэн бол Эрдэнэс-Тавантолгой ХК-д мөн дээрх хугацаагаар тасалбар болгон гаргасан 2023 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 01/364 дүгээр албан бичгээр ирүүлсэн мэдээлэлд Монгол Улсын харьяатаас гарсан 13,365 иргэн, нас барсан 90,284 иргэн хувьцаа эзэмшиж байгаа гэж тодорхойлжээ.

3.137 Цаг хугацааны хувьд нэмэгдэх өөрчлөлт гарахаар байхад 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс өмнө төрөөд нас барсан иргэний тоо 72,783 хүнээр, харьяатаас гарсан иргэний тоо 164 хүнээр, төрийн мэдэлд байгаа хувьцааны тоо 2,680 ширхгээр тус тус буурсан байна. Энэ нь бүртгэл алдаатай, мэдээллийг бодитой тайлагнахгүй байгааг харуулж байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төрийн мэдлийн ногдол ашиг болох 880.2 тэрбум төгрөг Ирээдүйн өв санд төвлөрөөгүй байна

3.138 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Ногдол ашиг хуваарилах тухай” 09 дүгээр тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2019 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахдаа нэгж хувьцааг 90.0 төгрөгөөр тооцож, төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ашгийг компанийн эзэмшиж байгаа үнэт цаасаар хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

3.139 Гэвч 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төрийн эзэмшлийн 9,779,874,440 ширхэг хувьцаанд тус компанийн 2019 оны цэвэр ашгаас Ирээдүйн өв санд ногдох 880,188,699,600.00 (найман зуун наян тэрбум, нэг зуун наян найман сая, зургаан зуун ерэн есөн мянга, зургаан зуун) төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

3.140 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 09, 20 дугаар тогтоолоор төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох 880.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг Монголын төмөр зам ТӨХК-ийн гаргасан хаалттай өрийн бичиг, Тавантолгой түлш ХХК-аас авах авлагаар төлж хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд холбогдох шийдвэрийн дагуу ногдол ашгийг үнэт цаас, мөнгөн хэлбэрээр олгох ТУЗ-ийн шийдвэр хэрэгжсэн байна.

Хүснэгт 35. Төрийн мэдлийн хувьцааны ногдол ашгийн зарцуулалт, тэрбум төгрөг

Он	Тавантолгой түлш ХХК	Монголын Төмөр зам ТӨХК
2018	18.6	
2019	111.8	357.0
2020		393.0
Нийт	130.4	750.0
		880.4

Эх сурвалж: Эрдэнэс Тавантолгой ХК

⁴⁹ 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаарх дүн

3.141 Энэ нь Засгийн газар “хууль дээдлэх”⁵⁰ зарчмыг хэрэгжүүлэхгүйг харуулж байгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ”, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 7.1.1-д ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг”, 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 7.1-д заасан эх үүсвэрийг энэ хуульд зааснаас бусад хэлбэрээр зарцуулахыг хориглоно”, 9 дүгээр зүйлийн 9.5-д “Сангийн эх үүсвэр, хөрөнгөөс 2030 он хүртэл энэ хуулийн 9.1-д зааснаас бусад хэлбэрээр зарцуулахыг хориглоно”, 12 дугаар зүйлийн 12.1.5-д “Сангийн хөрөнгийг зөвхөн олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан гадаад улсын нутаг дэвсгэрт арилжаалагдаж байгаа хөрөнгө оруулах хэрэгсэлд байршуулах”, 13 дугаар зүйлийн 13.2-т “Сан нь Засгийн газрын тусгай сан бөгөөд орлого, эх үүсвэр, хуримтлалын хувьд улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.142 Ирээдүйн өв сангийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд Монгол Улсын нэгдсэн төсвийг⁵¹ Төсвийн тухай хуулийн дагуу урд оны 11 дүгээр сарын 15-ны дотор баталдаг харин Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д “Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна” гэж зааснаар Ирээдүйн өв сангийн төсвийг төлөвлөх эрх зүйн зохицуулалт бүрэн бүрдээгүй байна. Тухайлбал,

- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2019 оны ашгаас ногдол ашиг хуваарилах шийдвэр ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Гэтэл Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль 2019 оны 11 дүгээр сарын 13-нд УИХ баталж, төсөвт төрд ногдох ногдол ашгийг тусгаагүй байна.

3.143 Ирээдүйн өв сангийн тухай хуулийн зорилго нь нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилготой тул төрийн аудитын байгууллагаас төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлээгүй, албан тушаалтанд хариуцлага тооцуулж, ирээдүйн өв сангийн хөрөнгийг нөхөн төлүүлэхээр дээрх асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэв.

Хүснэгт 36. Ногдол ашиг хуваарилах тооцоолол, төгрөг

	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нэгж хувьцаанд ногдох ашиг	Нийт ногдол ашиг	Үнэлгээ	Үнэлгээний дүн
Төр	1	9,779,874,440.0	90	880,188,699,600.0	933	9,124,622,852,520.0
Иргэн	2512768	2,213,060,522.0	90	199,175,446,980.0	933	2,064,785,467,026.0
ААН	486	7,065,038.0	90	635,853,420.0	933	6,591,680,454.0
Нийт		12,000,000,000.0		1,080,000,000,000.0		11,196,000,000,000.0

Эх үүсвэр: ҮЦХТТ, аудитын тооцоолол

3.144 Иргэдэд олгосон хувьцааны хувьд нэг иргэнд дунджаар 71,338.8 төгрөг олгосон нь байгалийн баялгийн өгөөжийг хүртэх боломжтой гэдгийг харуулж байгаа ч нөгөө талаар энэхүү ногдол ашиг өрхийн сарын дундаж орлогын 5 хувьтай тэнцэж өрхийн орлогод төдийлөн нөлөө үзүүлж чадахуйц дэмжлэг болоогүй байна.

⁵⁰ Үндсэн хуулийн 2 дугаар зүйл “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

⁵¹ Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

3.145 Иргэндээ байгалийн баялгийн ашгийг урт хугацаанд хүртээхийн тулд уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай явуулах төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд хөрөнгө оруулах нь зүйтэй байна.

Засгийн газрын тогтоолын дагуу үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлэх хөрөнгийг төлөвлөөгүй байна

3.146 Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний 2.11-д “Дотоодын үнэт цаасны зах зээлд өрийн бичиг “Эрдэнэс-Тавантолгой” бонд гаргаж, уул уурхай, зам, тээврийн салбарын томоохон бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг 2021 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх, Тавантолгойн 450 мВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх”-ээр заасан байна. Харин үнэт цаасаар татан төвлөрүүлэх хөрөнгийн 32.6 хувь буюу 650.6 тэрбум төгрөгийг гэрээт олборлогчдод өгөх өглөг, зээлийн дахин санхүүжилтэд зарцуулахаар төлөвлөсөн нь дээрх Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт 37. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн бондоор татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг зарцуулах төлөвлөгөө, тэрбум төгрөг, хувь

Төсөл хөтөлбөрүүд	Байршуулах дүн	Хувь
Дэд бүтцийн төслүүд:	972.7	48.8
Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн үлдэгдэл санхүүжилт	601.1	30.1
Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох холболтын төмөр замын санхүүжилт	65.4	3.3
450 МВт-ын хүчин чадалтай Тавантолгойн дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалтын санхүүжилт	306.2	15.4
Уурхайн хөгжүүлэлт:	371.0	18.6
Олборлолтын техник, тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилт	50.0	2.5
Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн бүтээн байгуулалтын санхүүжилт	65.3	3.3
Өмнөговь аймгийн Цогтцэций, Цогт-Овоо сумдын нутагт орших "Загийн усны хоолой" гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын урьдчилгаа санхүүжилт	16.2	0.8
Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний 10 сая тонны блокын санхүүжилт	123.5	6.2
Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших "Цагаанцав"-ын гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын санхүүжилт	116.0	5.8
Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт:	650.6	32.6
Гэрээт олборлогчдод өгөх өглөг	320.6	16.1
Өрийн бүтцийн шинэчлэлт	330.0	16.5
НИЙТ	1,994.3	100.0

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.147 Өндөр хүүтэй, богино хугацаатай бондын эх үүсвэрээр өрийг дахин санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь ирэх жилүүдэд төлөх өрийн эргэн төлөлтөөс дунд хугацаанд компанийн цаашдын үйл ажиллагаанд их хэмжээний ачаалал үзүүлэх эрсдэлтэйгээс гадна томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хугацаанд нь ашиглалтад оруулж, түүнээс хүртэх үр өгөөжийг бууруулах эрсдэлтэй байна.

Бонд гаргах зардалд нийт 8.0 тэрбум төгрөг зарцуулжээ

3.148 Эрдэнэс-Тавантолгой ХК нь ТУЗ-ийн 2021 оны 03, 06 дугаар тогтоолын дагуу холбогдох бэлтгэл ажлыг гүйцэтгэсний үндсэн дээр 769.0 тэрбум төгрөгийн бондыг төвлөрүүлсэн байна. Татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хүүд 2021 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хугацаанд 7.0 сая ам.доллар (20.0 тэрбум төгрөг), 117.5 тэрбум төгрөг буюу нийт 137.5 тэрбум төгрөг төлөх эргэн төлөлтийн хугацаатай байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хүснэгт 39. Үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн

Төрөл	Хэмжих нэгж	Татан төвлөрүүлсэн дүн	Нэрлэсэн үнэ	Хүү	Төлөх хүү	Хүү төлөх хугацаа
Төгрөгийн бонд	Тэрбум төгрөг	543.4	100.000.00 төгрөг	10.0%	487	2021.05.01
					48.3	2023.06.01
Ам.долларын бонд	Ам.доллар	149.1	100.00 ам.доллар	6.8%	5.5	2021.09.01
					1.5	2023.06.01
						2024.08.01
						2024.09.01
Төгрөгийн бонд	Тэрбум төгрөг	76.5	100,000.00 төгрөг	13.0%	20.5	2024.12.01
Нийт дүн	Тэрбум төгрөг	769.0			137.5	

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.149 Харин үнэт цаасны танилцуулга бэлтгэх, үнэт цаасыг санал болгох, үнийг тодорхойлох, хөрөнгө оруулагчдад тухайн үнэт цаасыг худалдах зэрэг ажлыг хамтран зохион байгуулахаар андеррайтерийн зөвлөх үйлчилгээ, хууль зүй, аудитын зөвлөх, хөрөнгийн үнэлгээний зөвлөх үйлчилгээний компаниудтай хамтран ажиллахаар гэрээ байгуулж нийт 5.8 тэрбум төгрөг, бондын арилжааны шимтгэлд 2.2 тэрбум төгрөг, нийт 8.0 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 40. Үнэт цаасны арилжаанд төлсөн шимтгэл, зөвлөх үйлчилгээний төлбөр, сая төгрөг

Огноо	Зардлын төрөл	Дүн		Төлбөр хүлээн авагч
		Сая төгрөг	Мянган ам.дол	
2021.04.12	Бондын арилжааны шимтгэл	372.6	61.4	Монголын хөрөнгийн бирж ХК
2021.04.12	Бондын арилжааны шимтгэл	17.7	2.9	ҮЦТХТ ХХК
2021.08.25	Бондын арилжааны шимтгэл	259.0		Монголын хөрөнгийн бирж ХК
2021.08.25	Бондын арилжааны шимтгэл	12.3	1.0	ҮЦТХТ ХХК
2021.08.25	Бондын арилжааны шимтгэл	224.3	20.9	Монголын хөрөнгийн бирж ХК
2021.11.11	Бондын арилжааны шимтгэл	10.7		ҮЦТХТ ХХК
2021.02.23 – 2021.03.09	Зөвлөх үйлчилгээний ажлын хөлс	5,822.8	86.2	
	Нийт дүн		8,057.9	

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.150 Мөн үнэт цаасны арилжаагаар төвлөрүүлсэн хөрөнгийн ажиллагааны зардалд ЭТТ-2019/780 дугаартай “Андеррайтерийн зөвлөх үйлчилгээний гэрээ”-ний нэмэлт, өөрчлөлтөөр андеррайтерт бондын урамшууллын төлбөр (success fee)-ийг бондын хөрөнгө төвлөрүүлэх бүрд тухайн өдрийн ханшаар тооцон төгрөгийн бондод 0.5-1.5 хувь, ам.долларын бондод 0.5-2.0 хувийн хүүг ажлын 5 хоногт багтаан төлөхөөр заасан байна. Энэ нь цаашид бонд нэмж гаргахад зардал өсгөх эрсдэлтэй байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн 42.0 хувь нь гэрээт олборлогчдод гэрээгээр гүйцэтгэсэн ажлын төлбөр барагдуулсан байна

3.151 Үнэт цаас гаргаж татан төвлөрүүлсэн хөрөнгийн 342.3 тэрбум төгрөгийг дэд бүтцийн төслийн санхүүжилтэд, 98.6 тэрбум төгрөгийг уурхайн хөгжүүлэлтэд, 319.6 тэрбум төгрөгийг гэрээт олборлогчийн ажлын хөлсөнд зарцуулсан байна.

Хүснэгт 41. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөг

Төсөл хөтөлбөрүүд	Байршуулах дүн	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
Дэд бүтцийн төслүүд:	972.7	342.3	35.2
Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн үлдэгдэл санхүүжилт	601.1	340.5	56.6
Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын холбох холболтын төмөр замын санхүүжилт	65.4	-	-
Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалтын санхүүжилт	306.2	1.8	0.6
Уурхайн хөгжүүлэлт:	371.0	98.6	26.6
Олборлолтын техник, тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилт	50.0	33.4	66.8
Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн бүтээн байгуулалтын санхүүжилт	65.3	65.2	99.8

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Өмнөговь аймгийн Цогтцэций, Цогт-Овоо сумдын нутагт орших "Загийн усны хоолой" гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын урьдчилгаа санхүүжилт	16.2	-	-
Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний 10 сая тонны блокын санхүүжилт	123.5	-	-
Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших "Цагаанцав"-ын гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын санхүүжилт	116.0	-	-
Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт:	650.6	319.6	49.1
Гэрээт олборлогчдод өгөх өглөг	320.6	319.6	99.7
Өрийн бүтцийн шинэчлэлт	330.0	-	-
НИЙТ	1,994.3	760.5	38.1

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.152 Гэрээт олборлогчдод төлөх өрийг хэлцэл хийж, төлбөрийн хуваарийн дагуу байгуулан барагдуулах боломжтой байсан ч үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн 42.0 хувь буюу 319.6 тэрбум төгрөгийг гэрээт олборлогчийн ажлын хөлсийг төлөхөд зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө"-ний 2.11-т бонд гаргаж, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээг санхүүжүүлнэ гэж заасантай нийцэхгүй байна.

3.153 Цаашид үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг зардал хэмнэх, үр өгөөжийг нь гаргах байдлаар зарцуулах шаардлагатай байна. Тухайлбал, эхний ээлжинд нэн тэргүүнд шаардлагатай усны эх үүсвэрийн төслийн Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших "Цагаанцав"-ын гүний усны ордоос ус татах шугам хоолой, Тавантолгой 450 МВт-ын цахилгаан станцын бүтээн байгуулалтад төлөвлөсний дагуу санхүүжүүлэх нь оновчтой байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, хийсэн дүн шинжилгээ аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын стратеги зорилт Тавантолгойн бүлэг ордын Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд бүрэн хэрэгжээгүй байна.
2. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн орлого, үйл ажиллагаанаас олсон ашгаар нийгмийн болон өөрийн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлж байгаа нь тус ордын техник, эдийн засгийн үндэслэлд заасан нэгдсэн төлөвлөлт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлд хүргэж, ордын үнэ цэнийг бууруулж байна.
3. Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгчээс удирдамж өгч, заавал биелүүлэх хэлбэрээр компанийн засаглалд оролцож, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ бие даан шийдвэр гаргах боломжийг хязгаарлаж, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчмуудыг зөрчиж байна.
4. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ордын геологи хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгө 2018-2022 онд 1.8-18.2 дахин багассан нь орд газрын нөөцийн нарийвчилсан суурь мэдээлэл хангалтгүйгээс уурхайг нэгдсэн байдлаар төлөвлөж, үйлдвэрлэлийг удирдах нөхцөл хангагдахгүй байх эрсдэлтэй байна.
5. Компанийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийн шинэчилсэн тайланд Цанхийн баруун хэсгийн геологийн нөөцөөс үйлдвэрлэлийн нөөцийг 182.0 сая тонноор илүү тооцож тооцооллын алдаа гаргасан нь уг нөөцийн тайланд үндэслэн тодотгох техник, эдийн засгийн үндэслэл бодитой хийгдэхгүй байх үр дагаварт хүргэжээ.
6. Эрдэнэс-Тавантолгой ХК Засгийн газрын тогтоолуудыг үндэслэн компанийн ирээдүйд олох орлого, төрд ногдох ногдол ашиг, үнэт цаас гаргах, орлогын өсөлтийг дайчлах замаар томоохон төслүүдэд 2019 онд ДНБ-ий 2.3 хувь, 2020 онд 2.8 хувь, 2021 онд 1.6 хувь, 2022 онд 1.9 хувьтай тус тус тэнцэх хэмжээний хөрөнгөөр санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуультай нийцэхгүй байна.
7. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны “Ногдол ашиг хуваарилах тухай” 09 дүгээр тогтоолоор компанийн 2019 оны цэвэр ашгаас төрийн эзэмшлийн 9,779,874,440 ширхэг хувьцаанд ногдох ашгийг компанийн эзэмшиж байгаа үнэт цаасаар хуваарилахаар шийдвэрлэж, 880.2 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлээгүй байна.
8. Тавантолгойн уурхайг цогц байдлаар ашиглахад шаардагдах усны эх үүсвэрийг шийдвэрлээгүйгээс цахилгаан станц, нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орох боломжгүйд хүрч, өндөр чанартай коксжих нүүрсийг сорчлон олборлож, коксжих чанар сул эдийн засгийн үр ашиг багатай “0” давхаргын болон эрчим хүчний нүүрсийг уурхайн ул хүртэл олборлоогүйгээс дотоод овоолго үүсэхгүй болж, Цанхийн баруун болон зүүн уурхайгаас нийт 1,630.9 сая м.куб хөрсийг гадаад овоолго руу зөөж байгаа нь ирээдүйд их хэмжээний үр ашиггүй нэмэлт зардал гарах үр дагавар үүсгэж, ордын үнэ цэнэ буурч, насжилт богиносж байна.

9. Цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлээгүйн улмаас ТЭЗҮ-д тусгасан өндөр хүчин чадалтай, цөөн тооны техникээр бус гэрээт олборлогчийн олон тооны хүчин чадал багатай техникээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа нь олборлолт, тээвэрлэлтийг иж бүрэн хяналттайгаар удирдах боломжгүйд хүргэж байна.
10. Эрдэнэс-Тавантолгой ХК ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн талбайн газар эзэмших эрхийг бүрэн аваагүйгээс ордын ашиглалтын талбайгаас иргэн, аж ахуйн нэгжид эзэмших, ашиглах, өмчлөх хэлбэрээр 4,937.8 га газрыг олгосон нь уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад саад учруулах, газрыг чөлөөлөхийн тулд их хэмжээний нөхөн төлбөр төлөх эрсдэлийг бий болгосон байна.
11. Нүүрс тээвэрлэлтийг хэт олон автомашинаар гүйцэтгүүлж, мөн Чойр, Ханги-Мандал, Шивээговь зэрэг чиглэлд зориулалтын бус замаар тээвэрлэлт хийснээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж, Говийн бүсийн эмзэг хөрс бүхий газар нутаг талхлагдаж, хөрсний элэгдэл их хэмжээгээр үүсгэж байна.
12. Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хооронд мэдээлэл солилцох протоколын дагуу талууд гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг цахим хэлбэрээр хагас, бүтэн жилээр харилцан солилцож зэрэгцүүлэлт хийж байгаа ч нүүрсний мэдээлэл зөрүүтэй илэрхийлэгдэж байгаа нь түүнд тавих хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрдээгүй, статистик мэдээ, тайланг Засгийн газарт хүргүүлж хэлэлцдэггүй байна.
13. Компанийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэл хангалтгүй, хууль, журмын дагуу уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулаагүй, хуримтлалын сан үүсгээгүй нь ирээдүйд уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийх зардал хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байна.
14. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс 2010-2022 онд уурхайн үйл ажиллагааг өргөжүүлэхээр 12 удаагийн шийдвэр гаргаж, орон тоо 2011 онд 243 байсан бол 2022 онд 1026 болж нэмэгдсэн ч бодит байдалд ТЭЗҮ-ийн дагуу үйл ажиллагааг өргөтгөх зорилтууд хэрэгжээгүй байхад тухайн орон тоог хэвээр хадгалж байгаа нь үйл ажиллагааны зардлыг өсгөж, ашигт ажиллагааг бууруулсан байна.
15. Компанийн дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаа жигдрээгүй, үйл ажиллагааны эрсдэлийг бодитой тодорхойлоогүйгээс удирдлага, зохион байгуулалтын түвшинд залилангийн эрсдэл өндөр байна.
16. Чалко трейдинг хонконг ХХК-тай 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан A/11/040 дугаар гэрээний 8.1-д нүүрсний үнийг 70.0 ам.доллар байхаар тогтоосон, хэлэлцээрт орж үнийг нэмэх арга хэмжээ авч байгаа ч Эрдэнэс-Тавантолгой ХК 2018-2022 онд Цанхийн зүүн уурхайгаас 14.4 сая тонн коксжих нүүрс борлуулахдаа бусад компанид коксжих нүүрс борлуулсан үнээс тонн тутамд 0.4-13.5 ам.доллараар доогуур үнээр борлуулахаар гэрээ байгуулснаар 107.3 сая ам.доллар буюу 306.2 тэрбум төгрөгөөр бага орлого олсон байна.
17. Нүүрс борлуулах гэрээний урьдчилгаа төлбөрт 2020-2022 онд нийт 5,179.4 тэрбум төгрөг авч, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,445.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий нүүрс ачуулах үлдэгдэлтэй байгаа нь дараагийн тайлант хугацааны валютын урсгалыг бууруулж, хил, гааль, тээвэрлэлтийн нэвтрүүлэх чадамжаас шалтгаалан өр төлбөр өсөхөд нөлөөлж байна.

18. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2020-2022 оны борлуулалтын 43.7 хувь нь төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг нүүрсээр барагдуулахад зарцуулагдаж байгаа нь тус компанийг мөнгөн хөрөнгийн дутагдалд оруулах эрсдэлтэй байна.
19. Эрдэнэс-Тавантолгой ХК уулын цулыг хөдөлгөх олборлолтын гэрээний үнийг Цанхийн баруун болон зүүн хэсэгт харилцан адилгүйгээр тогтоосноос Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогчийн зардлыг Цанхийн баруун уурхайн гэрээт олборлогчийн зардалтай харьцуулахад 2018-2020 онд 582.8 тэрбум төгрөгөөр илүү байгаа нь цаашид компанийн зардлыг бууруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.
20. Эрдэнэс-Тавантолгой ХК-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, зарим барилга байгууламжийн төсөвт өртгийг өндрөөр тооцсон, ажлын гүйцэтгэлийг бодитой хянаж баталгаажуулаагүйгээс ажлын тоо хэмжээг давхардуулсан, хийгээгүй ажилд санхүүжилт олгох зэргээр 5.9 тэрбум төгрөгийг илүү олгосон байна.
21. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эзэмшиж буй Тавантолгой ордод үнэлгээ хийж компанийн хувьцааны нэрлэсэн үнийг тогтоохгүйгээр Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор нэгж хувьцааны үнийг 933 төгрөгөөр шууд тогтоож компанийн үнэлгээ бодитой биш байна.
22. Иргэдэд эзэмшүүлсэн хувьцаа нь саналын эрхгүй, Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдахаас бусад аливаа хэлбэрээр захиран зарцуулах боломжгүй байгаа нь 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс өмнө төрөөд нас барсан 163,067, харьяатаас гарсан 13,529, нийт 176,596 иргэний эзэмшиж байсан хувьцааны өв залгамжлах, ногдол ашиг хүртэх эрхийг зөрчиж байна.
23. Засгийн газрын шийдвэрийн дагуу гадаадын хөрөнгийн биржид үнэт цаас гаргах зорилгоор Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийг байгуулж, үйл ажиллагаа явуулсан ч үр дүнд хүрээгүйгээс 48.1 тэрбум төгрөгийг үргүй зарцуулсан байна.
24. Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний 2.11-т бонд гаргаж, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээг санхүүжүүлнэ гэж заасны дагуу үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн 42.0 хувийг гэрээт олборлогчдын төлбөрийг барагдуулахад зарцуулж, Засгийн газар хяналтаа хэрэгжүүлээгүйгээс тогтоолын заалт зөрчигдсөн байна.

ЗӨВЛӨМЖ

Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилтуудын хэрэгжилт хангалтгүй, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлох боломж бүрдээгүй, уг бодлогын баримт бичиг хүчингүй болсныг анхаарч шинээр боловсруулах хөгжлийн зорилтот хөтөлбөрт салбарын хэрэгцээ, шаардлагыг бодитой тодорхойлох;
- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн үйл ажиллагаа төрөөс хэт хамааралтай байгаа нь техник, эдийн засгийн үндэслэл, нэгдсэн төлөвлөлтийн дагуу ордыг ашиглах боломжгүй байдалд хүргэж байх тул компанийн засаглалыг сайжруулах зохистой загвар, эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Засгийн газрын тогтоол, шийдвэрээр төрд ногдох ногдол ашгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлээгүй, АМНАТ болон ус бохирдуулсны төлбөрийг бүрэн төлөөгүй нь төсвийн орлогыг тасалдуулж, мөн Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлого, ирээдүйд олох орлогыг дайчлах замаар төсвөөс гадуур төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, улсын төсөв нэгдсэн байх зарчмыг алдагдуулж байгаад анхаарлаа хандуулна уу.

Аудитын илрүүлэлт, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газарт:

1. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн үйл ажиллагаа төрөөс хэт хамааралтай байгаагаас техник, эдийн засгийн үндэслэлд заасан нэгдсэн төлөвлөлтийн дагуу ордыг ашиглах боломжгүй байдалд хүргэж байх тул компанийн засаглалыг сайжруулах зохистой загвар, эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх;
2. Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшсэн иргэд, нэрлэсэн үнээр худалдаж авсан аж ахуйн нэгжүүдийн хувьцаа хоёр дахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл саналын болон аливаа хэлбэрээр захиран зарцуулах эрхгүй байгаа нь нийт хувьцааны 14.8 хувийг эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд өөрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх, эрхээ хамгаалах нөхцөлгүй болгож байх тул Компанийн тухай хуульд нийцүүлж жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

Эдийн засаг, хөгжлийн сайдад:

3. Нүүрсний салбар нь ДНБ-ий 10 хувь, нэгдсэн төсвийн орлогын 7-10 хувийг бүрдүүлж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын 14-28 хувийг эзэлж байгаагийн хувьд уурхай, эрдэс баялгийн биржийн тогтвортой ажиллагааг хангахад холбогдох бусад салбартай хамтран ажиллах;

Сангийн сайдад:

4. Гаалийн мэдээлэл солилцох, зэрэгцүүлэлт хийх үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлдэг байх тогтолцоог бий болгох;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:

5. Шинээр боловсруулах хөгжлийн зорилтот хөтөлбөрт салбарын хэрэгцээ, шаардлагыг бодитой тодорхойлж, олон талт хамтын ажиллагааг хангасан цогц төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

6. Бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээж, ордыг үр ашигтай, цогцоор нь ашиглах нөхцөл болсон ус хангамжийн асуудлыг шийдвэрлэж, баяжуулах үйлдвэр, цахилгаан станцыг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулахад анхаарч, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасны дагуу сорчлон ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн төлөвлөлт, удирдлагаар хангаж ажиллах;
7. Бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчид хүргэх, үр ашиггүй зардлыг бууруулахад чиглэсэн ачилт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг компани өөрийн нөөцөөр бий болгох;
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх болон компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдүүлж, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлж ажиллах;
9. Компанийн орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгах, хүний нөөцийг чадавхыг сайжруулах, шаардлага хангасан ажилтныг тогтвортой ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
10. Компанийн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр шууд тогтоосон нь ордын үнэ цэнийг бууруулж байх тул Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эзэмшиж буй Тавантолгой ордод үнэлгээ хийлгэх;

Эрдэнэс-Тавантолгой ХК-д:

11. Геологи хайгуулын ажлыг эрчимжүүлж, орд газрын нөөцийг бодитой тогтоох;
12. Бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээж, ордыг үр ашигтай, цогцоор нь ашиглах нөхцөл болсон ус хангамжийн асуудлыг шийдвэрлэж, баяжуулах үйлдвэр, цахилгаан станцыг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулахад анхаарч, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасны дагуу сорчлон ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн төлөвлөлт, удирдлагаар хангаж ажиллах;
13. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайн нөөцийн шинэчилсэн тооцооны нэгтгэл тайланд туссан Цанхийн зүүн, баруун уурхайн геологийн болон үйлдвэрлэлийн нөөцийн зөрүүг арилгаж, тодотгол хийх;
14. Газрын тухай хуульд заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эзэмшиж буй 8 тусгай зөвшөөрлийн 68,471.43 га талбайн эрхийн гэрчилгээг авч, гэрээ байгуулан, Улсын бүртгэлд бүртгүүлэх;
15. Хөрс тээвэрлэлтийн зардал өсөх шалтгаан болсон Цагаан-Овоо тосгоныг шинэ суурьшлын бүс рүү нүүлгэх арга хэмжээг цаг алдахгүй зохион байгуулж, ирээдүйд гарах үргүй зардлыг бууруулах;
16. Уулын цулыг хөдөлгөх ажлыг олборлолт, борлуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах;
17. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг шинэчлэх, уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажлын үр дүнд хяналт тавих, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах, хуримтлалын сан үүсгэх;

18. Евро-хан ХХК-тай 2019 онд байгуулсан ЭТТ-2019/782 дугаартай “Уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн сан үүсгэх” зөвлөх үйлчилгээний 799.4 сая төгрөгийн гэрээний үүргийн биелэлтийг тооцож, гэрээг дүгнэн, олгосон урьдчилгаа төлбөрийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах;
19. Эрдэнэс-Тавантолгой ХК-аас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт тавих зохиогч, захиалагчийн хяналтын үр дүнг тооцож ажиллах;
20. Мөнгөн урсгалыг зохистой удирдах замаар Үнэт цаас гаргаж татан төвлөрүүлсэн хөрөнгийн эргэн төлөлтийг эрсдэлгүй болгох;
21. Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг төлөвлөх, зураглах, геологи-геотехникийн нөхцөлүүдийг тооцох, өрөмдлөг тэсэлгээ, маркшейдер болон диспетчерийн хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, программчилсан удирдлагаар хангаж, үр нөлөөтэй хяналтын тогтолцоо бүрдүүлэх;

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2022.10.12 № 4/73
танай 2022.10.3 -ны № 4/45 -т

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн "Тайлангийн төсөлд санал авах тухай" н/45 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Төрийн аудитын байгууллага аудитын тайлангийн төслийг шалгадагч этгээдэд хүргүүлнэ" гэж, мөн зүйлийн 18.2-т "шалгадагч этгээд аудитын тайлангийн төсөлд өгөх саналаа 10 хоногийн дотод төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ" тус тус заасан байдаг.

Ийнхүү тус яамнаас хуульд заасны шалгадагч этгээдийн бүрэн эрхийн дагуу аудитын тайлангийн төсөлд албан ёсоор санал өгөх боломжгүй боловч зөвлөмжийн төсөлтэй танилцах явцад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хамаарах дараах асуудалд холбогдох тайлбар, мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх хүрээний асуудалд хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох, эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа, зохицуулалт хамаардаг. Иймд тайлангийн төсөл (67 дугаар хуудас)-д "Шинээр боловсруулах хөгжлийн зорилтот салбарын хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлж, олон талын хамтын ажиллагааг хангасан байдлаар боловсруулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах асуудлыг Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд даалгах нь зүйтэй байгааг анхаарах.

Мөн Эрдэс баялгийн бирж байгуулах зэргээр түүхий нүүрсийг боловсруулж, зах зээлийн үнэд хүргэж, борлуулах талаар нэгдмэл бодлогын арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хариуцаж хийх боломжтой бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа болохыг мэдэгдэх нь зүйтэй байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Б.ЗЯМБАДАГВА

1508 05 1796



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555
И-мэйл: info@erdeneestt.mn, Вэбсайт: www.ett.mn

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
Я.САРАНСҮХ ТАНАА**

2022.10.12 № 01/2184

танай _____-ны № _____-т

Г _____

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Н/45 тоот албан бичигтэй танилцлаа.

Танай байгууллагаас хийж гүйцэтгэсэн "Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2018-2021 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт барих бодлого, Ашигт малтмалын хуулиар хүлээсэн үүргийн биелэлт" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ГАНХУЯГ

Г470005673



Тайлангийн төсөлд өгөх санал, тайлбар

1. Тайлангийн төслийн 2.9, 2.10-д тусгагдсан асуудалд зөвлөмж авах саналтай. Цагаан-Овоо багийг нүүлгэн шилжүүлэх ажлыг Аймаг сумын засаг даргын тамгын газартай хамтран эрчимжүүлэх тухай зөвлөмж болгох; /тайлбарыг хавсаргав/

2. Тайлангийн төслийн 2.38, 2.39-д тусгагдсан хэсэгт зөвлөмж болгон өөрчлүүлэх саналтай. Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.12-д зааснаар Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд газар ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлнэ гэж заасныг хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, дүгнэлтийг Цогтцэций сумын Засаг даргын тамгын газар, Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүргүүлэн, баталгаажуулсан тохиолдолд газрын хянан баталгааны ажлын үр дүнг газрын нэгдмэл сангийн ангиллын тайлан, газар ашиглах, хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

3. Тайлангийн төслийн 2.48, 2.50, 2.51, 2.54-д тусгагдсан Компани хуульд заасан чиг үүргээ бүрэн биелүүлээгүй байгаагаас уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах... гэх асуудалд албан шаардлага өгөх гэснийг зөвлөмжөөр солих. Компанийн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаартай тушаалаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг Ажлын хэсэгт хүргүүлж, дүгнэлт гаргуулан, дүгнэлтээр өгсөн зөвлөмж, чиглэлийг дараа оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон төсөвт суулган тодорхой ажлуудыг шат дараалалтай хийсэн.

4. Тайлангийн төслийн 2.58-д тусгагдсан зөрчлийг хасуулах саналтай. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2014 оны А/04 дугаартай тушаалаар баталсан журмын дагуу зөрүү тооцон шаардлагатай мөнгийг компанийн төсөвт суулган, нэмж байршуулах асуудлаар төрийн захиргааны төв байгууллагаас тавьсан шаардлагын дагуу хуулийн хэрэгжилтийг хангаж, тухай бүр тооцоо нийлж ажиллаж байна.

5. Тайлангийн төслийн 2.70-д тусгагдсан зөрчлийн талаарх зөвлөмжид дараах агуулгыг тусгуулах саналтай. "Эрдэнэс Тавантолгой" ХК нь Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолын 2.2-т заасныг үндэслэн ашигт малтмалын ашиглалтын MV-011943 дугаартай тусгай зөвшөөрлийг тусгаарлах замаар байгуулсан охин компанидаа хөрөнгө оруулалт байдлаар шилжүүлсэн байна. Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн "8.2.1. эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад шилжүүлснээс олсон орлого" гэсэн заалтаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл борлуулсан орлогод албан татвар ногдуулах асуудал зохицуулагдаж байсан. Уг эрхийн шилжилт нь арилжааны зориулалттай бус гүйлгээ бөгөөд Засгийн газрын шийдвэрийн дагуу хийгдсэн хөрөнгө оруулалтын гүйлгээ тул уг гүйлгээнээс орлого олсон гэж үзэх үндэслэлгүй юм. Мөн хуулийн 8.2.2-т "хуулийн этгээд, түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар олсон орлого" гэсэн заалтын хувьд мөн тус гүйлгээнд хамаарахгүй бөгөөд энэхүү тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигч нь "төр" бөгөөд эцсийн эзэмшигч өөрчлөгдөөгүй байна. Энэхүү тусгай зөвшөөрөл шилжүүлсэн шийдвэр буюу "Эрдэнэс Тавантолгой майнинг" ХХК байгуулсан шийдвэр нь Засгийн газрын 2020 оны 146 дугаар тогтоолоор хүчингүй болсон бөгөөд энэ шийдвэр гарснаар ашиглалтын тусгай зөвшөөрөл "Эрдэнэс Тавантолгой" ХК-д буцаж шилжсэн.

6. Тайлангийн төслийн 2.75, 2.76-д тусгагдсан асуудалд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэгжилтийг ажилладаг бөгөөд компаниас шалтгаалсан зөрчил байхгүй тул зөрчлөөс хасах. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5.2-т заасан "Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал"-ыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталсан байна. Уг журам, аргачлалын дагуу мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргаж, уг дүгнэлтэд үндэслэн ус бохирдуулсны төлбөрийн ногдуулалтыг хийх эрх зүйн зохицуулалттай. Төрийн байгууллагууд хууль хэрэгжүүлэх журам, аргачлалыг хугацаанд батлуулаагүй нь улсын хэмжээнд хууль хэрэгжихгүй байх шалтгаан болсон. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлж, төлбөрийн ногдуулалтад хяналт тавих чиглэлээр Татварын ерөнхий газартай хамтран ажиллахаар хүсэлтээ хүргүүлсэн.

7. Тайлангийн төслийн 3.7, 3.8, 3.8-д заасан хэсэгт зөвлөмж гаргуулах саналтай. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьд Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5.1.3, 6.1.1, 21.2.3, Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 3.2, 7.4 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 367 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэн, "Эрдэнэс Монгол" ХХК-иас ирүүлсэн удирдамжийг баримтлан ажиллаж байна. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс ТЭЗҮ-д тусгагдсан нэгдсэн төлөвлөлтийн хүрээний төсөл, хөтөлбөрт компанийн орлого, ашгийг зарцуулахад анхаарч Монгол Улсын Их хурлын Үйлдвэржилтийн байнгын хорооны 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралд дээрх асуудлыг танилцуулан, хурлаас 6 дугаар тогтоол гарсан. Уг тогтоолд "Монгол Улсын Их хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 4 дэх хэсэгт заасан "Таван толгойн нүүрсний ордыг түшиглэж үйлдвэр, зам, дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулах, ашиглахад олон улсын жишиг стандартыг баримтлах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой уялдуулж, Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах, дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжид авч хэрэглэх нөхцөл, боломж хэрэгжүүлэх, 2018 оны 73 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл хөтөлбөрүүдээс 6 төрлийн төслийг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн бие даан болон бусад этгээдтэй хамтран хөрөнгө оруулан санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг дээрх 6 төрлийн төсөл хөтөлбөрийн хүрээнд хязгаарлах, эдийн засгийн үр ашигтай нөхцөлөөр санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон" байна.

8. Тайлангийн төслийн 3.27-д тусгагдсан төлбөрийн акт тогтоох хэсгийг хасуулах саналтай байна. Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх заалт нь захиргааны байгууллагын хувьд хэрэгжих заалт бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК нь захиргааны байгууллага бус төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд тул Хөдөлмөрийн тухай хууль /1999 оны/-ийн 141 дүгээр зүйлийн 141.3-д заасны дагуу ажлаас халагдаад шүүхийн шийдвэрээр буцаан томилогдсон ажилтнуудад нөхөн олговор олгосныг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т заасныг удирдлага болгон нэхэмжлэх хууль зүйн үндэслэлгүй. Түүнчлэн, Хөдөлмөрийн тухай хууль /1999 оны/-ийн 141 дүгээр зүйлийн 141.3-д заасны дагуу ажилтны эрүүл мэндэд гэм хор учирсан бол тухайн ажилтан өөрөө Иргэний хуулийн 498 дугаар зүйлд заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тусгайлан зохицуулсан бөгөөд мөн хуульд ажил олгогчийн зүгээс хохирлыг төлүүлэх талаар зохицуулаагүй тул уг асуудлыг зөрчил гэж үзэх үндэслэл бүрдээгүй байна.

9. Тайлангийн төслийн 3.39, 3.40-т тусгагдсан асуудлыг хасуулах саналтай байна. 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл 1,129.2 тэрбум төгрөг буюу 2.7 сая.тн орчим байсан нь 2020-2022 оны хугацаанд хилийн нэвтрүүлэлт нийт 700 гаруй өдрийн турш тээврийн хэрэгслийн хязгаарлалттай ажилласан (хил бүрэн хаасан өдрүүдийг оролцуулаад) болон Тавантолгой-Цагаанхад чиглэлийн тээвэрлэлт бүтэн 1 жилийн хугацаанд тэг зогссонтой шууд холбоотой. 2022 оны 05 дугаар сарын 25-нээс Тавантолгой-Цагаанхад чиглэлийн тээвэрлэлт энэ тоо 1.5 сая.тн буюу нийт гэрээлсэн хэмжээний 2.2%-д хүрч буурсан байдалтай байна.

10. Тайлангийн төслийн 3.41, 3.42-т тусгагдсан асуудлыг хасуулах саналтай байна. Нүүрсний үнийг бууруулсан нь зах зээлтэй холбон тайлбарлагдана. Өөрөөр хэлбэл 2019 оны эхний хагаст "Ex-Stock Ганцмод" нөхцөлтэй, 1010-1050 юань/тн буюу ойролцоогоор 153-160 ам.доллар/тн байсан нүүрсний үнэ 2019 оны 2 дугаар хагасаас буурч эхэлсэн бөгөөд 2020 оны 01 дүгээр сар гэхэд 860 юань/тн буюу 130 ам.доллар/тн болж 15-20% буурсан үзүүлэлттэй байсан. 2021 оны эхний хагас жил хүртэлх нүүрсний үнийг гэрээний анхны үнэтэй харьцуулсан нь учир дутагдалтай ба нэр дурдагдсан гэрээнүүдийн хувьд 2022 оны 2 дугаар улирлын үнэ нь 150.71 ам.доллар буюу гэрээний анхны үнээс даруй 100% (2 дахин) өссөн байгааг харгалзан үзэж 3.41, 3.42 заалтуудыг хасаж өгнө үү. /номлох баримт ирүүлэх/

11. Тайлангийн төслийн 3.45-д тусгагдсан хэсгийг хасуулах саналтай. Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогч компани 2011 онд олборлолтын хөлсийг үйл ажиллагааны бодит зардлын дүнгээр ам.доллараар ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу төлдөг байсныг 2015 оны гэрээний нэмэлт өөрчлөлтөөр нэгж үнэлгээтэй болгон өөрчилж 1 м.куб уулын цул хөдөлгөх зардлыг 4.39 ам.доллар /НӨАТ-гүй үнэ 3.99 ам.доллар/ -аар төлөхөөр тохиролцсон. 2015 оноос хойш жил тутамд тухайн 1 м.куб уулын цул хөдөлгөх зардлын дүнг Тохиролцооны гэрээ /Settlement agreement/-гээр баталгаажуулж гэрээний хэрэгжлэлтийн хугацаанд 1м.куб уулын цул хөдөлгөх зардлыг огт өөрчлөөгүй тогтмол 3.99 (НӨАТ ороогүй) ам.доллар байлгасан ба талуудын хооронд байгуулсан ЭТТ-2015/157 дугаартай гэрээний хугацаа 2021 оны 2 дугаар сарын 28-ны өдрөөр дуусгавар болсон. Ам.долларын ханшийн зөрүүгээр алдагдал хүлээх энэхүү гэрээг дуусгавар болгосноор 2021 оны Цанхийн зүүн уурхайд гэрээт олборлогч сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, 2021 оны 11 дүгээр сард Олборлолтын ажлын гэрээ байгуулснаар Цанхийн баруун уурхайн гэрээт олборлогч компаниудын 1м.куб уулын цул хөдөлгөх зардлыг ойролцоо түвшинд хүргэсэн нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг "Эрдэнэс Тавантолгой" ХК хэрэгжүүлж ажилласан болно.

12. Тайлангийн төслийн 3.66-д тусгагдсан хэсгийг хасах саналтай байна. Захиргааны ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн удирдлагатай 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн ЭТТ-2018/112 тоот гэрээ, 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн ЭТТ-2021/407 тоот гэрээний болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д заалтын хүрээнд нийгмийн хариуцлагын ажлуудыг санхүүжүүлж ажилласан. Энэхүү гэрээ болон бусад нийгмийн хариуцлагын ажлыг компанийн ТУЗ-өөр жил бүр хэлэлцүүлэн "Компанийн 2022 оны зарим хандив, тусламжийн жагсаалтыг батлах тухай" тогтоолыг батлуулан ажилладаг. Эдгээр нь нэг удаагийн бус "Эрдэнэс Тавантолгой" ХК Тавантолгойн орд газарт үйл ажиллагаа явуулах хугацаанд үргэлжилнэ.

13. Тайлангийн төслийн 3.73-т тусгагдсан зөрчилд тооцсон хэсгийг хасуулах саналтай байна. Үүнд:

а. "Энержи конвектер" ХХК-тай байгуулсан нэмэлт ажлын гэрээний 188.9 сая төгрөгийн зөрчил.

Тайлбар: Уурхайн захиргаа, хотхоны барилга угсралтын ажлын дэд бүтцийн ажлыг төлөвлөхдөө цэвэр усны нөөцийн саавыг төлөвлөөгүй. Харин тус төлөвлөлтийн алдаагаа засан "уурын зуухны зураг төсөл, төсөө боловсруулах, халаалтын халуун тогоо угсрах, барилгын ажил"-д Барилгын тухай хуулийн 14.1, 24.1, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1, Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаартай тушаалаар батлагдсан "Барилгын төсөө зохиох дүрэм"-ийн 3.2, 3.3 дах заалт, "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хий дүрэм"-ийн дагуу батлагдсан барилга угсралтын ажлын зураг төсөл, төсвийг үндэслэн Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан 262 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулан шийдвэрлэсэн. Тус гэрээ нь тендерийн хэмнэлтээр санхүүжигдээгүй болохыг холбогдох баримт нотлох тул.

б. "Лаки лайф" ХХК, "Голден лайт" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа ажилд давхардсан ажил, материалын үнийн зөрүү тооцоогүй олгосон үндэслэлээр дүгнэсэн 190.8 сая төгрөгийн зөрчил.

Тайлбар: "Лаки лайф" ХХК-ийн давхардсан ажил, материалын үнийн зөрүү болон "Голден лайт" ХХК-ийн давхардсан ажилд санхүүжилт олгоогүйг явцын гүйцэтгэлийн тайлангаар, "Голден лайт" ХХК-ийн материалын үнийн зөрүүг тооцолгүй олгосон боловч



тухайн компанитай хэлцэл хийж үлдэгдэл санхүүжилтээс хасаж тооцохор тохиролцсоныг холбогдох баримт нотлох тул,

с. "Гегатера тех" ХХК-аар гүйцэтгүүлсэн ажилд илүү санхүүжилт олгосон гэх 75.7 сая төгрөгийн зөрчил,

Тайлбар: Интерьерын ажлын зургийн үнэ нь "Зураг төслийн ажлын жишиг үнэ" БД 81-16-20-д байхгүй. Нэмэлт ажлыг дүйцүүлэн хассан. Зарим ажил нь барилга ашиглалтад ороогүй байгаагаас хүлээгдэж байгаа зэрэг нь холбогдох баримтаар нотлогдох тул,

д. Хотхоны цэвэрлэх байгууламжийн газар шорооны ажлын тоо хэмжээний зөрүү 37.8 сая төгрөгийн зөрчил,

Тайлбар: Барилгын угсралтын ажил гүйцэтгэгч компани 201.3 сая төгрөгийн төсвийг гүйцэтгэлийн зургийг үндэслэн хийж ирүүлсэн бөгөөд барилгын талбай дээрх хэмжилтийг үндэслэн газар шорооны ажлын зөрүү 30.7 сая төгрөгийг хасаж 170.5 сая төгрөгөөр төсвийг хянаж олгосныг холбогдох баримт нотлох тул дээрх зөрчлүүдийг хасуулах саналтай.

14. Тайлангийн төслийн 3.74-т тусгагдсан зөрчлийг хасуулах саналтай. Захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Барилга, дэд бүтцийн газрын инженерүүд нь мэргэшсэн болон зөвлөх зэрэгтэй болохыг холбогдох баримт нотлох тул, мөн "Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана" гэж заасныг зөрчсөн байна гэсэн нь захиалагчийн хяналтын зардлыг зориулалтын бусаар ашиглаагүй болно.

15. Тайлангийн төслийн 3.76-т тусгагдсан дараах зөрчлүүдийг хасуулах саналтай байна. Үүнд:

а. Хөндлөнгийн хяналтын зөвлөх үйлчилгээ аваагүй гэх 2,967.1 сая төгрөгийн зөрчил.

Тайлбар: Төслийн барилга угсралтын ажлын 70 орчим хувь нь хийгдээгүй байхад захиалагчийн хяналт хийх хөндлөнгийн зөвлөх үйлчилгээний 3 хувь буюу 2,9 тэрбум төгрөгт бүхэлд нь акт тавьсан байна. Төслийн эхний үе шат буюу гүйцэтгэх ажлын 30 гаруй хувьд компани өөрийн нөөц бололцоогоор захиалагчийн техникийн хяналт хийж хэмнэлт хийсэн. Захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээг үзүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа зохих, дүрэм журмын дагуу явагдаж байгаа болно.

16. Тайлангийн төслийн 3.94-д тусгагдсан асуудлыг хасуулах саналтай байна. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7-д "компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно." гэж заасны дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 09, 20 дугаар тогтоолоор төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох 880.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг "Тавантолгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн санхүүжилтэд зориулан бэлэн мөнгө хэлбэрээр, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн гаргасан өрийн бичгийг худалдан авахад зориулж буюу компанийн эзэмшиж байгаа үнэт цаас хэлбэрээр тус тус төрд хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд холбогдох шийдвэрийн дагуу санхүүжилт олгож, ногдол ашгийг үнэт цаас, мөнгөн хэлбэрээр олгох Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр хэрэгжсэн. Иймд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьд Ирээдүйн өв санд 880.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг давхар (дахин) төвлөрүүлэх үүрэггүй болно. Энэ талаар Сангийн яамны 2022 оны 03/6253 тоот албан бичгээр "... "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас 2020 оны төсвийн жилд Ирээдүйн өв санд ногдол ашиг төвлөрүүлэхээр төсөвлөөгүй тул "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2019 оны цэвэр ашгаас төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашгийг Ирээдүйн өв санд аливаа хэлбэрээр тусгаагүй, улмаар санхүүгийн тайланд "Эрдэнэс Тавантолгой" ХК-аас төвлөрүүлэх ногдол ашигтай холбоотой авлага бүртгэгдээгүй болно." гэж дурдсан тул "Эрдэнэс Тавантолгой" ХК нь 2019 оны ногдол ашгийг Ирээдүй өв санд төвлөрүүлэх үндэслэлгүй болно. /нотлох баримт ирүүлэх/

Дээрх саналуудыг хүлээн авч тайланд тусгахыг хүсье.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Эрдэнэс-Тавантолгой ХК-аас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ирүүлсэн 2 тайлбараас 1-ыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулж, 1 нь тайлангийн утга санааг дэмжсэн агуулгатай байна.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Саналыг хүлээн авч ЭЗХЯ-ны зөвлөмжид тусгалаа.
Тайлбар 2	Тайлангийн утга санааг дэмжсэн агуулгатай байна.


Эрдэнэс-Тавантолгой ХК-аас ирүүлсэн 16 саналаас тайлбарыг хүлээн авах боломжгүй байна. ЭХЗХ-оос ирсэн 1 саналыг хүлээн авсан болно.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Саналыг хүлээн авч, зөвлөмжид тусгалаа.
Тайлбар 2	Тайлангийн утга санааг дэмжсэн агуулгатай байна.
Тайлбар 3	Компани хуульд заасан чиг үүргээ бүрэн биелүүлээгүй тул уг асуудалд албан шаардлага өгөх гэснийг зөвлөмжөөр солих саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 4	Тайлангийн төслийн 2.58-д туссан асуудал нь компани Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд хуулийн дагуу жил бүр тооцож төвлөрүүлбэл зохих 958.5 сая төгрөгийг байршуулахаар байхад БОАЖЯ журмын заалтыг үндэслэн буцаалт хийж, дараа онд шилжүүлэн тооцож байгааг өөрчлөх, хууль болон журмын заалтыг нийцүүлэх, эрх зүйн орчныг тодорхой болгох талаар туссан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 5	Ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй, хуулиар зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг зөвлөмжид оруулсан болно.
Тайлбар 6	Тайлангийн утга санааг дэмжсэн агуулгатай байна.
Тайлбар 7	Саналыг хүлээн авч тайлангийн 3 дугаар бүлэгт тусгалаа.
Тайлбар 8	Эрдэнэс-Тавантолгой ХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төрийн өмчийн хуулийн этгээд гэдгээр Захиргааны ерөнхий хууль үйлчлэх тул саналыг хүлээн авах боломжгүй. Харин өмнөх аудитад 2018 оны дүн хамаарсан тул 2019-2021 оны дүнг хамруулав.
Тайлбар 9	Саналыг хүлээн авч ерөнхий мэдээлэл хэсэгт “Дэлхийн нийтэд шинэ төрлийн коронавируст халдвар тархаж, Гашуунсухайт хилийн боомтын үйл ажиллагааг хязгаарласнаар 2020-2022 онд 701 өдөр нүүрсний экспорт саатсан байна. Энэ нь Монгол Улсад орох валютын урсгал, компанийн борлуулалтад сөрөг нөлөө үзүүлж мөнгөн хөрөнгийн дутагдалд оруулж байсан байна.” гэж орууллаа.
Тайлбар 10	Тайланд зөвхөн гэрээний нэмэлт өөрчлөлтийн тухай агуулгыг оруулж өгсөн. Саналд тусгасан нэмэлт мэдээллийг тайланд тусгалаа.
Тайлбар 11	Тайлангийн утга санааг дэмжсэн агуулгатай байна.
Тайлбар 12	Ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй, компанийн нийгмийн хариуцлагын зардлыг олон улсын жишгийн дагуу зарцуулах талаар зөвлөмж өгсөн болно. Харин найруулгын өөрчлөлтийн саналыг хүлээн авлаа.


Тайлбар 13	Төлбөрийн акт тавих зөрчил тул саналыг хүлээн авах боломжгүй, Харин нийт үнийн дүн 302.5 сая төгрөг болсон тул тайланд өөрчлөлт оруулсан.
Тайлбар 14	Захиалагчийн хяналтыг сайжруулах албан шаардлага өгөхөөр тайланд нэмэлт өөрчлөлт орууллаа.
Тайлбар 15	Тайланд захиалагчийн хяналт хангалтгүй байгаад зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэхээр болов.
Тайлбар 16	Ирээдүйн өв сангийн тухай хуулиар төрд ногдох ногдол ашгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлэхээр заасан тул хуулийн хэрэгжилтийг хангаж дансанд төвлөрүүлэх шаардлагатай тул саналыг хүлээн авах боломжгүй.

ХАВСРАЛТУУД:


Хавсралт 1. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайн байршлын тойм зураг




Хавсралт 2. Хөрс тээвэрлэх зайг харьцуулсан байдал




Хавсралт 3. Тавантолгойн бүлэг ордын ойролцоо орших усны ундаргын байршил



Хавсралт 4. ТЭЗҮ-ээр төлөвлөсөн уурхайн хүрээг одоо үүсээд байгаа уурхайн хүрээ болон овоолготой харьцуулсан зураг



Хавсралт 5. ТЭЗҮ-ээр төлөвлөсөн уурхайн хүрээ рүү 400-450 метрээр цөмөрч орон “0”, “III”-ын давхаргын нүүрсийг дарсан овоолгын зураг



Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хавсралт 6. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ашиглалтын лицензтэй талбайд иргэн, хуулийн этгээдэд эзэмших, өмчлөх, ашиглах хэлбэрээр олгосон газар

№	Талбайн нэр	Лиценз дугаар	Нийт талбайн хэмжээ, га	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эзэмших эрхээ баталгаажуулсан		Иргэн, аж ахуйн нэгжид олгосон									
						Эзэмших эрхтэй			Өмчлөх эрхтэй		Ашиглах эрхтэй		Нийт иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Нийт олгосон газрын хэмжээ, га	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд эзлэх хувь
						Талбайн хэмжээ, га	Эзлэх хувь	Иргэн	Аж ахуйн нэгж	Талбайн хэмжээ, га	Иргэн	Талбайн хэмжээ, га			
1	Цанхийн зүүн уурхай	MV-16883	700.4	560.6	80.0		1	33.0		-		-	1	33.0	4.7
2		MV-11943	2,036.3	1,829.0	89.8	1	2	6.3		-		-	3	6.3	0.3
3	Цанхийн баруун уурхай	MV-16881	556.7	241.0	43.3	5	1	15.3	54	4.1	1	2.1	61	21.5	3.9
4		MV-16882	2,447.1	1,327.1	54.2		1	2.0	-	-	-	-	1	2.0	0.1
5	Бусад уурхайн талбай	MV-11953	12,864.5	129.4	1.0	11	34	1,786.9	6	0.3	3	6.5	54	1,793.7	13.9
6		MV-11954	22,901.4	900.6	3.9	14	6	94.4	10	0.8	7	165.8	37	261.0	1.1
7		MV-11955	23,813.1	2,809.7	11.8	18	55	2,820.4	-	-		-	73	2,820.4	11.8
8		MV-11956	3,151.9	100.8	3.2		1			-		-	1	-	-
Нийт талбайн хэмжээ			68,471.4	7,898.2	11.5	49	101	4,758.3	70	5.2	11	174.3	231	4,937.8	7.2

Хавсралт 7. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүчин чадал, олгосон санхүүжилтийн судалгаа, тэрбум төгрөг

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Төсөл		Уртын хэмжээ	Хүчин чадал	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт, оноор				Нийт олгосон санхүүжилт	Төслүүдийн хэрэгжилтийн товч мэдээлэл
		Эхлэх	Дуусах				2019	2020	2021	2022		
Уурхайн үндсэн үйл ажиллагаатай холбоотой												
1	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл	2019	2022	240 км	30 сая тонн	3,653.7	505.7	521.3	348.1	412.8	1,787.9	Төслийн нийт өртөг 1,282.0 сая ам.доллар, гэрээний дүн 1,005.6 сая ам.доллар, санхүүжүүлэгч нь Эрдэнэс-Тавантолгой ХК
2	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл	2019	2022	414.6 км	15 сая тонн	1,392.0	357.0	526.0	273.4	127.3	1,283.7	Төслийн нийт өртөг 1,392 тэрбум төгрөг, Эрдэнэс-Тавантолгой ХК-аас Монголын Төмөрзам ТӨХХК-аас гаргасан бондын санхүүжилт 750.0 тэрбум төгрөг, Зүүнбаян төмөрзам ХХК-д нэмэлт санхүүжилт 533.0 тэрбум төгрөг, нийт 1,283.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Засгийн газрын 2022 оны 434 дүгээр тогтоолоор Зүүнбаян Төмөрзам ХХК-ийг татан буулгаж, Эрдэнэс-Тавантолгой ХК тус компанийн нийт хувьцааны 66 хувийг эзэмших боломжгүй болсон тул олгосон санхүүжилтийн дүнгээр Монголын Төмөрзам ТӨХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулахаар ажиллаж байна.
3	Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян төмөр замыг холбох төсөл	2021	2022	21.09 км	30 сая тонн	218.0				218.0	218.0	Хэрэгжсэн
4	Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв	2021	2023		20 сая тонн	313.2			81.0	88.7	169.8	Төслийн нийт өртөг 313.2 тэрбум төгрөг. Санхүүжилтийн гүйцэтгэл 50.4 хувьтай.
5	Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл	2022	2024		10 сая тонн	956.1				95.6	95.6	Норинко Интернэйшнл Күүпэрэйшн болон Дади Инженеринг группийн түншлэл шалгарч ажлаа эхлүүлсэн.
6	Тавантолгой дулааны цахилгаан станцын төсөл	2022	2025		450 МВт	2,783.9			5.7	7.0	12.7	Засгийн газрын 2022.11.11-ний өдрийн 175 дугаар тогтоолоор Тавантолгой ДЦС ТӨХХК-ийн хувьцааны 30.0 хувийг Эрдэнэс-Тавантолгой ХК-д эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. Төслийг хэрэгжүүлэхэд нийт 808.2 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай.

7	Загийн усны хоолой гүний усны ордоос Тавантолгой уурхай хүртэлх шугам татах төсөл	2022	2023	Гол шугам 63 км, салбар шугам 30 км	63.6 л/с	118.3				84.2	84.2	Төслийн нийт өртөг 118.3 тэрбум төгрөг. Ажлын гүйцэтгэл 71.1 хувьтай.
8	Кокс-эрчим хүчний үйлдвэрийн төсөл	2023	2025		2 сая тонн	1,535.7				0.08	0.1	Кокс эрчим хүчний үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажил хийгдсэн.
9	Цагаан цавын ордоос ус ашиглах төсөл	2023	2024	281 км	800 л/с, 220 л/с зөв-шөөрөгдөх	630.4						- Цагаан цав гүний усны ордоос ус хангамжийн шугам хоолой татах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, БОНБНҮ хийлгэх ажлыг 2023 онд 1,719.6 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн
10	Гадаргын ус /Орхон Онги/	2026	2030	535 км	500/800 л/с	1,223.3						- Төслийн ТЭЗҮ, судалгааны ажлыг 2023 онд хийж эхлэхээр төлөвлөсөн
11	Метан хийн төсөл	2022										- Эрдэнэс-Тавантолгой ХК гүний уурхай байгуулахад нэн шаардлагатай төсөл
12	Үйлдвэрлэл технологийн паркийн ачилтын нэгдсэн төв											- ТНАЛТ төсөл хэрэгжсэнээр хэрэгжүүлэх шаардлагагүй болсон
Компанийн үйл ажиллагаатай хамааралгүй:												
13	Богдхан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилт	2022	2023	144 км	20 сая тонн	4,836.2				130.9	130.9	ҮАБЗ-ийн 2021.06.23-ны өдрийн мн/04 дугаар зөвлөмжөөр төмөр замын суурь бүтэц барих санхүүжилтийг Эрдэнэс-Тавантолгой ХК-тай хамтран шийдвэрлэх чиглэл өгсний дагуу Засгийн газрын 2021.07-ны өдрийн 206, 2021.11.17-ны өдрийн 353 дугаар дугаар тогтоолоор санхүүжүүлэх үүрэг хүлээлгэсэн.
14	Газрын тос дамжуулах хоолойн төсөл	2022		650 км	1.5 сая тонн/жил	1,367.5				62.9	62.9	Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК төслийн нийт хөрөнгө оруулалт болох 397.0 сая ам.долларыг санхүүжүүлэхээр байна. Хөрөнгө оруулалтаас хүртэх үр өгөөж тодорхойгүй.
НИЙТ ДҮН						19,028.4	862.7	1,047.3	708.2	1,227.5	3,845.7	

Хавсралт 8. Борлуулалтын гүйцэтгэлийн тайлангаарх борлуулсан нүүрсний тоо хэмжээг уулын ажлын тайлантай харьцуулсан байдал

Он	Исэлдсэн нүүрс (эрчим хүчний нүүрс)			Коксжих нүүрс			Уулын ажлын тайлангаарх тоо хэмжээ (мян.тонн)			Зөрүүгийн тоо хэмжээ (мян.тонн)		
	Хэмжээ, мян. тонн	Мөнгөн дүн, мян. ам.доллар	Жигнэсэн дундаж үнэ, ам.доллар	Хэмжээ, мян. тонн	Мөнгөн дүн, мян. ам.доллар	Жигнэсэн дундаж үнэ, ам.доллар	Коксжих нүүрс	Эрчим хүчний нүүрс	Нийт	Коксжих нүүрс	Эрчим хүчний нүүрс	Нийт
Цанхийн зүүн уурхай												
2018	593.5	8,949.7	15.08	7,855.7	513,518.3	65.37	7,855.7	593.5	8,449.2	(0.0)	0.0	0.0
2019	509.1	5,541.5	10.88	9,380.9	600,784.1	64.04	9,380.9	509.1	9,890.0	(0.0)	0.0	(0.0)
2020	216.6	2,164.3	9.99	7,907.9	400,215.3	50.61	7,909.5	221.1	8,130.6	1.6	4.5	6.1
2021	189.3	1,995.0	10.54	3,460.3	218,771.0	63.22	3,460.2	189.3	3,649.5	(0.1)	(0.0)	(0.1)
2022	889.7	31,670.7	35.60	6,641.3	784,154.0	112.70	6,652.9	889.7	7,542.6	11.6	0.0	11.6
Цанхийн баруун уурхай												
2018	783.8	11,848.7	15.12	3,857.0	267,229.3	69.28	3,857.0	784.0	4,641.0	0.0	0.2	0.2
2019	8.8	92.0	10.50	5,598.9	394,031.0	70.38	5,598.9	8.8	5,607.6	(0.0)	(0.0)	(0.1)
2020	131.5	1,265.5	9.62	3,642.9	187,918.5	51.58	3,642.9	131.4	3,774.3	0.0	(0.1)	(0.1)
2021	64.8	843.9	13.02	2,592.0	174,540.0	67.34	2,600.0	60.0	2,660.0	8.0	(4.8)	3.2
2022	1,648.7	61,051.7	37.00	2,267.5	268,381.9	118.40	2,267.5	1,649.0	3,916.5	0.0	0.3	0.3

Хавсралт 9. Гэрээт олборлогч компанийн төлбөрт 2021-2022 онд өгсөн нүүрсний тоо хэмжээ, үнийн дүн

Олборлогч компанийн нэрс	Гэрээний нэр	Гэрээний дугаар	Нүүрсээр нийлүүлсэн			Үүнээс: Хөнгөлөлт үзүүлсэн	
			Тоо хэмжээ, мян.тонн	Мөнгөн дүн, сая ам.доллар	Мөнгөн дүн, тэрбум төгрөгөөр	Тоо хэмжээ, мян.тонн	Мөнгөн дүн, сая ам.доллар
Хишиг Арвин Индустриал ХХК	Jidong Development (Hong Kong) International Limited & Khishig Arvin Industrial LLC	2021/713	130.5	17.7	50.4	130.5	1.5
Монгол Майнинг ХХК	Inner Mongolia Guoju Import and Export Trade Co.,ltd & Mongol Mining and Exploration LLC	2021/310	8.8	1.1	3.0	8.8	0.1
	Gobi Resources of Inner Mongolia & Mongol Mining Exploration LLC	2021/712	46.4	6.0	17.0	46.4	0.5
Моннис Майнинг ХХК	Monnis mining, Monblack Limited	2022/340	38.0	5.1	15.9	38.0	0.3
	Erlanhot Carlbore Energy Co.,ltd & Monnis Mining LLC	2022/180	20.7	2.5	8.0	20.7	0.2
	Inner Mongolia Houtung Energy Co., Ltd & Monnis maining	2022/522	22.2	3.0	9.7	22.2	0.3
ТиТиЖиВиСиӨү ХХК	E-Commodities Holdings Private limited and TTJVCo LLC	2021/708	3.6	0.5	1.5	67.8	0.4
	Auxin Holdings (Hong Kong) Limited & TT JV CO LLC	2021/707	36.3	5.0	14.2	36.3	0.2
	Auxin Holdings (Hong Kong) Limited & TT JV CO LLC	2022/114	84.5	11.1	32.7	84.5	1.2
	Glory Town Holdings Limited & TT JV CO LLC& Normount LLC	2022/311	359.5	46.9	148.2	359.5	5.2
Спешл Майнинг ХХК	Special Mining Serviices Llc, Monblack Limited	2021/711	39.4	5.5	15.5	39.4	0.3
Нийт дүн			789.9	104.3	316.0	854.1	10.3

Хавсралт 10. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Цанхийн зүүн уурхайн 2018-2022 оны уулын ажлын төлөвлөгөө, тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД		Хэмжих нэгж	2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он	
				Төлөв (тодотгол)	Гүйц	Төлөв (тодотгол)	Гүйц	Төлөв (тодотгол)	Гүйц	Төлөв (тодотгол)	Гүйц	Төлөв (тодотгол)	Гүйц
1	Нийт уулын цул		мян.м.куб	41,500.0	41,566.0	59,343.0	59,365.0	52,444.0	53,930.0	66,100.0	15,800.0	29,200.0	33,000.0
2	Хөрс хуулалт		мян.м.куб	36,600.0	36,046.0	52,200.0	51,500.0	47,017.0	47,612.0	57,600.0	12,919.0	25,400.0	27,900.0
3	Нийт уулын цүлд эзлэх хувь		хувь	88.2	86.7	88.0	86.8	89.7	88.3	87.1	81.8	87.0	84.5
4	Хөрс хуулалтын коэффициент		м.куб/тонн	5.0	5.0	5.0	5.0	6.0	5.0	5.0	3.0	5.0	4.0
5	Нийт олборлосон нүүрс		мян.м.куб	4,797.0	5,032.0	7,142.0	7,868.0	5,445.0	6,321.0	8,571.0	2,856.0	3,785.0	5,078.0
			мян.тонн	6,716.0	7,045.0	10,000.0	11,016.0	7,000.0	8,851.0	12,000.0	3,999.0	5,300.0	7,111.0
	5.1	Коксжих нүүрс	мян.тонн	5,987.0	6,610.0	8,550.0	9,624.0	6,467.0	8,008.0	11,000.0	3,871.0	3,710.0	6,800.0
	5.2	Эрчим хүчний нүүрс	мян.тонн	729.0	435.0	1,450.0	1,392.0	533.0	843.0	1,000.0	128.0	1,590.0	311.0
6	Эхний үлдэгдэл нүүрс		мян.тонн	-	2,342.0	-	937.8		2,063.8		2,784.1		3,133.7
	6.1	Коксжих нүүрс	мян.тонн		1,665.0		419.3		662.4		760.9		1,171.7
	6.2	Эрчим хүчний нүүрс	мян.тонн		677.0		518.5		1,401.4		2,023.2		1,961.9
7	Нийт борлуулсан нүүрс		мян.тонн	8,414.0	8,449.2	9,700.0	9,890.0	11,900.0	8,130.6	11,640.0	3,649.5	5,300.0	7,542.6
	7.1	Коксжих нүүрс	мян.тонн	7,787.0	7,855.7	8,600.0	9,380.9	11,550.0	7,909.5	10,800.0	3,460.2	3,710.0	6,652.9
	7.2	Эрчим хүчний нүүрс	мян.тонн	627.0	593.5	1,100.0	509.1	350.0	221.1	840.0	189.3	1,590.0	889.7
8	Оны эцсийн үлдэгдэл нүүрс		мян.тонн		937.8		2,063.8		2,784.1		3,133.7		2,702.1
	8.1	Коксжих нүүрс	мян.тонн		419.3		662.4		760.9		1,171.7		1,318.8
	8.2	Эрчим хүчний нүүрс	мян.тонн		518.5		1,401.4		2,023.2		1,961.9		1,383.2
9	Нийт борлуулалтын орлого		сая төг	1,078,916.0	1,331,537.0	1,346,753.0	1,634,572.0	840,887.0	1,149,014.0	820,442.0	648,212.0	1,734,306.0	2,513,637.0
	9.1	Уурхайн орлого	сая төг	1,078,916.0	1,296,224.0	1,346,272.0	1,613,570.0	840,309.0	1,129,376.0	819,994.0	627,210.0	1,714,497.0	2,439,653.0
	9.2	Бусад орлого	сая төг	-	35,312.0	481.0	21,003.0	578.0	19,638.0	448.0	21,002.0	19,809.0	73,984.0
10	Татвар ногдох орлого		сая төг	544,090.0	631,662.0	593,600.0	746,620.0	330,279.0	157,880.0	58,050.0	130,049.0	713,570.0	1,270,233.0
11	Нийт зардал		сая төг	534,827.0	699,875.0	753,153.0	887,952.0	510,608.0	991,133.0	762,393.0	518,163.0	1,020,737.0	1,243,403.0
	11.1	Үйлдвэрлэлийн зардал	сая төг	480,716.0	645,536.0	724,431.0	708,846.0	439,126.0	645,390.0	636,550.0	379,058.0	812,762.0	1,010,015.0
	11.2	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил (туслан гүйцэтгэгч)	сая төг	326,220.0	448,733.0	482,247.0	461,685.0	287,802.0	388,478.0	359,090.0	181,200.0	236,163.0	563,407.0
	11.3	Үйлдвэрлэлийн бус зардал	сая төг	54,111.0	54,339.0	170,100.0	179,106.0	71,482.0	345,743.0	125,843.0	139,105.0	207,975.0	233,389.0

12	Нийт улсын төсөвт төвлөрүүлсэн орлого	сая төг	283,304.0	322,580.0	336,920.0	437,264.0	215,915.0	312,510.0	228,601.0	241,018.0	515,782.0	885,301.0
13	Борлуулалтын орлогод эзлэх татвар	хувь	26.3	24.2	25.0	26.8	25.7	27.2	27.9	37.2	29.7	35.2
Эрдэнэс таван толгой ХК-ийн өртөг	1 м.куб уулын цулд ногдох зардал	төг/м.куб	12,887.0	16,838.0	12,692.0	14,958.0	9,736.0	18,378.0	11,534.0	32,795.0	64,604.0	42,582.0
	1 м.куб хөрс хуулалт	төг/м.куб	11,366.0	14,601.0	11,164.0	12,976.0	8,729.0	16,225.0	10,051.0	26,815.0	56,196.0	36,001.0
	1 тонн нүүрсний бүрэн өөрийн өртөг	төг/тонн	79,635.0	99,342.0	75,315.0	80,607.0	66,979.0	111,984.0	63,533.0	129,583.0	192,592.0	174,881.0
Туслан гүйцэтгэгч өртөг	1 м.куб уулын цулд ногдох зардал	төг/м.куб	7,861.0	10,796.0	8,126.0	7,777.0	5,488.0	7,203.0	5,433.0	11,468.0	14,947.0	19,295.0
	1 м.куб хөрс хуулалт	төг/м.куб	6,933.0	9,362.0	7,148.0	6,747.0	4,920.0	6,360.0	4,734.0	9,377.0	13,002.0	16,313.0
	1 тонн нүүрсний бүрэн өөрийн өртөг	төг/тонн	48,574.0	63,694.0	48,225.0	41,911.0	37,752.0	43,892.0	29,924.0	45,315.0	44,559.0	79,241.0
Нийт өртөгт туслан гүйцэтгэгчийн зардлын эзлэх хувь		Хувь	61.0	64.1	64.0	52.0	56.4	39.2	47.1	35.0	23.1	45.3

Хавсралт 11. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Цанхийн баруун уурхайн 2018-2022 оны уулын ажлын төлөвлөгөө, тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД		Хэмжих нэгж	2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он	
				Төлөв (тодотгол)	Гүйц	Төлөв (тодотгол)	Гүйц	Төлөв (тодотгол)	Гүйц	Төлөв (тодотгол)	Гүйц	Төлөв (тодотгол)	Гүйц
1	Нийт уулын цул		мян.м.куб	28,120.0	18,041.0	47,300.0	17,973.0	37,253.0	31,231.0	49,714.0	42,146.0	26,140.0	25,900.0
2	Хөрс хуулалт		мян.м.куб	24,910.0	15,223.0	41,600.0	14,300.0	33,000.0	28,218.0	44,000.0	38,963.0	23,150.0	22,900.0
3	Нийт уулын цулд эзлэх хувь		хувь	88.6	84.4	87.9	79.6	88.6	90.4	88.5	92.4	88.6	88.4
4	Хөрс хуулалтын коэффициент		м.куб/тонн	5.5	3.9	5.2	2.8	5.5	6.7	7.3	8.7	4.0	5.0
5	Нийт олборлосон нүүрс		мян.м.куб	3,214.0	2,818.0	5,714.0	3,690.0	4,285.0	3,013.0	4,285.0	3,182.0	4,714.0	3,000.0
			мян.тонн	4,500.0	3,945.0	8,000.0	5,127.3	6,000.0	4,219.0	6,000.0	4,455.5	6,600.0	4,196.4
	5.1	Коксжих нүүрс	мян.тонн	3,829.0	3,570.0	7,270.0	5,076.3	5,300.0	4,033.0	5,300.0	3,409.0	5,940.0	3,809.0
	5.2	Эрчим хүчний нүүрс	мян.тонн	671.0	375.0	730.0	51.0	700.0	186.0	700.0	1,046.5	660.0	387.4
6	Эхний үлдэгдэл нүүрс		мян.тонн		1,729.0	1,145.0	1,033.0	1,196.0	589.0	1,166.0	1,033.0	2,982.0	2,832.0
	6.1	Коксжих нүүрс	мян.тонн		1,023.0	802.0	736.0	799.0	213.0	710.0	605.0	1,544.0	1,377.0
	6.2	Эрчим хүчний нүүрс	мян.тонн		706.0	343.0	297.0	397.0	377.0	456.0	433.0	1,437.0	1,478.0
7	Нийт борлуулсан нүүрс		мян.тонн	4,500.0	4,641.0	7,800.0	5,607.6	5,100.0	3,774.3	5,100.0	2,660.0	6,500.0	3,916.5
	7.1	Коксжих нүүрс	мян.тонн	3,700.0	3,857.0	7,100.0	5,598.9	4,800.0	3,642.9	4,800.0	2,600.0	6,000.0	2,267.5
	7.2	Эрчим хүчний нүүрс	мян.тонн	800.0	784.0	700.0	8.8	300.0	131.4	300.0	60.0	500.0	1,649.0
8	Оны эцсийн үлдэгдэл нүүрс		мян.тонн		1,033.0		552.7		1,033.7		2,828.5		3,111.9
	8.1	Коксжих нүүрс	мян.тонн		736.0		213.4		603.1		1,414.0		2,918.5
	8.2	Эрчим хүчний нүүрс	мян.тонн		297.0		339.2		431.6		1,419.5		216.4
9	Нийт борлуулалтын орлого		сая төг	551,585.0	709,464.0	1,273,604.0	1,041,025.0	676,666.0	557,765.0	1,129,983.0	516,305.0	1,120,161.0	1,086,807.0
	9.1	Уурхайн орлого	сая төг	551,585.0	690,650.0	1,273,101.0	1,047,392.0	676,211.0	548,232.0	112,396.0	499,624.0	1,107,366.0	1,054,819.0
	9.2	Бусад орлого	сая төг		18,815.0	50,267.0	13,633.0	455.0	9,533.0	587.0	16,681.0	12,794.0	31,988.0
10	Татвар ногдох орлого		сая төг	233,328.0	400,054.0	696,982.0	639,360.0	235,521.0	87,755.0	237,918.0	29,698.0	407,085.0	517,645.0
11	Нийт зардал		сая төг	318,257.0	309,411.0	576,622.0	401,665.0	441,145.0	470,010.0	892,065.0	488,495.0	713,076.0	569,162.0
	11.1	Үйлдвэрлэлийн зардал	сая төг	318,257.0	280,458.0	549,026.0	296,901.0	383,622.0	419,181.0	721,300.0	316,121.0	581,745.0	467,588.0
	11.2	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил (туслан гүйцэтгэгч)	сая төг	197,715.0	167,808.0	374,472.0	156,499.0	222,588.0	290,092.0	351,720.0	87,977.0	198,045.0	253,694.0
	11.3	Үйлдвэрлэлийн бус зардал	сая төг	-	28,953.0	27,596.0	104,764.0	57,523.0	50,829.0	721,300.0	316,121.0	1,311,331.0	101,574.0

12	Нийт улсын төсөвт төвлөрүүлсэн орлого	сая төг	136,859.0	169,007.0	333,220.0	278,483.0	169,121.0	145,056.0	337,401.0	198,129.0	290,998.0	390,287.0
13	Борлуулалтын орлогод эзлэх татвар	хувь	24.8	23.8	26.2	26.8	25.0	26.0	29.9	38.4	26.0	35.9
Эрдэнэс таван толгой ХК-ийн өртөг	1 м.куб уулын цулд ногдох зардал	төг/м.куб	11,318.0	17,150.0	12,191.0	22,348.0	11,842.0	15,050.0	17,944.0	11,591.0	27,279.0	24,854.0
	1 м.куб хөрс хуулалт	төг/м.куб	10,026.0	14,472.0	10,722.0	17,781.0	10,490.0	13,598.0	15,882.0	10,715.0	24,159.0	21,975.0
	1 тонн нүүрсний бүрэн өөрийн өртөг	төг/тонн	70,724.0	78,420.0	72,078.0	77,753.0	73,524.0	111,416.0	148,677.0	109,641.0	108,042.0	135,515.0
Туслан гүйцэтгэгч өртөг	1 м.куб уулын цулд ногдох зардал	төг/м.куб	7,031.0	9,301.0	7,917.0	8,707.0	5,975.0	9,289.0	7,075.0	2,087.0	7,576.0	9,795.0
	1 м.куб хөрс хуулалт	төг/м.куб	6,229.0	7,849.0	6,963.0	6,928.0	5,293.0	8,393.0	6,262.0	1,930.0	6,710.0	8,661.0
	1 тонн нүүрсний бүрэн өөрийн өртөг	төг/тонн	43,936.0	42,530.0	46,809.0	30,294.0	37,098.0	68,766.0	58,620.0	19,746.0	30,007.0	60,403.0
Нийт өртөгт туслан гүйцэтгэгчийн зардлын эзлэх хувь		Хувь	62.1	54.2	64.9	39.0	50.5	61.7	39.4	18.0	27.8	44.6